

Жилийн тайлан
2014





Эрдэнэт хүмүүн | **Эх дэлхий** | Эрүүл ашиг

Жилийн тайлан

2014

ГАРЧИГ

Хэтийн зорилт, эрхэм зорилго, үнэт зүйлс	
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргын мэндчилгээ	6
ХасБанкны Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	8
2014 оны онцлох үйл явдлууд	10
2014 оны санхүүгийн үзүүлэлт	11
Тэнгэр Санхүүгийн Нэгдлийн Хувьцаа эзэмшигчдийн бүтэц	13
Төлөөлөн Удирдах Зөвлөл	14
Удирдлагын баг	16

ГУРВАН ТУЛГУУРТ ЭРХЭМ ЗОРИЛГО

ЭРДЭНЭТ ХҮМҮҮН

Иргэдийн Банкны үйлчилгээ	26
Цахим Банкны үйлчилгээ	30
Бизнесийн Банкны үйлчилгээ	31
Мэдээлэл технологийн удирдлага	34
Иргэдэд санхүүгийн боловсрол олгох хөтөлбөр	35
Хүний нөөц	36

ЭХ ДЭЛХИЙ

Эко банкны үйл ажиллагаа	40
2014 оны нийгмийн хариуцлага	41
Планет Рэйтингийн үнэлгээ	42
ХасБанкны 2014 оны шагналууд	43

ЭРҮҮЛ АШИГ

Макро эдийн засаг	46
Банкны сектор	47
Санхүүгийн үзүүлэлт	48
Эрсдлийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт	49
Олон улсын хөндлөнгийн үнэлгээний байгууллагын үнэлгээ	52
Дотоод аудит	53

ТУЛХТАЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ТҮНШЛЭЛ

Тулхтай хөгжлийн төлөөх түншүүд	56
Хөрөнгө оруулагчид	58
Корреспондент харилцаатай банкууд	59

КОМПАНИЙ ЗАСАГЛАЛЫН ТАЙЛАН

62

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

70

ХЭТИЙН ЗОРИЛТ, ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮНЭТ ЗҮЙЛС



ХЭТИЙН ЗОРИЛТ

Бид үнэ цэнэтэй санхүүгийн цогц үйлчилгээгээрээ бүхий л түвшний харилцагчдад таашаагдсан, шилдэг бизнесийн үйл ажиллагаатай банк болохын зэрэгцээ бичил санхүүгийн салбар дахь манлайллаа хадгалах болно.

ЭРХЭМ ЗОРИЛГО

ХасБанк нь эх дэлхий, эрдэнэт хүмүүн, эрүүл ашгийг эрхэмлэсэн санхүүгийн зах зээлд манлайлах үйлчилгээтэй, тэргүүлэгч байгууллага байна.

ҮНЭТ ЗҮЙЛС

Бид хэтийн зорилт, эрхэм зорилгодоо хүрэхийн тулд дараах зүйлсийг өдөр тутмын үйл ажиллагаандаа эрхэмлэн ажиллана. Үүнд:

Манлайлах эрч хүч

Нийгмийн хариуцлага

Бүх түвшний харилцагч

Бүтээлч сэтгэлгээ

Харилцагч төвтэй үйл ажиллагаа

Мэргэжлийн өндөр түвшин

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ

Ч.ГАНБОЛД
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга



Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, харилцагчид, түнш байгууллагууд болон манай ажиллагсадаа,

Өмнөх жилүүдийн тайланд мэндчилгээгээ бичихэд хялбар байлаа. Өнгөрсөн оноос эхлэн эдийн засгийн орчин муудаж, санхүүгийн салбарт бүхэлдээ хүнд жил болж өнгөрлөө. Үндэсний нийт бүтээгдэхүүний өсөлт өмнөх жилийн 12 хувиас 7.8 хувь болж буурлаа. Инфляцийн түвшин 11 хувьд хүрч, үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшийн уналт америк доллартай харьцуулахад 14 хувьд хүрлээ. Урьд нь, жилийн 80 хувьтай байсан банкны салбарын өсөлт бүтэн жилийн хугацаанд зөвхөн 8 хувь боллоо. Засгийн газар болон Монголбанкнаас санаачлан хэрэгжүүлсэн эдийн засгийг эрчимжүүлэх хөтөлбөр зогсч, мөнгөний хатуу бодлого барьсан нь хадгаламжийн зах зээлийн өрсөлдөөнийг ихээр эрчимжүүллээ. Эдийн засгийн уналт манай үйл ажиллагаанд ч багагүй нөлөөлж, бид төсөөлж байснаас хүнд нөхцөл байдалтай тулгарлаа. Өсөлтийн гэхээсээ илүү тогтвортой байдал, үр ашиг, зээлийн эрсдэлдээ бид анхаарах шаардлагатай болов.

Хэдийгээр эдийн засаг таагүй байсан хэдий ч ХасБанк цаг алдалгүй шуурхай арга хэмжээнүүд авсны үр дүнд байгууллагын тогтвортой байдал, үр ашгийг өрсөлдөхүйц түвшинд хадгалж чадсаныг дурьдахад таатай байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн (ТУЗ) зүгээс санаачлан хэрэгжүүлсэн банк болон толгой компанид хийсэн бүтцийн өөрчлөлтийн оновчтой, зоримог, шуурхай алхамууд үүнд мөн зохих хувь нэмэр оруулсныг цохон тэмдэглүүштэй. Эдийн засаг, бизнесийн орчны хандлага, банк болон ТСН (ТэнГэр Санхүүгийн Нэгдэл) ХХК-ийн стратеги, үйл ажиллагаанд үзүүлэх үр нөлөөг ТУЗ 2014 оны 7 дугаар сард хийсэн ээлжит бус хурлаар хянаж үзээд толгой компанийн үйл ажиллагааг банк руу чиглэсэн байдлаар өөрчлөхөөр шийдвэрлэсэн юм. Ингэснээр ТСН ХХК-ийг үйл ажиллагаа явуулдаггүй толгой компанийн хэлбэрт шилжүүлэн, хүний нөөцийг нь банкин дээр төвлөрүүлж ашиглах, үйл ажиллагааны зардлыг 10 хувиар бууруулах, өсөлтийн зорилтуудаа эргэн харах, эрсдэл даах чадвараа нэмэгдүүлэх, удирдлагын бүтэц зохион байгуулалтын шинэчлэл хийх зорилтыг тавьж, хэрэгжүүллээ.

Үүний үр дүнд, банк бизнесийн өсөлтийн зорилтоо биелүүлж, өнгөрсөн жил актив 2.1 их наяд төгрөг, зээл 1.4 их наяд төгрөгт тус тус хүрлээ. Энэ нь өмнөх жилтэй харьцуулбал актив 15 хувь, зээл 30 хувиар өссөн үзүүлэлт юм. Том зээлийн өсөлтийг хязгаарлах, эрсдлийн нөөцөө шуурхай нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлсний улмаас цэвэр ашиг болон хувь нийлүүлэгчдийн хөрөнгийн өгөөжийн түвшин өмнөх жилээс 2 дахин буурч цэвэр ашиг 11.7 тэрбум төгрөг, өөрийн хөрөнгийн өгөөж 9.0 хувьтай байв.

Удирдлагын шинэчлэлийн хүрээнд ТСН ХХК нь зөвхөн Гүйцэтгэх захиралтай байх ба энэхүү албан тушаалтан давхар банкны Гүйцэтгэх захирал байна гэсэн ТУЗ-ийн шийдвэрийг үндэслэн ХасБанкны Гүйцэтгэх захирлын ажлыг сүүлийн гурван жил хагасын хугацаанд хашсан Дүгэрсүрэнгийн Бат-Очирын оронд Магваны Болд ХасБанкны шинэ Гүйцэтгэх захирлаар томилогдов. ХасБанкны төлөө нөр их хөдөлмөр, хичээл зүтгэл гаргаж ажилласан Д.Бат-Очирт чин сэтгэлийн талархал дэвшүүлж байна. Түүний удирдлагын дор ХасБанк системийн банк болж, активын хэмжээгээ 3.9 дахин өсгөж чадсанаас гадна зах зээл дээрх эзлэх хувиа өсгөж, өрсөлдөх чадвар болон байгууллагын чадавхийг бэхжүүлсэн юм. Мөн банкны үндсэн системийг шинэчлэх, цахим сувгийн хараат бус байдлыг хангах, банкны шинэчлэл зэрэг ирээдүйн өсөлтийг дэмжих хэд хэдэн чухал төслүүдийг эхлүүлсэн билээ. ХасБанкны анхны ажилтнуудын нэг болох Д.Бат-Очир банкны дээд удирдлагын багт үйл ажиллагаа болон санхүүгийн удирдлагыг хариуцахын зэрэгцээ байгууллагын чадавхийг бүрдүүлэхэд чиглэж эхлүүлсэн өндөр ач холбогдол бүхий төслүүдийн явцын удирдлага, хяналтыг тодорхой хэмжээнд хариуцан ажиллахаар шийдвэр гаргасныг тэмдэглэхэд таатай байна.

ХасБанкны удирдлагын баг Ганибалын Амартүвшин болон Ганзоригийн Зул нарын мэргэжлийн хүмүүсээр эгнээгээ бэхжүүллээ. Г.Амартүвшин корпорейт болон бизнесийн банк хариуцсан Ерөнхийлөгч, Г.Зул хүний нөөц хариуцсан Дэд ерөнхийлөгчөөр тус тус томилогдлоо. Эдгээр шинэ томилгоо нь ХасБанкыг системийн банк болгон төлөвшүүлэх ажилд бодитой хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

2014 онд гол анхаарал маань сайн засаглалыг хэрэгжүүлж өргөжүүлэхэд чиглэгдсэн хэвээр байлаа.

Өнгөрсөн жил ТУЗ-ийн бүрэлдэхүүнд ч багагүй өөрчлөлтүүд гарлаа. 2005 оноос эхлэн манай жижиг хувьцаа эзэмшигч болох Нээлттэй Нийгэм форумаас сонгогдон ажиллаж байсан Пэрэнлэйн Эрдэнэжаргал болон хараат бус гишүүнээр 2012 оноос хойш ажилласан Биндэрьяагийн Саран өөрсдийн хүсэлтээр гишүүнээс чөлөөлөгдлөө. П.Эрдэнэжаргал болон Б.Саран нь ажиллах хугацаандаа ТУЗ-ийн төлөвшил, үйл ажиллагаанд өөрсдийн мэргэжлийн ур чадвар, идэвхтэй оролцоо, зарчимч байр сууриараа үнэтэй хувь нэмэр оруулсан билээ.

ТУЗ болон удирдлагад асар их дэмжлэг үзүүлж манай ТУЗ-д чухал болох жендерийн тэнцвэртэй байдал эмэгтэйчүүдийн төлөөллийн жинхэнэ үлгэр жишээ болж чадсан эдгээр гайхалтай хатагтай нарт талархал дэвшүүлж байна.

Өнгөрсөн онд ТУЗ хоёр шинэ захиралтай болсон. Монголын бизнес эрхлэгчдийн дунд мэргэжил, мэдлэгээрээ хүлээн зөвшөөрөгдсөн Баатарын Батсайхан нь үйл ажиллагааны орчин, бизнес хөгжлийн өдөр тутмын мэдлэгтэйн хувьд бидэнд шинэ хэтийн төлөв авчирсан шинэ захирлаар томилогдлоо. Олон улсад ажилласан арвин их туршлагатай банкны мэргэжилтэн Жэймс Стэнт хараат бус захирлаар орж ирсэн явдал сайн засаглал хийгээд нээлттэй, мэргэжлийн шийдвэр гаргахын төлөө бидний үйлсэд ач холбогдол бүхий алхам байлаа.

Энэ завшааныг ашиглан 2014 онд дэвшүүлсэн зорилго зорилтондоо хүрэхийн тулд хичээл зүтгэлтэй сайн ажилласан банкны нийт ажиллагсаддаа юуны өмнө талархал дэвшүүлж байна. ХасБанкны нэр хүндийг өндөрт өргөн банкны үйлчилгээг чанартай хүртээмжтэй хүргэхийн төлөө шаргуу ажиллаж буй орон нутаг дахь хамт олондоо онцгой талархал дэвшүүлье. Эдийн засгийн хүндрэл бэрхшээлийг үл харгалзан, биднийг өөрсдийн итгэлт банкаараа сонгон, үргэлж хамт байдаг бүх харилцагч, зээлдэгч, зээлдүүлэгч болон бизнесийн түншүүддээ баярлалаа. Бидний амжилтанд та бүгдийн хувь нэмэр, итгэл найдвар асар чухал үүрэгтэй бөгөөд бидний хийж буй болгон та бүгдийн сайн сайхны төлөө гэдгийг дахин хэлмээр байна.

Эцэст нь ТСН-ийн бүх түвшинд шинэчлэлийг хэрэгжүүлэх зоримог шийдвэр гаргасан ТУЗ-ийн болон удирдлагын гишүүдэд мөн биднийг ойлгож дэмжсэн хувьцаа эзэмшигчиддээ талархал дэвшүүлж байна.

2014 оноо үдэж, чамгүй сорил бүхий 2015 онтой золгож буй энэ мөчид нийт хувьцаа эзэмшигчид, ТУЗ болон удирдлагын баг та бид бүгдээрээ нэг цул байж аливаа хямралаас боломжийг хайж тэрхүү боломжоо хамтын үнэ цэнэ болгон хувиргах замаар өмнөө тохиолдох ямар ч хүндрэл бэрхшээлийг хамтдаа даван туулж чадна гэдэгт илтгэлтэй байгаагаа илэрхийлэхийг хүсч байна.

Хүндэтгэсэн,



Чулууны Ганболд
ХасБанк болон ТэнГэр Санхүүгийн нэгдэлийн
Төлөөлөн Удирдах зөвлөлийн дарга

ХАСБАНКНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

М.БОЛД
ХасБанкны Гүйцэтгэх захирал



Эрхэм Танд ХасБанкны 2014 оны тайланг хүргүүлж байгаадаа баяртай байна.

Өнгөрөгч онд гадаад худалдааны тэнцлийн алдагдал нэмэгдэж, гадаадын хөрөнгө оруулалт буурснаас үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн ам.доллартай харьцах ханш суларч түүхэн доод түвшинд хүрсэн төдийгүй эдийн засгийн өсөлтийн хурд саарч эдийн засгийн орчны эрсдэл өндөр хэвээр үргэлжилсэн жил боллоо.

Гадаад орчны энэхүү эгзэгтэй үед ХасБанк нь байгууллагын үр ашигтай, тогтвортой хөгжлийн зорилтууддаа хүрэхэд чиглэсэн багагүй ажлыг хийж чамлалтгүй үр дүнд хүрэв. Компанийн засаглал, ил тод байдал, эрсдэлийн удирдлагаар тэргүүлэгч байхын зэрэгцээ оны эцсийн байдлаар нийт активын хэмжээгээ 2.1 их наяд төгрөгт хүргэсэн нь өмнөх оныхтой харьцуулбал 15 хувиар өссөн үзүүлэлт байлаа. Нийт зээлийн багц 1.4 их наяд төгрөг болж 30 хувиар нэмэгдэв. Үүний зэрэгцээ бид харилцах хадгаламжийн өсөлтөөрөө тэргүүлэгч байж, нийт системийн өсөлтийн 1/6-ийг дангаараа бүрдүүллээ. Зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах сангийн хэмжээгээ 2.6 дахин нэмэгдүүлж 48 тэрбумд хүргэсэн нь нийт чанаргүй зээлийн 95 хувийг даах хүрэлцээтэй болгож байгаа юм. Ингэснээр 2014 онд банк 12 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллалаа.

Банкны шинэчлэл төслийн хүрээнд Улаанбаатар хот дахь иргэдийн банкны салбар сүлжээнийхээ арын албыг нэгтгэн, борлуулалтыг илүү дэмжихэд чиглэсэн

бүтэцтэйгээр ажиллаж эхлэв. Бид хөгжлийнхөө шинэ мөчлөгтэй уялдуулан хэрэглэх брэндийн шинэчлэл төслийн хүрээнд харилцагчдынхаа нийтлэг сегментүүдэд өөр өөрийн гэсэн онцлог өнгө төрх бүхий үйлчилгээний орчинг бүрдүүлэх зорилгоор жишиг салбар бий болголоо. 2014 оны бас нэг онцлох чухал үйл явдал бол Банкны Үндсэн Системийн шинэ FLEXCUBE 12.0 хувилбарыг амжилттай нэвтрүүлснээр бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ боломжийг илүү тэлэх, шинэ шинэ үйлчилгээ, цахим сувгуудыг бий болгох, харилцагчийн мэдээллийн найдвартай байдлыг илүү нэмэгдүүлэх бусад олон давуу талыг бий болгох үүд хаалгыг нээсэн юм.

Нийгмийн хариуцлагын цогц үнэлгээг ХасБанкинд 2 дахь удаагаа хийсэн Олон Улсын үнэлгээний “Планет Рейтинг” байгууллага “4” буюу “Сайн” гэсэн үнэлгээг өгсөн нь нийгмийн хариуцлагаар Ази тивд хамгийн өндөр үнэлгээ болж бидний хичээл зүтгэлийг үнэллээ.

2014 онд банкны хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн гишүүд, ажиллагсад дотооддоо болон хилийн чанадад Эрдэнэт Хүмүүн, Эх Дэлхий, Эрүүл Ашгийг эрхэмлэсэн зорилгоо чанд баримталж, тунгалаг, сайн засаглалтай компани болохоо нийтээр хүлээн зөвшөөрүүлсээр ирлээ. Манай харилцагчид, хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн гишүүд болон хамтран зүтгэгчиддээ банкны эрхэм зорилгыг хэрэгжүүлэх үйлсэд биднийг тууштай дэмжиж байгаад гүн талархал илэрхийлье.

Хүндэтгэн ёсолсон,



Магваны Болд
ХасБанкны Гүйцэтгэх Захирал

2014 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



ЖДҮ, Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд үзүүлэх үйлчилгээний чанарыг сайжруулж, санхүүжилтээ нэмэгдүүлэх зорилгоор ОУСК-тай зөвлөх үйлчилгээний гэрээ байгууллаа. Ингэснээр Зүүн өмнөд Ази, Номхон далайн бүс нутаг дахь ОУСК-ийн “Бизнес эрхлэгч эмэгтэйчүүд” хөтөлбөрийн 2 дахь түнш банк боллоо.

ISO 27001

Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны олон улсын ISO 27001 стандартыг нэвтрүүлээ.


ОУ-ын зээлдүүлэгч, хөрөнгө оруулагч байгууллагатай хамтын ажиллагаагаа бэхжүүлсний үр дүнд, ADB, EBRD, OFID, ОөЕВ, IFC зэрэг 8-н байгууллагаас нийт 139 сая ам.долларын санхүүжилт авлаа.

\$ 139
сая

Planet Rating ОУ-ын үнэлгээний байгууллагаар

үнэлүүлж “4” гэсэн үнэлгээ авлаа.

Энэ нь Ази тивд хамгийн өндөр, Дэлхийд эхний 15-д орох үзүүлэлт юм.



Мобайл аппликэйшн

танилцууллаа



Банкны үндсэн систем болох Flexcube 10.1

программын хувилбар ахиулж FC 12.0 болгох ажлыг амжилттай гүйцэтгэлээ.




Банкны шинэчлэл

төслийн хүрээнд салбар, нэгжийн бүтцийг өөрчилж, үйлчилгээний процессыг шинэчлэн, төвлөрсөн бүтцийг УБ хотод 100 хувь нэвтрүүлээ.



Майкрософт, IT zone компаниудтай мэдээллийн технологийн дэд бүтцийг бий болгох “Open Value licensing program” хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурлаа.

2014 ОНЫ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ



ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТ

Харьцаа үзүүлэлтүүд		2013	2014	Харьцаа үзүүлэлтүүд		2013	2014
Нийт өөрийн хөрөнгийн хүрэлцээ	> 14%	16.5%	17.0%	Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	> 25%	43.8%	37.2%
1-р зэрэглэлийн ӨХ-н хүрэлцээ	> 9%	11.2%	9.8%	Нэг зээлдэгчид олгосон зээл / ӨХ	< 20%	12.4%	11.2%
Валютын ханшийн эрсдэл (нэгж валют)	< 15%	-5.2%	-5.8%	Нийт холбогдох этгээдийн зээл / ӨХ	< 20%	8.2%	10.7%
Валютын ханшийн эрсдэл (нийт)	< 40%	7.5%	7.8%	Нэг холбогдох этгээдийн зээл / ӨХ	< 5%	4.1%	4.3%

ГУРВАН ТУЛГУУРТ ЭРХЭМ ЗОРИЛГО

ЭРДЭНЭТ ХҮМҮҮН

- Бидний бүтээгдэхүүн үйлчилгээний агуулга нэн түрүүнд хүний төлөө, харилцагч төвтэй байхад оршино.
- Бид харилцагч, үйлчлүүлэгчдийнхээ насан туршийн санхүүгийн түнш байж, хамтдаа хөгжихийг зорино.
- Манай ажиллагсад бидний хамгийн үнэт хөрөнгө юм.

ЭХ ДЭЛХИЙ


- Бид эх дэлхийгээ ногоон байлгахыг хичээнэ.
- Бид байгаль орчинд ээлтэй хэрэглээг нэмэгдүүлэх, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниудыг дэмиж ажиллана.
- Бидний зорилго байгаль орчинд учруулж буй хор нөлөөг багасгах.

ЭРҮҮЛ АШИГ

- Ашиг - бидний дан ганц зорилго биш.
- Бидний үнэт зүйлсийн нэг бол нийгмийн хариуцлага.
- Бид нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч банк.

ТЭНГЭР САНХҮҮГИЙН НЭГДЛИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

ХасБанк нь санхүүгийн лизинг, даатгал, банкны хөрөнгө оруулалт болон бичил санхүүгийн салбарт санхүүгийн цогц үйлчилгээг үзүүлдэг ТэнГэр Санхүүгийн нэгдлийн бүрэн эзэмшлийн охин компани юм. ТэнГэр Санхүүгийн нэгдэл нь Олон Улсын санхүүгийн байгууллагууд, дотоодын болон гадаадын нэр хүндтэй компаниуд, Хөрөнгө оруулалтын сангууд, Төрийн бус байгууллагууд болон хувь хүмүүсээс бүрдсэн хувьцаа эзэмшигчидтэй ба одоогоор Монгол Улсын банк, санхүүгийн салбарт ийм төрөлжсөн хувьцаа эзэмшигчдийн бүтэцтэй цорын ганц компани.





ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Чулууны ГАНБОЛД ТУЗ-ийн дарга

2004 оноос хойш Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК болон ХасБанкны ТУЗ-ийн даргаар ажиллаж байна. Тэрээр Монгол Улсын анхны банк бус санхүүгийн байгууллага болох Х.А.С. (Хөгжлийн Алтан Сан)-гийн Зөвлөхүүдийн хорооны гишүүнээр сонгогдон ажиллаж байлаа. Ч.Ганболд 1999-2000 онд Монгол Улсын Ерөнхий Сайдын зөвлөх, 1993-1995 онд Дэлхий Монголчуудын Холбооны Гүйцэтгэх захирлын албан тушаал хашиж байсан бөгөөд Монгол улс дахь Ротари хөдөлгөөнийг үүсгэн байгуулагчдын нэг юм. Мөн Оюу Толгой ХХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байснаас гадна Email Daily News (EDN) ХХК-ийн Гүйцэтгэх захирал болон хэд хэдэн ТББ-ын Тэргүүнээр ажиллаж байна. Ч.Ганболд нь ОХУ-ын Москва хотын Гадаад хэлний их сургуулийг дүүргэсэн бөгөөд удирдлага, олон нийтийн харилцаа, бизнесийн зөвлөгөө, хэвлэн нийтлэл болоод соёл урлагийн чиглэлээр гуч гаруй жил ажилласан арвин туршлагатай.

Магваны БОЛД Гүйцэтгэх захирал

М.Болд нь 2014 оны 7 сарын 10-наас ХасБанкны Гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллаж байгаа бөгөөд ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-н гүйцэтгэх болон ХасБанкны ТУЗ-ийн гүйцэтгэх бус гишүүн. 2011 оноос ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. ТэнГэр Санхүүгийн Нэгдлээс өмнө ХасБанкны Гүйцэтгэх захирлаар 2009-2010 онд, Ерөнхийлөгчөөр 2005-2008 онд жил ажиллажээ. М.Болд нь төрийн болон хувийн хэвшлийн банк, санхүүгийн байгууллагууд, мөн түүнчлэн Дэлхийн Банк, Олон улсын валютын сан зэрэг олон улсын санхүүгийн байгууллагад хорь гаруй жил ажиллаж, банкны салбарын эдийн засгийн бодлого, бүтцийн шинэчлэлийн асуудлаар гүнзгий мэргэшсэн юм. Тэрээр 1996-2000 онд Монгол Банк (Төв Банк)-ны дэд ерөнхийлөгч, ОХУ-ын Москва дахь Олон Улсын Хөрөнгө Оруулалтын Банк болон Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Банкны ТУЗ-ийн гишүүн байсан. Мөн Зах зээл судлалын хүрээлэнд дэд захирал, Монголын Экспорт Импортын Банкны Гүйцэтгэх захирал, Афганистан Улсын Төв Банкнд зөвлөхөөр тус тус ажилласан. М.Болд нь БНУУ-ын Будапешт хотын Эдийн Засгийн Их Сургуулийг Олон улсын эдийн засагч мэргэжлээр төгссөн. АНУ-ын Колумбийн Их сургуулийн эдийн засгийн бодлого, удирдлагын чиглэлээр олон улсын харилцааны магистрын зэрэг хамгаалжээ. 2009-2014 онд Монголын Банкуудын Холбооны дэд ерөнхийлөгч, Ерөнхийлөгчөөр сонгогдон ажилласан. М.Болд нь Бүгд Найрамдах Исланд улсын Өргөмжит Консул.

Дүгэрсүрэнгийн БАТ-ОЧИР

Д.Бат-Очир нь 2011 оноос эхлэн ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдон ажиллаж байна. Д.Бат-Очир нь 2014 оны 7 сарын 10-наас ХасБанкны Ерөнхий Захирлаар томилогдсон бөгөөд үүнээс өмнө 3 жил ХасБанкны Гүйцэтгэх Захирлаар ажилласан. Анх 1998 онд НҮБХХ-ийн Микро Старт төслийн санхүүгийн зөвлөхөөр ажлын гараагаа эхэлж байсан тэрээр 2000 онд Хөгжлийн Алтан Сан Санхүүгийн компанийн Санхүүгийн Хэлтсийн Захирлын албан тушаалд дэвшин ажилласан юм. Тэрээр ХасБанк болон Тэнгэр Санхүүгийн Нэгдлийн удирдлагын багт 13 жил ажиллаж компанийн хөрөнгө оруулалт, бичил санхүү, удирдлага, бизнесийг хөгжүүлэх чиглэлээр банкны салбарын арвин туршлага хуримтлуулжээ. Тэр 2001-2006 онд Санхүү, бүртгэлийн газрын захирал, 2009-2011 онд Гүйцэтгэх Дэд Захирлаар тус тус ажилласнаас гадна 2009-2010 онд Тэнгэр Санхүүгийн Нэгдэлд Хөрөнгө оруулалт хариуцсан захирлаар ажиллажээ. Д. Бат-Очир нь 2008 онд АНУ-ын Бостон хот дахь Брандейс Их сургуулийн Олон Улсын Бизнес Сургуульд ОУ-ын санхүүгийн чиглэлээр төвлөрсөн Бизнес Удирдлагын магистрын зэрэг хамгаалсан.

Сабина ЗИУРМАН

2013 оноос ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн гүйцэтгэх бус гишүүнээр сонгогдон ажиллаж байна. Тэрээр Зээлийн шугам, ЖДБ хөгжүүлэлт, Банкны удирдлага, болон байгууллага ба бизнесийн удирдлагын чиглэлээр олон жил ажилласан арвин туршлагатай. Сабина 2004 оноос хойш Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны санхүүгийн байгууллагуудын багт ахлах банкираар ажиллаж байгаа ба Төв Азийн бүсийн Кавказ, Монгол зэрэг улсуудыг хариуцан ажиллаж байна. Тэрээр ЕСБХБ, DFID, болон Дэлхийн Банкны олон урт ба богино хугацааны төслүүдийн шугамаар Армен, Молдав, ОХУ, Туркминстан, Узбек, Беларусь, Киргиз, болон Тажикстан зэрэг улсуудад ажиллаж байсан. Сабина Зиурман нь Лондонгийн Бизнесийн сургуульд бизнесийн удирдлагын магистрын зэрэг хамгаалсан.

Ричард РАНКЕН

14 2009 оноос ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн ТУЗ-д Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК)-ийг төлөөлөн ТУЗ-ийн гүйцэтгэх бус гишүүнээр сонгогдон ажиллаж байна. Ричард нь Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК)-ийн Зүүн Ази, Номхон далайн бүсийг хариуцсан ахлах зөвлөх, Азийн хэд хэдэн хөрөнгө оруулалтын сан болон банкуудын Төлөөлөн Удирдах Зөвлөлд гишүүнээр ажилладаг. ОУСК-д нийт 30 гаруй жил түүний дотор хуучин ЗХУ, Африк болон Зүүн Азид ажиллаж байсан туршлагатай. Тэрээр ОХУ-д ОУСК-ийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх газрын захирлаар ажиллахдаа 50,000 аж ахуйн нэгжийг хувьчилахад зөвлөгөө өгч, тэдгээрт ТУЗ-ын стандартыг



анх нэвтрүүлж, банк санхүүгийн хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулжээ. Мөн Африкт ОУСК-ийн үйл ажиллагаа эрхэлсэн захирлын үүрэг гүйцэтгэж байхдаа ЖДБ болон бичил санхүүд төвлөрсөн цоо шинэ бодлогыг боловсруулж, энэхүү байгууллагын хөрөнгө оруулалт, бизнесийн үйлчилгээг 30 гаруй орнуудад нээлттэй болгож, бизнесийн хэмжээг 1,5 триллион ам долларт хүргэж чадсан байна. Тэрээр ОУСК-ийн Зүүн Ази, Номхон Далай бүсийн захирлаар ажиллаж байх хугацаандаа цаг уур, дулаарлын эсрэг хөрөнгө оруулалт, зөвлөх үйлчилгээний чиглэлээр голлон ажиллажээ. Ричард Австралийн Компанийн Захирлуудын Сургууль (GAICD)-ийг дүүргэж, Австралийн Үндэсний Их Сургуульд мастерийн зэрэг хамгаалжээ.

Шүжи ИРИЕ

2013 оноос ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн гүйцэтгэх бус гишүүнээр сонгогдон ажиллаж байна. Тэрээр 2011 оноос эхлэн ОРИКС корпорацийн хөрөнгө оруулалтын банкны даргаар ажиллаж эхэлсэн ба 2013 оны 1-р сард тус корпорацийн гүйцэтгэх захирлын албан тушаалд томилогдон ажиллаж байна. Тэрээр 1989-2011 онд Мизүхе Корпорейт Банк болон Мизүхе үнэт цаасны компаниудад үнэт цаас болон үл хөдлөх хөрөнгийн чиглэлээр ажиллаж байсан туршлагатай. Шүжи Ирие Токио хотын Васеда Их Сургуулийг төгссөн.

Майкл МАДДЕН

2009 оноос хойш ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн ТУЗ-ийн гүйцэтгэх бус гишүүнээр ажиллаж байна. Майкл Ирландын Дублин хотод хөрөнгө оруулалт, зөвлөх үйлчилгээний Ронок компанийг үүсгэн байгуулж, ерөнхий захирлаар нь ажиллаж байна. Тэрээр 15 жил Американ Экспресс компанид ажилласнаас гадна Зүүн Европын зах зээлд төлбөрийн картыг нэвтрүүлж банкны салбарын бизнест амжилттай яваа бизнесмен юм. Тэр 1988-2003 онд Американ Экспресс компанид ажиллаж байсан бөгөөд 1988-1992 онд Дублин хотод менежер, 1993-1996 онд хуучин ЗХУ-ын орнуудад Американ Экспресс компанийн төлөөлөгч менежер, 1997-1998 онд Нэгдсэн Вант улсын Брайтон хотод захирал, 1998-2003 онд Лондон хотод Американ Экспрессийн дэд ерөнхийлөгчөөр тус тус ажиллаж байв. Мөн 2003-2007 онд ОХУ-д Ренессанс Кредит банкыг байгуулж, гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан юм.

Нямтайширийн ЦЭЛМҮҮН

2012 оноос ТэнГэр санхүүгийн ТУЗ-ийн гишүүн, 2007 оноос хойш Монголын Алт /МАК/ компанийн дэд ерөнхийлөгч, ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байна. Тэрээр Худалдаа Хөгжлийн Банк болон МАК компаниудад 8 жилийн турш удирдах албан тушаал хашиж байсан бөгөөд хөрөнгө оруулалт, бизнесийн удирдлагын чиглэлээр арвин туршлагатай. Анх 2005 онд Худалдаа Хөгжлийн Банкны хөрөнгө зохицуулалтын хэлтсийн мэргэжилтнээр ажлын гараагаа эхэлж байсан тэрээр 2007 онд МАК компанийн дэд ерөнхийлөгчөөр сонгогдсон ба нийгмийн хариуцлагын хэлтэс, худалдан авалтын хэлтэс, худалдааны хэлтсүүдийг хариуцан ажиллаж байна. Мөн 2010 оноос хойш тус байгууллагын хөрөнгө оруулалт санхүүгийн хэлтсийг давхар хариуцан ажиллаж байна. Н.Цэлмүүн нь Индиана мужийн Valparaiso Их Сургуулийг бизнесийн удирдлагын чиглэлээр төгссөн бөгөөд ХонгКонг дахь Стэнфордын Их сургуулийн Санхүүгийн инженерийн хөтөлбөрийг дүүргэсэн.

Баатарын БАТСАЙХАН

2014 оноос ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн гүйцэтгэх бус гишүүнээр сонгогдон ажиллаж байна. Б.Батсайхан нь Монголия Оппортунистиз Фанд (Mongolia Opportunities Fund)-ын үүсгэн байгуулагч, хамтран эзэмшигчээр ажилладаг. Монголия Оппортунистиз Фанд нь Монголын хурдацтай хөгжиж буй компаниудад хөрөнгө оруулалт хийж, тэдгээрийн өсөлтийг дэмжих зорилгоор Олон Улсын Санхүүгийн Корпораци, Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк, Нидерландын Хөгжлийн Банк, Германы Хөгжлийн Банк, Япон улсын Мицубиши болон ОРИКС корпораци зэрэг олон улсад танигдсан, нэр хүндтэй хөрөнгө оруулалт, санхүүгийн байгууллагуудын хамтын хөрөнгө оруулалтаар байгуулагдсан анхны хувийн хөрөнгө оруулалтын сан юм. Б.Батсайхан нь Монгол дахь хамгийн нөлөө бүхий бизнес холбоодын нэг болох CEO клубын үүсгэн байгуулагч төдийгүй Дэд Ерөнхийлөгчөөр ажилладаг Монголын бизнесийн салбарт хүлээн зөвшөөрөгдсөн удирдагч юм. Монголын хөрөнгө оруулалтын санг байгуулахаасаа өмнө тэрээр 2002-2003 онд UNIQLO компанид маркетингийн менежер, 2004-2005 онд MCS группд шинэ бизнесийн стратеги, санхүүгийн шийдлийг хариуцсан Дэд Ерөнхийлөгч, 2005-2007 онд Гоёо компанийн Гүйцэтгэх Захирлаар тус тус ажиллаж байсан туршлагатай. Тэрээр Гоёо компанид ажиллах хугацаандаа санхүүгийн хүнд байдалд ороод байсан уг компанийг Монголын хамгийн амжилттай ноолууран бүтээгдэхүүний брэнд болгож чадсан, мөн UNIQLO компанийн 100 сая ам.долларын борлуулалтын орлого авчирсан төслийг хэрэгжүүлсэн шилдэг удирдах ажилтан юм. Мөн тэрээр Токио дахь А.Т. Kearney компанид зөвлөхөөр ажиллаж байсан. Б.Батсайхан нь Япон улсын Хитоцубаши Их Сургуулийг маркетинг, зах зээлийн өрсөлдөөний стратегийн чиглэлээр төгссөн, Бизнесийн Удирдлагын Бакалавр зэрэгтэй.

Жеймс СТЕНТ

2014 оны 4-р сарын 3-ны өдрөөс ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдсон. Тэрээр 20 гаруй жилийн хугацаанд Тайландын Азийн Банкны Дэд Ерөнхийлөгчийн албыг хашиж байгаад 2002 онд тэтгэвэрт гарсанаах дараа тус банкны ТУЗ-ийн гишүүнээр 2004 он хүртэл ажилласан. Жеймс Стент банк санхүүгийн салбарт арвин туршлагатай нэгэн юм. Тэрээр Хятадын Everbright банкны ТУЗ-ийн хараат бус гишүүн, Аудитын хорооны даргаар 6 жил ажилласан бөгөөд одоо тус банкны Захирлуудын Зөвлөлийн гишүүнээр ажиллаж байна. Жеймс Стент нь Тайландын зээлийн үнэлгээний агентлаг болон Хятадын Миншенг Банкны ТУЗ-ийн гишүүнээр мөн ажиллаж байсан. Тэрээр 2012-2014 онд ХасБанкны Гүйцэтгэх Захирлын зөвлөхөөр ажилласан. Жеймс Стент нь ажлын гараагаа 1970-аад оны сүүлээр Ситибанкнаас эхэлсэн бөгөөд дараа нь Азийн Банк руу шилжихээсээ өмнө АНУ-ын Crocker National банкны Нью-Йорк, Сан Франциско, Манила, Бангкок, Хонконг дахь салбаруудад ажиллаж байсан. Жеймс Стент нь Принстоны Их Сургуулийн Олон Улсын харилцааны сургуульд суралцаж хөгжлийн эдийн засгийн чиглэлээр магистрын зэрэгтэй, Хятад, Тайланд хэлтэй.

УДИРДЛАГЫН БАГ







УДИРДЛАГЫН БАГ

Магваны БОЛД Гүйцэтгэх захирал

М.Болд нь 2014 оны 7 сарын 10-наас ХасБанкны Гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллаж байгаа бөгөөд ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-н гүйцэтгэх болон ХасБанкны ТУЗ-ийн гүйцэтгэх бус гишүүн. 2011 оноос ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. ТэнГэр Санхүүгийн Нэгдлээс өмнө ХасБанкны Гүйцэтгэх захирлаар 2009-2010 онд, Ерөнхийлөгчөөр 2005-2008 онд ажиллажээ. М.Болд нь төрийн болон хувийн хэвшлийн банк, санхүүгийн байгууллагууд, мөн түүнчлэн Дэлхийн Банк, Олон улсын валютын сан зэрэг олон улсын санхүүгийн байгууллагад хорь гаруй жил ажиллаж, банкны салбарын эдийн засгийн бодлого, бүтцийн шинэчлэлийн асуудлаар гүнзгий мэргэшсэн юм. Тэрээр 1996-2000 онд Монгол Банк (Төв Банк)-ны дэд ерөнхийлөгч, ОХУ-ын Москва дахь Олон Улсын Хөрөнгө Оруулалтын Банк болон Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Банкны ТУЗ-ийн гишүүн байсан. Мөн Зах зээл судлалын хүрээлэнд дэд захирал, Монголын Экспорт Импортын Банкны Гүйцэтгэх Захирал, Афганистан Улсын Төв Банкинд зөвлөхөөр тус тус ажилласан. М.Болд нь БНУУ-ын Будапешт хотын Эдийн Засгийн Их Сургуулийг Олон улсын эдийн засагч мэргэжлээр төгссөн. АНУ-ын Колумбийн Их сургуулийн эдийн засгийн бодлого, удирдлагын чиглэлээр олон улсын харилцааны магистрын зэрэг хамгаалжээ. 2009-2014 онд Монголын Банкуудын Холбооны дэд ерөнхийлөгч, Ерөнхийлөгчөөр сонгогдон ажилласан. М. Болд нь Бүгд Найрамдах Исланд улсын Өргөмжит Консул.

Ганибалын АМАРТҮВШИН Ерөнхий захирал

Г.Амартүвшин нь 2014 оны 7 сараас ХасБанкны Ерөнхий захирлаар томилогдон ажиллаж байна. ХасБанкинд ажиллахын өмнө Г.Амартүвшин нь ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн ерөнхий захирлаар 3 жил ажилласан.

Тэрбээр Казахстан улсын арилжааны томоохон банк болох Казкоммерц банкны Эрсдлийн Удирдлагын Газрын дарга, Ерөнхий захирлын алба хашиж төслийн санхүүжилт болон зээлийн санхүүжилтийн чиглэлээр арваад жил ажилласан туршлагатай.

Казкоммерц банкинд ажиллахын өмнө Г.Амартүвшин нь ABN AMRO Банкны Лондон, Амстердам болон Чикаго хотуудын салбарт ажиллаж байв. ABN AMRO банкны бүтцийн зээлийн хэлтэст ажиллаж байхдаа Европын газрын тос, шатдаг хий, эрчим хүч, харилцаа холбоо гэх мэт хэд хэдэн өндөр хэмжээний гүйлгээг хариуцан ажиллаж байжээ. Г.Амартүвшин нь хөдөлмөрийн гараагаа ABN AMRO дахь бэлэн мөнгөний менежментийн газраас эхэлсэн бөгөөд улмаар тэндээ Ерөнхий Эрсдэлийн Удирдлагын хэлтэст шилжин оржээ.

Тэрээр Бельги улсын Брюссель хотын Европын Их сургуулийн бизнесийн удирдлагын бакалаврын зэрэгтэй бөгөөд АНУ-ын Бостон хотын Харвардын бизнесийн сургуулийн, бизнесийн удирдлагын магистрын дипломыг гардан авсан билээ.

Дүгэрсүрэнгийн БАТ-ОЧИР Ерөнхий захирал

Д.Бат-Очир нь 2014 оны 7 сарын 10-наас ХасБанкны Ерөнхий захирлаар томилогдон ажиллаж байна. Үүнээс өмнө Д.Бат-Очир нь 3 жил ХасБанкны Гүйцэтгэх захирлаар ажилласан. Ажлын гараагаа анх 1998 онд Микростарт төсөл дээр эхлүүлж, түүнээс хойш ХасБанкинд тасралтгүй ажиллаж Банк болон ТСН-ийн хөгжлийн үе шат бүрт бодит хувь нэмэр оруулж ирсэн олон талт мэдлэг, чадвартай удирдагч юм.

1998 оны 8 дугаар сараас Монгол дахь НҮБХХ-ийн МикроСтарт төсөл болон Техникийн туслалцааны ACDI/ VOCA нэгжид санхүүч, 1999 оноос МикроСтарт төсөл, Хөгжлийн Алтан Сан ХХК-ийн санхүүгийн зөвлөх, дотоод аудитор, 2000 онд Хөгжлийн Алтан Сан ХХК-ийн Санхүүгийн хэлтсийн захирал, 2001- 2006 онуудад ХасБанкны Санхүү, Бүртгэлийн газрын захирлаар ажиллаж байсан туршлагатай.

Д.Бат-Очир нь 2006-2008 онуудад Америкын Олон Улсын Бизнесийн Сургуульд Бизнесийн удирдлагын магистрын зэрэг хамгаалж, Олон Улсын Санхүүгийн чиглэлээр түлхүү мэргэшиж, улмаар ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн Санхүү Эрхэлсэн Захирал, ХасБанкны Гүйцэтгэх тэргүүн дэд захирал, ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн Хөрөнгө оруулалт хариуцсан захирлын албыг тус тус хашиж байсан.



Баянжаргалын ДЭЛГЭРЖАРГАЛ Иргэдийн банк хариуцсан захирал

Б.Дэлгэржаргал нь 2011 оны 3 дугаар сараас ХасБанкны Иргэдийн банк хариуцсан захирлаар ажиллаж байгаа бөгөөд тэрээр Монголын Хөрөнгийн Биржээс ажлын гараагаа эхэлж, 1992-1998 он хүртэл Гишүүн пүүсийн алба, Бүртгэл хяналтын албанд ажиллаж улмаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (UNDP)-ийн Micro Start төсөлд зээлийн мэргэжилтнээр ажилд орж ажилласан юм.

Тэрээр тус байгууллагад санхүүгийн менежер, ерөнхий нягтлан бодогч, Хөгжлийн Алтан Сан ХХК-ийн Бодлого зохицуулалтын хэлтсийг ахалж байсан туршлагатай. 2002 оноос ХасБанкинд Бичил зээлийн газрын захирал, Зээл эрхэлсэн захирал, Үйл ажиллагаа эрхэлсэн захирал, улмаар 2009 оны 9 сараас Санхүү эрхэлсэн захирлын хариуцлагатай ажлуудыг хийж иржээ.

Ганзоригийн ЭРДЭНЭБАЯР Санхүү хариуцсан захирал

Г.Эрдэнэбаяр нь 2013 оны 1 дүгээр сараас ХасБанкны Санхүү хариуцсан захирлаар томилогдон ажиллаж байна. Тэрээр ажлын гараагаа 2005 онд ХасБанкны эрсдэлийн менежерээр эхэлсэн бөгөөд 2008 онд Эрсдэлийн нэгдсэн удирдлагын газрын захирал, 2012 онд Санхүүгийн удирдлагын газрын захирлаар томилогдон ажиллаж байсан.

Г.Эрдэнэбаяр нь 2002-2006 онд Санхүү Эдийн Засгийн Дээд Сургуулийг бизнесийн удирдлагын бакалавр, 2010-2012 онд Японы Олон Улсын Их Сургуульд бизнесийн удирдлагын магистрын зэргийг санхүүгийн чиглэлээр тус тус хамгаалсан.

Аарт ЖОНГЖАНС Эрсдэл хариуцсан захирал

Аарт Жонгжанс нь 2013 оны 9 дүгээр сараас Эрсдэл хариуцсан захирлаар томилогдон ажиллаж байна. Тэрээр эрсдэлийн удирдлагын чиглэлээр 40 гаруй жил ABN AMRO Bank, BNP Paribas зэрэг томоохон банкуудад ажиллаж байсан асар их туршлагатай. Аарт нь Европ, Ойрх Дорнод, ба Ази номхон далайн 7 улс оронд ажиллаж байсан.

Юндэнгийн ГЭРЭЛМАА Зээл хариуцсан захирал

Ю.Гэрэлмаа нь 2006 оны 2 дугаар сараас ХасБанкны зээлийн удирдлага, тэр дундаа зээлийн эрсдэлийн удирдлага, тусгай активыг хариуцан ажиллан улмаар Зээл хариуцсан захирлаар ажиллаж байна. Тэрээр ажлын гараагаа 1986-1990 онд Монголбанк (Төв банк)-ны Олон улсын төлбөр тооцооны газар нягтлан бодогчоор эхэлж, улмаар Худалдаа, Хөгжлийн Банкинд Зээлийн газрын орлогч захирал, Тусгай активын хэлтсийн захирал, Гадаад тооцооны газрын захирал, санхүүгийн байгууллагын менежер зэрэг удирдах албан тушаал хашиж байв.

Ю.Гэрэлмаа нь Герман улсын Берлин хот дахь Эдийн засгийн дээд сургуулийг 1986 онд эдийн засгийн мэргэжлээр төгсч, улмаар 1992-1994 онд ХБНГУ-ын Киел хот дахь Эдийн засгийн дээд сургуульд зах зээлийн эдийн засгийн чиглэлээр удирдлагын хөтөлбөр дүүргэсэн.



УДИРДЛАГЫН БАГ

Чогсомын МӨНХБАЯР Үйл ажиллагаа хариуцсан захирал

Ч.Мөнхбаяр нь 2011 оны 11 дүгээр сараас ХасБанкны Үйл ажиллагаа хариуцсан захирлаар ажиллаж байна. Тэрээр ажлын гараагаа Сангийн яамны Санхүүгийн хяналтын газарт хянан шалгагчаар эхэлж, улмаар ахлах хянан шалгагч, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын санхүүгийн хяналтын газрын даргын албыг тус тус хашиж байв.

Ч.Мөнхбаяр нь Санхүүч-Эдийн засагчийн мэргэжлээр Монгол Улсын Их Сургууль, Санхүүгийн удирдлагын магистр зэргээр Австрали Улсын Үндэсний их сургуулийг тус тус төгссөн юм. ХасБанкны Гүйцэтгэх захирлын зөвлөх болон Байгууллагын банкны газрын харилцааны албаны зөвлөхөөр ажиллаж байсан туршлагатай.

Төмөрбаатарын ТАЙШИР Хуулийн асуудал хариуцсан захирал

Т.Тайшир 2014 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс ХасБанкны Хуулийн асуудал хариуцсан захирлаар томилогдон ажиллаж байна.

Тэрээр 2013 оны 2 дугаар сараас ТэнГэр Санхүүгийн Нэгдэлд Хуулийн захирлаар томилогдон ажиллаж байсан бөгөөд өмнө нь Ньюком Группд хуулийн зөвлөхөөр ажиллаж байжээ.

Тайшир нь 2006 онд Ломоносовын нэрэмжит Москвагийн Улсын Их Сургуулийн Хуулийн ангийг төгссөний дараа шинэ тутам байгуулагдсан Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэрээгүүлэх хэлтэс, Судалгаа шинжилгээний албаны ажилтнаар ажлын гараагаа эхэлсэн. 2010 онд Монгол Улсын Их Хурлын Тамгын газарт зөвлөхөөр дэвшин ажилласан бөгөөд Эдийн засаг, Төсөв болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороон дээр хэлэлцэгдэх хууль, УИХ-ын тогтоолын төслүүд дээр түлхүү ажилласан. Тэрээр 2011 онд Ньюком Группын Хуулийн зөвлөхөөр ажиллаж эхэлсэн бөгөөд энэ хугацаанд төслийн санхүүжилтийн багийн гишүүдтэй ЕСБХБ, ФМО болон Женерал Электрик компанитай хамтран Монгол Улсын анхны салхин цахилгаан станцыг барьж ашиглалтад оруулах ажлыг хариуцаж байсан.

Энэбишийн УЛАМБАЯР Ерөнхий аудитор

Э.Уламбаяр нь 2013 оны 7 дугаар сараас ерөнхий аудиторoor томилогдон ажиллаж байна. Тэрээр ажлын гараагаа Монголбанкны Хяналт шалгалтын газраас эхэлсэн бөгөөд энэхүү чиглэлээр 12 жил ажилласныхаа дараа Монгол улсын хөгжлийн банк болон Оюутолгой ХХК-д тодорхой удирдах албан тушаалуудыг хашиж байжээ.

Э.Уламбаяр нь МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг Банкны эдийн засагч мэргэжлээр төгссөн бөгөөд магистрийн зэргээ Австралийн Викториагийн их сургуульд Бизнесийн удирдлагын чиглэлээр хамгаалжээ.



Чадраагийн БАТТӨГС Мэдээлэл технологи хариуцсан захирал

Ч.Баттөгс нь 2012 оны 10 дугаар сараас эхлэн ХасБанкны Мэдээлэл Технологи Эрхэлсэн Захирлаар ажиллаж байна. Ажлын гараагаа 1999 оноос программ хангамжийн инженерээр эхэлсэн бөгөөд АНУ-ын Майкрософт болон Салесфорском компаниудад программ хангамжийн инженерээр 13 жил ажилласан туршлагатай.

Ч.Баттөгс Америкийн Нэгдсэн Улсын Хавай дахь Brigham Young-ийн Их сургуулийг Компьютерийн Шинжлэх Ухааны Бакалавр зэрэгтэй төгссөн байна.

Ганзоригийн ЗУЛ Хүний нөөц хариуцсан захирал:

Г.Зул 2014 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс ХасБанкны Хүний нөөц хариуцсан захирлаар томилогдон ажиллаж эхэллээ. Тэрээр 2011 оны 3 дугаар сараас эхлэн ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн Хүний нөөц эрхэлсэн захирлаар ажиллаж байсан бөгөөд түүний хариуцах ажил үүргийн хүрээнд Тэнгэр Санхүүгийн Нэгдлийн болон ХасБанкны хүний нөөцийн удирдлагын бодлогын асуудал болох цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, сургалт ба хүний нөөцийн хөгжил, удирдах ажиллагчдын хөдөлмөрийн харилцааны болон мэргэжлийн өсөлттэй холбоотой асуудал, шинээр ажилтан элсүүлэх, ажилтнуудын ажил үүргийн биелэлт, байгууллагын ёсзүй, зохион байгуулалт зэрэг цогц асуудлуудыг удирдан зохицуулах ажлууд ордог.

Г.Зул нь ХасБанкны үүсгэн байгуулагч, ACDI/VOCA (Монгол дахь НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөрийн Бичил Эхлэл төсөл) хөтөлбөрт ажиллаж байгаад 1999 онд ХасБанкинд нэгдэж орсон. Хоёр томоохон банк бус санхүүгийн байгууллагууд нэгдэж арилжааны банк болох үйл явцын хүрээнд тэрээр байгууллагын хүний нөөцийн бодлого хөтөлбөрийг амжилттайгаар боловсруулан уялдуулан нэгтгэж чадсан юм. Шилжилтийн энэхүү явц нь бүтээгдэхүүнд чиглэсэн байгууллагаас харилцаанд тулгуурласан бизнесийн байгууллага болох зохион байгуулалт, өөрчлөлтийн үйл явцыг хамарч байв. Тэрээр мөн 2003 онд захиргаа хариуцсан үйл ажиллагааны хэлтсийг удирдан ажиллаж байжээ. Үүнээс өмнө буюу 1998 онд Г.Зул нь Эрүүл Мэнд Нийгмийн Хамгаалалын Яаманд олон улсын харилцааны ажилтнаар ажиллан энэ хугацаандаа НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөрийн Залуучуудын Хөгжлийн төслийн хэрэгжилтэд оролцон ажиллаж байв. Мөн Г.Зул нь бүс нутаг дахь Бичил Санхүүгийн байгууллагуудад хүний нөөцийн удирдлагын чиглэлээр бодлого үйл ажиллагааны зөвлөгөө өгдөг бөгөөд энэ нь ХасБанкинд олон улсын бичил санхүүгийн төсөл хөтөлбөрүүд бий болгоход хувь нэмэр үзүүлж ач холбогдлоо өгсөөр байна.

Г.Зул нь Бүгд Найрамдах Болгар Улсын Софи хотын Их Сургуулийг төгссөн.

Дашнямын АШИДМАА Хөрөнгө оруулагчдын харилцаа, компанийн засаглал хариуцсан захирал:

Д.Ашидмаа 2014 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс ХасБанкны Хөрөнгө оруулагчдын харилцаа, компанийн засаглал хариуцсан захирлаар томилогдон ажиллаж эхэллээ. Д.Ашидмаа нь 2011 оны 7 дугаар сараас эхлэн ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-д Хөрөнгө оруулагчдын харилцаа, компанийн засаглал эрхэлсэн захирлаар ажиллаж байсан бөгөөд өмнө нь Энержи Ресурс ХХК-д компанийн засаглал эрхэлсэн захирлаар 2 жил ажилласан. Тэрээр тус компанид ажиллах хугацаандаа Хонгконгийн хөрөнгийн бирж дээр үнэт цаас гаргаж арилжаалах ажлыг гүйцэтгэх явцад засаглал, хянан нийцүүлэх асуудлуудыг хариуцан ажилласан.

Д.Ашидмаа нь АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр хэрэгжсэн хэд хэдэн хөтөлбөрт ажиллаж байсан. 2004-2009 онуудад АНУ-ын Chemonics International компанийн хэрэгжүүлсэн эдийн засгийн бодлогын шинэчлэл, өрсөлдөх чадварын төсөлд бизнес санхүүгийн зөвлөхөөр, 1998-2004 онуудад АНУ-ын Barents Group of Bearing Point компанийн хэрэгжүүлсэн Монголын хувьчлалын хөтөлбөрт санхүүгийн шинжээчээр ажиллаж байсан. 2006-2007 онуудад Монголын 10 арилжааны банкууд хамтарч байгуулсан мэргэжлийн хоёрдогч зах зээлийн анхны байгууллага болох Монголын Ипотекийн Корпораци (МИК)-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр ажилласан. Д.Ашидмаа нь мөн Монголын компанийн засаглалыг хөгжүүлэх төвийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байгаа.

Д.Ашидмаа нь АНУ-ын Виржиния мужийн Политехникийн Дээд Сургуульд бизнес санхүү, бондын хөрөнгө оруулалт, эрсдэлийн удирдлагын мэргэжлээр магистрын зэрэг хамгаалсан болно. Мөн түүнчлэн ОХУ-ын Москва хотын Олон Улсын Харилцааны Дээд Сургуулийг олон улсын эдийн засгийн харилцааны бакалавр зэрэгтэй төгссөн.





ЭРДЭНЭТ ХҮМҮҮН

2013-2014 оны хичээлийн жилд ХасБанк Хөгжлийн Алтан Сан Холбоо ТББ-тай хамтран "Тэмүүлэл" болон "Афлатон" хөтөлбөрийг орон даяар ерөнхий боловсролын 60 сургуулийн 6,060 хүүхдэд амжилттай хүргэлээ.





ИРГЭДИЙН БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

ХасБанк нь Улаанбаатар хот, 21 аймаг, томоохон сумдыг хамарсан 95 салбар, нэгжээр дамжуулан банкны бүх төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг 650 гаруй мянган харилцагчиддаа хүргэж ажиллалаа. 2013 оноос эхлэн туршигдсан Иргэдийн банкны үйл ажиллагааг Олон Улсын жишигт нийцүүлэн өөрчлөн зохион байгуулах ажлыг өргөжүүлж, Улаанбаатар хотын бүх 30 салбар, нэгж, орон нутгийн 13 салбар нэгжийг хамруулан, үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалтыг өөрчлөв.

Эдийн засгийн нөхцөл байдалтай уялдан, банкны системийн иргэдийн банкны өсөлт саарсан хэдий ч ХасБанк зээл, хадгаламж, иргэдийн төлбөр тооцоо, цахим сувгийн хэрэглээгээрээ зах зээлд эзлэх байр сууриа тогтвортой өсгөн нэмэгдүүлээ.


ХАДГАЛАМЖ

Иргэдээс татсан харилцах, хадгаламжийн багц өмнөх оноос 18.4 хувиар өсч 575.0 тэрбум төгрөгт, нийт дансны тоо 10.9 хувиар өсч 761.0 мянгаас 844.0 мянгад хүрлээ. Иргэдээс татсан эх үүсвэрийн 23.1 хувь нь хугацаагүй болон харилцах данс, 25.3 хувь нь богино хугацаатай буюу 13 сар хүртэлх хугацаатай, 51.6 хувь нь 13 сараас дээш урт хугацаатай хадгаламж байна.

Бүтээгдэхүүнээр ангилж үзвэл нийт эх үүсвэрийн 23.1 хувийг харилцах болон хугацаагүй хадгаламж, 27.6 хувийг хүүхдийн хадгаламж, 49.4 хувийг бусад хугацаатай хадгаламж эзэлж байна.

Үзүүлэлтүүд	2013	2014	14/13 (%)
Харилцах дансны тоо	296,818	329,714	11.1%
Харилцах дансны багц (тэрбум төгрөг)	10.3	16.8	63.3%
Хадгаламжийн тоо	464,206	514,581	10.9%
Хадгаламжийн багц (тэрбум төгрөг)	476	559	17.4%

Иргэдийн хуримтлалын бүтэц




ЗЭЭЛ

ХасБанк нь 2014 онд 171,893 иргэнд нийт 764.0 тэрбум төгрөгийн зээл олгож, иргэдийн зээлийн багц 683.0 тэрбум төгрөгт хүрснийг өмнөх онтой харьцуулбал олгосон зээлийн хэмжээ 31.2 хувь, зээлийн багц 44.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Нийт олгосон зээлийн 32.2 хувийг бизнесийн зориулалтаар, 36.6 хувийг хэрэглээний зориулалтаар, 31.7 хувийг орон сууц, хашаа байшин худалдан авах зориулалтаар олгожээ.

Үзүүлэлтүүд	2013	2014	14/13 (%)
Олгосон зээлийн тоо	141,853	171,893	21.2%
Олгосон зээлийн дүн (тэрбум төгрөг)	582	764	31.2%
Нийт идэвхтэй зээлийн тоо	95,232	122,550	28.7%
Нийт идэвхтэй зээлийн багц	472	683	44.8%
1 зээлийн дундаж үлдэгдэл	5.0	5.6	12.5%

Зээлийн багцын бүтэц



ОРОН СУУЦНЫ САНХҮҮЖИЛТ

Банк 2014 онд 2,747 иргэнд орон сууц, хашаа байшин худалдан авах, орон сууцны нөхцөлөө сайжруулахад зориулан 125.0 тэрбум төгрөгийн зээл олгосноос 40.0 тэрбум төгрөгийн зээлийг өөрийн эх үүсвэрээс санхүүжүүлсэн бол 85.0 тэрбум төгрөгийн зээлийг Засгийн Газраас Монголбанкт хамтран хэрэгжүүлж буй “Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрт хамрууллаа.

Дэд хөтөлбөрийн хүрээнд 1,524 өрхөд 8(±1) хувийн хүүтэй орон сууцны зээлийг шинээр олгож, 219 харилцагчийн зээлийг тус хөтөлбөрт шилжүүлснээр ипотекийн зах зээлд эзлэх хувиа 1.2 нэгжээр өсгөж 10.3 хувьд хүргэсэн байна.

Ипотекийн хоёрдогч зах зээл дээр идэвхитэй оролцож, 52.5 тэрбум төгрөгийн орон сууцны зээлийн багцыг Монголын Ипотекийн Корпораци (МИК)-д амжилттай худалдаж, 47.6 тэрбум төгрөгийн ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас (ИЗББ)-ны арилжааг Монголбанкт хийлээ.


ИРГЭДИЙН БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

БИЧИЛ САНХҮҮГИЙН МАНЛАЙЛАЛ

2014 онд 21,287 бичил болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд 229.1 тэрбум төгрөгийн бичил зээлийг эргэлтийн болон үндсэн хөрөнгийн зориулалтаар олгож, оны эцсийн байдлаар банкны нийт зээлийн багцын 16.2 хувийг бичил зээл, идэвхитэй зээлдэгчийн 21.5 хувийг бичил зээлдэгчид эзэлж байна.

ХасБанк бичил болон жижиг, дунд бизнес эрхлэгчдэд олгож буй зээлээ тогтвортой өсгөн нэмэгдүүлж байгаагийн дээр, зах зээлд эзлэх хувиа 30 хувиас дээш түвшинд амжилттай удирдан ажилласаар байна. 2014 оны эцсээр Банкны бичил, жижиг дунд бизнес эрхлэгч иргэдэд олгосон зээлийн зах зээлд эзлэх хувь хэмжээ зээлдэгчийн тоогоор 49.6 хувь, зээлийн багцын дүнгээр 33.8 хувьд тус тус хүрэв.

Бичил зээлдэгчид



Кива Олон Улсын байгууллагатай хамтран 2009 оноос хойш хэрэгжүүлж буй олон улсын зээл зуучлалын хөтөлбөрт 6,305 харилцагчийг хамруулж, 11.8 тэрбум төгрөгийн зээлийг бичил бизнес эрхлэгчдэд олгоод байна. Хөтөлбөрт хамрагдан зээлээ хугацаанд нь төлсөн бизнес эрхлэгчдэд нийт төлсөн хүүгийн 9 хувьтай тэнцэх дүнгээр хадгаламж нээж урамшуулдаг бөгөөд, 2014 онд 23.2 сая төгрөгийн хадгаламжийг 906 харилцагчид нээлээ.

Банк барьцаа хөрөнгийн хүрэлцээгүй, банкны ердийн зээлийн шалгуураар зээл авах чадамжгүй 3,020 бизнес эрхлэгчдэд 10.9 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг өөрийн эх үүсвэрээс олгож, бичил бизнес эрхлэгчдийг дэмжин ажиллаа. Мөн Монгол Улсын Засгийн Газрын болон дотоод гадаадын төсөл хөтөлбөрүүдтэй үр дүнтэй хамтран ажилласнаар банкны 1,450 харилцагчийг бага хүүтэй, хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлд хамруулсан байна.

“

Уламбаярын Ганзориг

У.Ганзориг нь Увс аймагт үйл ажиллагаа эрхэлдэг нарийн боовны үйлдвэрүүдийн бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, худалдан авагчдын эрэлт хэрэгцээг хангахуйц шинэ төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх эрмэлзлээр эхнэрийн хамт 2008 онд Мөнхийн Чанар ХХК-г байгуулан “Өнхрүүш” нарийн боов, тортны үйлдвэрийг нээсэн.


Бизнесээ эхлэхэд санхүүгийн хэрэгцээ тулгарч банкуудын зээлийн бүтээгдэхүүний судалгаа хийж байхдаа танилынхаа зөвлөснөөр ХасБанкинд хандан анхныхаа бизнесийн зээлийг авсан нь бизнесээ цаашид тогтвортой, өргөжүүлэн ажиллахад ихээхэн тус болсон гэж тэрээр үздэг байна.

У.Ганзориг нь ХасБанкнаас нийт 8 зээлийг бизнес болон өрхийн санхүүжилт, орон сууц худалдан авах зориулалтаар авсан бөгөөд шаргуу хөдөлмөрийн үр шим, хуримтлалын ашиг, тусыг ойлгон түүнийгээ хуримтлуулж чадсанаар зах зээлд танигдсан бизнестэй болсон төдийгүй, өөрийн өмчлөлийн 3 өрөө орон сууцандаа гэр бүлийн хамт амьдарч байна.

Мөнхийн Чанар ХХК нь нийт 32 иргэнийг ажлын байраар ханган, “Өнхрүүш” нарийн боов, тортны үйлдвэр, “Өнхрүүш” буфет цайны газар болон “Улаангом” сити шоп салбаруудаараа шинэхэн, эрүүл, чанартай бүтээгдэхүүнийг Увс аймгийн иргэдэд хүргэж байгаад ХасБанкны зүгээс ихээхэн талархдаг билээ.

У.Ганзориг нь “ХасБанкны олон сонголттой, уян хатан нөхцөлтэй зээлийн бүтээгдэхүүн болон санхүүгийн бусад үйлчилгээнүүдийн тусламжтайгаар салбар, сүлжээгээ өргөжүүлэн, бүтээгдэхүүнийхээ нэр төрөл, чанар, баглаа боодлоо сайжруулан баруун бүсийн иргэдийг өөрсдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр хангах зорилгоо хэрэгжүүлэх болно” гэсэн итгэлээр дүүрэн ажиллаж байна.

”



ЦАХИМ БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

2014 онд ХасБанк нь цахим сувгийн үйлчилгээний нэр төрлийг олшруулах, хамрах хүрээг өргөжүүлэх, найдвартай ажиллагааг сайжруулах чиглэлээр хөрөнгө оруулалт хийж, амжилттай гүйцэтгэсэн жил боллоо. Банкны нийт гүйлгээнд эзлэх цахим сувгийн гүйлгээ 60 хувьд хүрсэн нь өмнөх оноос 14 нэгжээр нэмэгдсэн байна.

ИНТЕРНЕТ БОЛОН МОБАЙЛ БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

Оны эхэнд интернет банкны системийг бүрэн шинэчилж, үйлчилгээний нэмэлт боломжуудыг агуулсан шинэ хувилбарыг нэвтрүүллээ. Шинэчилсэн интернет банкны системийн хамгаалалт, аюулгүй ажиллагаа улам сайжирч, харилцагчдад олон төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг цахим сувгаар авах боломжийг бий болгохын зэрэгцээ, ухаалаг утсанд зориулсан хувилбарыг өөрийн гар утсанд суулгаж илүү хялбар аргаар ашиглах боломжийг бүрдүүллээ.

Тайлант хугацаанд интернет банкны хэрэглэгчийн тоо 59.0 хувиар, нийт гүйлгээний тоо 94.1 хувиар өссөн бол харилцагчийн дансанд хийгдсэн гүйлгээ, төлбөр тооцоог мэдээлэх ХасИнфо үйлчилгээгээр 100 мянга гаруй харилцагчид 2.7 сая мэдэгдлийг цаг тухайд нь хүргэж ажиллалаа.

Мөн мобайл банкны Амар үйлчилгээний хэрэглэгчийн тоо 187.3 мянгад хүрч, нийт 900 гаруй мянган удаагийн хандалтад гүйлгээ, дансны мэдээллийн үйлчилгээ үзүүлсэн байна.

КАРТЫН ҮЙЛЧИЛГЭЭ

2014 онд ХасБанк нь картын үйлчилгээг харилцагчдад улам ойртуулах, картаар үйлчлэх цэгийг өргөжүүлэх зорилт тавьж ажиллалаа. ПОС терминалыг 40 хувиар нэмэгдүүлснээр картаар үйлчлэгч байгууллагын тоог 1,892-т хүргэж, АТМ-ийн сүлжээг 140 болгож өргөжүүллээ.

Карт эзэмшигчдийн тоо 13.3 хувиар өсч 200.6 мянгад хүрсэн бол картаар үйлчлэгч байгууллагын гүйлгээ 1 дахин, АТМ гүйлгээ 23.9 хувиар өссөн байна.

ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ

Харилцагчийн үйлчилгээний төв (1800-1888) нь 400 мянга гаруй дуудлагыг 24 цагийн горимоор хүлээн авч, банкны бүтээгдэхүүн үйлчилгээний мэдээлэл хүргэхийн зэрэгцээ, харилцагчдын санал хүсэлтийг 99.5 хувийг бүрэн шийдвэрлэж ажиллалаа.

Харилцагчдад шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ таниулах, карт болон цахим банкны үйлчилгээтэй холбоотой мэдээллийг цаг тухайд нь хүргэх, үйлчилгээний чанарыг хэмжих чиглэлээр 25 мянга гаруй харилцагчтай шууд холбогдож үйлчилгээ үзүүлсэн байна.

БИЗНЕСИЙН БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

КОРПОРЕЙТ БАНКНЫ ГАЗАР

Корпорейт банкны газар нь 2014 онд бүтэц, зохион байгуулалтын томоохон өөрчлөлтийг хийж, өөрийн үйл ажиллагаагаа харилцагчдад чанартай үйлчилгээ үзүүлэхэд илүүтэй чиглүүллээ.

Нэгдүгээрт, харилцагч бүр хариуцсан “ЭЗЭН” буюу харилцааны менежертэй байх, харилцааны менежерүүд нь харилцагчийн хэрэгцээ шаардлагыг таньж мэдэх, түүнд тохирсон санхүүгийн цогц үйлчилгээг санал болгодог тогтолцоог шат дараатайгаар хэрэгжүүлж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэв. Харилцааны менежер бүр ажлын цагийнхаа дийлэнх хувийг харилцагчаа халамжлах, түүнд туслахад зарцуулсанаар бид харилцагч бүрийнхээ хэрэгцээ, шаардлагыг ойлгож, түүнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх бололцоо бүрдлээ.

Хоёрдугаарт, бизнесийн тодорхой салбаруудад дагнан үйлчилгээ үзүүлэх 4 нэгжийг бий болгож, дараах бизнесийн салбаруудыг хариуцан ажиллаж байна. Үүнд:

- Нэгж 1: Барилга, үл хөдлөх хөрөнгө, газар тариалан;
- Нэгж 2: Үйлдвэрлэл, үйлчилгээ;
- Нэгж 3: Худалдаа, хүнсний үйлдвэрлэл;
- Нэгж 4: Уул уурай, дэд бүтэц.

Энэхүү өөрчлөлт нь болзошгүй эрсдлийг оновчтойгоор удирдах, харилцагчдад мэргэжлийн зөвлөгөө, зөвлөмжийг өгөх, бодит хэрэгцээнд нийцсэн санхүүгийн үйлчилгээ үзүүлэх бололцоог олгож байгаа юм.

Корпорейт харилцагчдын дунд банкны нэр хүнд улам нэмэгдлээ. Бизнесийн салбар бүрт тэргүүлэх байр суурьтай аж ахуйн нэгж, байгууллагууд ХасБанктай хамтран ажиллах болсон нь үүний гол нотолгоо юм.



“ Жишээлбэл: Монгол Улсын Засгийн газрын экспортыг дэмжих бодлогын хүрээнд Үндэсний томоохон үйлдвэрлэгчдийн нэг “Тэсо” корпорацийн охин компани болох Агь ХХК нь үйлдвэрлэлийнхээ хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор банкнаас нийт 2.2 сая орчим ам.долларын санхүүжилт авлаа. Энэхүү санхүүжилтийн үр дүнд тус компанийн үйлдвэрлэдэг Лапша брэнд гоймонгийн чанар сайжирч, Япон Улсад экспортлох боломжтой болсон бөгөөд Япон улсын оюуны өмчийн газарт албан ёсоор бүртгэгдэж гэрчилгээ авч чанар нь баталгаажлаа. Цаашид Агь ХХК нь зөвхөн Япон улсад төдийгүй олон улс оронд экспортлох төлөвлөгөөтэй байна. ”

Зах зээлд банкны нэр хүнд өсөхөд гол нөлөө үзүүлсэн хүчин зүйлс:

- о Компанийн засаглал, бизнесийн ёс зүй;
- о Хэрэгцээнд тохирсон цогц үйлчилгээ, бүтээгдэхүүний давуу тал;
- о Чадварлаг боловсон хүчин, харилцагчийн үйлчилгээ зэрэг юм.


Гадаад харилцаа, хамтын ажиллагаа өргөжин тэлсэн жил боллоо. Тайлант хугацаанд гадаад худалдааны санхүүжилтийн шугамын хэмжээг нийт 20.0 сая ам.доллараар нэмэгдүүлэв. Түүнчлэн худалдааны санхүүжилтийн чиглэлээр Европ тивийн тэргүүлэгч банкуудын нэг Commerz банктэй корреспондент харилцаа эхэлж, худалдааны санхүүжилтийн шугам нээснээр харилцагчийн төлбөр тооцоо хурдан шуурхай, хямд хийгдэх боломж бүрдлээ.

БИЗНЕСИЙН БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

Монгол Улсын арилжааны бүх банкууд үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр зорьж буй Тогтвортой санхүүжилтийн (ТОС) чиглэлээр бодитой арга хэмжээнүүдийг авч ажилласан. Олон Улсын Санхүүгийн Корпорацийтай хамтран нийт 30 гаруй байгууллагад Тогтвортой санхүүжилтийн зөвлөгөө, сургалт зохион байгууллаа. Ялангуяа энэ чиглэлээр мэргэшсэн инженерүүдтэй хамтран ажиллаж, харилцагчийн бизнестэй танилцан технологийн шинэ боломжуудын талаар тодорхой зөвлөмжүүд өгч ажилласан нь үр дүнтэй байв. Түүнчлэн ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг компаниуд байгаль орчинд ээлтэй технологийг хэрхэн үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн туршлагыг газар дээр нь судлах арга хэмжээг Олон Улсын Санхүүгийн Корпорацийн БНХАУ дахь төлөөлөгчийн газартай хамтран зохион байгуулсан нь харилцагчдын сэтгэлд хүрсэн арга хэмжээ боллоо.

Хамтын ажиллагаа харилцан ашигтай байх зарчмыг баримтлан харилцагчдад зориулсан санхүүгийн зөвлөгөөг үнэ төлбөргүй өгч ажилласан. Худалдааны санхүүжилтийн бүтээгдэхүүн, түүний боломжуудыг харилцагчдад таниулах сургалтыг үргэлжлүүлэн явууллаа. Түүнчлэн олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтран “Хамтын санхүүжилт”-ийн үйлчилгээг харилцагчдад санал болгов. Үүний үр дүнд харилцагчдын санхүүжилтийн зардал жилийн 5%-7%-иар буурч, харилцагчдад бодитой хэмнэлт, хуримтлал бий боллоо. Энэхүү боломжийг тайлант хугацаанд 20 гаруй харилцагч хүртсэн байна.

Корпорейт банкны газрын гол тоон үзүүлэлтүүдийг харуулбал:



#	Үзүүлэлтүүд	Өсөлт /хувиар
1	Харилцагчийн тоо	5%
2	Зээлийн багц	15%
3	Татан төвлөрүүлсэн эх үүсвэр	78%
5	Гадаад худалдааны санхүүжилтийн багц	232%
6	Гадаад худалдааны санхүүжилтийн орлого	78%

БИЗНЕСИЙН БАНКНЫ ГАЗАР

ХасБанкны хувьд 2014 он Байгууллагын зах зээл дэх өөрийн байр сууриа тасралтгүй бэхжүүлсэн жил боллоо.

Тайлант хугацаанд 3,600 орчим байгууллага шинээр харилцагч болж, 30%-ийн өсөлт хийснээр нийт харилцагч байгууллагын тоо 16 мянгыг давлаа. Харилцагчийн хамтын ажиллагааг урамшуулсан “Хас Түншлэл” хөтөлбөр, харилцагч байгууллагуудыг татах “Гинжин холбоо” аян зэрэг арга хэмжээнүүд нь энэхүү өсөлтөд гол нөлөө үзүүлсэн.

“Банкны шинэчлэл” төслийн хүрээнд жижиг, дунд бизнес эрхлэгчдэд үйлчилгээ үзүүлэх банкны бүтцэд томоохон өөрчлөлтүүд хийгдсэн. Жижиг бизнесүүдэд чиглэсэн сегментийн бодлогыг Иргэдийн банк хариуцан ажиллаж эхэллээ. Ингэснээр эдгээр бизнес эрхлэгчид өөрийн бизнест тохирсон стандарт үйлчилгээг сонгон үйлчлүүлэх боломжтой болохын зэрэгцээ илүү хялбар, түргэн шуурхай үйлчилгээ авах боломж бүрдэв. Харин дунд хэмжээний бизнес эрхлэгчдийн сегментийн бодлогыг хэрэгжүүлэх зорилготой Бизнесийн банкны газар нь өмнөх Жижиг, дунд бизнесийн банкны газрын бааз суурийг үндэслэн шинээр үүсгэн байгуулагдав. Тус газар нь үндсэн хоёр чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Нэгдүгээрт, байгууллагуудад зориулсан банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, нөхцлийг сайжруулах гэх мэт бүтээгдэхүүний удирдлагын бодлогыг хэрэгжүүлнэ. Хоёрдугаарт, дунд хэмжээний бизнес эрхлэгчдийг хариуцсан харилцааны менежерүүдийг томилж, түүгээр дамжуулан харилцагчдынхаа хэрэгцээ, шаардлагыг таньж мэдэх, түүнд тохирсон санхүүгийн шийдлийг санал болгохыг зорин ажиллаж байна. Өөрөөр хэлбэл дунд хэмжээний байгууллагуудад банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэх борлуулалтын чиг үүргийг гүйцэтгэх юм.

Бизнесийн банкны газар нь нийт 1,500 орчим дунд хэмжээний байгууллагыг зорилтот харилцагч болгон тодорхойлсон бөгөөд үүнээс 550 орчим байгууллагад 2014 онд банкны үйлчилгээг хүргэн ажилласан.

Харилцагчдад хүрч үйлчлэх, бизнес секторын онцлогт тохирсон бүтээгдэхүүн үйлчилгээ санал болгох үүднээс өнгөрсөн онд бизнесийн байгууллагуудын нэгдсэн холбоотой хамтран ажиллах ажлыг эхлүүлэн “Монголын авто замчдын холбоо”, “Тариаланчдын холбоо”, “ Аялал жуулчлал, зочид буудлын нэгдсэн холбоо”, “Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо”-той хамтын ажиллагааны гэрээ байгуулан хамтарсан өдөрлөг уулзалт, семинаруудыг амжилттай зохион байгууллаа.

Харилцагчийн үйлчилгээг сайжруулах, санхүүгийн цогц үйлчилгээг харилцагч бүрт хүргэх зорилгоор байгууллага бүрийг хариуцсан харилцааны менежерүүдийг томиллоо. Томилогдсон харилцааны менежерүүд нь харилцагчийн хэрэгцээнд тохирсон банкны болон банкны бус санхүүгийн үйлчилгээг үзүүлэх, харилцагчдад зөвлөгөө өгч ажиллаж эхлээд байна. Уг өөрчлөлтийн хүрээнд борлуулалт болон харилцагчийн харилцаа хариуцсан ажиллагсдаа мэргэшүүлэх, чадавхижуулах зорилгоор сургалтуудыг шат дараатай зохион байгууллаа.

Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг урт хугацаат санхүүгийн эх үүсвэрээр дэмжих зорилгоор Засгийн газар, Монголбанк, Хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй төсөл, төсөлт хөтөлбөрүүд болон Жайка, Азийн хөгжлийн банкны төслийн санхүүжилтийн зээлүүд, Deutsche банкны хүлэмжийн хийг бууруулах хөнгөлөлттэй зээл, Японы Олон улсын хамтын ажиллагааны банкны импортын зээлийг харилцагчдад олгож байна. Мөн жижиг дунд үйлдвэрлэгчид зээл санхүүжилт авахад тулгардаг гол бэрхшээл болох барьцаа хөрөнгийн дутагдлыг Зээлийн батлан даалтын сан, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн Зээлийн баталгааны хөтөлбөрт тус тус хамруулж харилцагчийн бизнесийг дэмжин ажиллаж байна.

Монголын Маркетинг Менежментийн Хүрээлэнгээс хоёр жилд нэг удаа зохион байгуулдаг “Next Generation-2014” бизнес форумаас харилцагчдын өгсөн үнэлгээ, хөндлөнгийн экспертүүдийн дүгнэлтээр ХасБанк Жижиг, дунд бизнесийг дэмжигч шилдгийн шилдгээр шалгарч “ГРАН ПРИ” шагналыг хүртлээ.

Харилцагч байгууллагуудын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, тэдний урт хугацааны түншлэлийг урамшуулах зорилгоор 2013 оны 4 дүгээр сараас эхлэн “ХасТүншлэл” хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн цагаас 1,000 гаруй харилцагч тогтмол хамрагдаж, урамшуулалт хөтөлбөрийн үр шимийг хүртсэн байна. Банк тус хөтөлбөрийн хүрээнд 2014 онд 200 гаруй сая төгрөгийн урамшууллыг өөрийн бүтээгдэхүүн үйлчилгээгээр болон түншлэгч байгууллагуудын бүтээгдэхүүн үйлчилгээгээр харилцагч байгууллагууддаа хүргээд байна.



БИЗНЕСИЙН БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ



Онцлох харилцагч: Баянбүрд ногоон төгөл ХХК

Баянбүрд ногоон төгөл ХХК нь 2003 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд Улаанбаатар хот төдийгүй хөдөө орон нутгийн хэрэглэгчдээ экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүнээр хангах чиглэлээр 12 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байна.

Тус компани нь бүх төрлийн нарийн ногооны хүлэмжийн аж ахуй, жимс жимсгэнэ тариалалт, боловсруулалт болон мод бут, сөөг тариалалт, суулгалтын аж ахуйн үйл ажиллагааг явуулж байгаа бөгөөд хайлаас, шинэс, шар хуайс, интоор, буйлс, бургас, улиас зэрэг 10 гаруй нэр төрлийн 800,000 гаруй мод үржүүлэн Улаанбаатар хотын цэцэрлэгжилт, Монгол орны цөлжилтийн эсрэг өөрсдийн хувь нэмрээ оруулж байна.

2014 онд Засгийн газраас хэрэгжүүлсэн импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх зорилт бүхий 888 төсөлт хөтөлбөрийн хүрээнд тус компани хүлэмжийн аж ахуйн шинэ дэвшилтэд технологич бүхий Гедропон Лед гэрэл ашиглан бүх төрлийн Салатны навчыг тариалах шинэ үйлдвэрийн төслийг боловсруулж Банк санхүүжилтийг экологийн цэвэр бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх, төслийн ач холбогдол болон байгууллагын туршлагад тулгуурлан олгож хамтран ажиллаж байна.

Уг төсөл хэрэгжсэнээр Монгол Улсын хэрэглэгчид экологийн цэвэр бүтээгдэхүүнийг жилийн 4 улирлын турш үндэсний үйлдвэрээсээ авах боломжтой болсон төдийгүй төслийн хүчин чадлыг 100% ашигласан тохиолдолд дотоодын хэрэглээг бүрэн хангах боломжтой юм. Банкны зүгээс тус харилцагч байгууллагын үйл ажиллагааг дамжуулан хэрэглэгч, харилцагч нартаа экологийн цэвэр бүтээгдэхүүн хүргэж нөгөө талаас үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх үйлсд өөрсдийн хувь нэмрийг оруулсаар байна.

”

МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН УДИРДЛАГА

ORACLE®

Банкны өдөр тутмын үйл ажиллагааг дэмжин ажилладаг Flexcube 10.2 банкны үндсэн системийг Flexcube 12.01 хувилбарт шилжүүлэх төслийг амжилттай хэрэгжүүлэв. Банкны хэрэглэдэг олон систем, програмуудыг шинэ хувилбартай нийцүүлэх ажлыг багаараа амжилттай зохион байгуулж гүйцэтгэлээ. Ингэснээр банк ирээдүйн хөгжлийн сууриа улам баталгаажуулж харилцагчийн үйлчилгээгээ нэмэх, найдвартай, тасралтгүй ажиллагааг нэмэгдүүллээ.

Технологи хурдацтай хөгжиж буй үед банк харилцагчийг салбарт ирэлгүй үйлчилгээ авах боломжийг бүрдүүлж интернет банк болон мессеж банк үйлчилгээг өмнөх жилүүдэд нэвтрүүлсэн. 2014 онд энэ чиглэлээр интернет банкны үйлчилгээний боломжийг нэмж, iPhone, Android, Blackberry утсанд зориулсан мобайл банкны үйлчилгээг шинээр бий болгов.

Банк хоорондын бага дүнтэй гүйлгээг 24/7 онлайн горимд амжилттай шилжүүлэв. Харилцагчийн үйлчилгээний хурдыг нэмэх, тасралтгүй найдвартай ажиллагааг дэмжих чиглэлээр дотооддоо олон сайжруулалтыг амжилттай хийж гүйцэтгэлээ. Банкны дотуур холбооны Avaaya системийг халж Мобикомын Мобайл Оффис шийдэл амжилттай нэвтрүүлсэн.

Хэрэглээний программ хангамжийн лицензийг албан ёсны болгох төслийн хүрээнд Макрософт Корпорацтай Open Value Agreement гэрээ байгуулан лицензүүдийн худалдан авалтыг хийв.

ИРГЭДЭД САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ ХӨТӨЛБӨР



ТЭМҮҮЛЭЛ ХӨТӨЛБӨР

2009 оноос ХасБанк нь Дэлхийн Эмэгтэйчүүдийн банкттай хамтран 14-18 настнуудад санхүүгийн боловсрол эзэмшүүлэх Тэмүүлэл хөтөлбөрийг эхлүүлсэн билээ.

Тус санхүүгийн боловсрол эзэмшүүлэх хөтөлбөрийг 2013-2014 оны хичээлийн жилд Хөгжлийн Алтан Сан Холбоо ТББ нь ХасБанктай хамтран Улаанбаатар хотын 28, орон нутгийн 17-н ерөнхий боловсролын сургуулиудад амжилттай хэрэгжүүлж нийт 3,540 хүүхдийг хамрууллаа.



2013-2014 оны хичээлийн жилд Тэмүүлэл хөтөлбөрт Дорнод аймгийн 500 орчим хүүхэд хамрагдлаа.

АФЛАТОН ХӨТӨЛБӨР

Дэлхийн 100 оронд амжилттай хэрэгжиж буй 8-13 насны хүүхдүүдэд нийгмийн болон санхүүгийн боловсрол олгох Афлатон хөтөлбөрийг ХасБанк 2010 оноос эхлэн амжилттай хэрэгжүүлж байна.

2013-2014 оны хичээлийн жилд Хөгжлийн Алтан Сан Холбоо ТББ нь ХасБанктай хамтран Афлатон хөтөлбөрийг 15 ерөнхий боловсролын сургууль болон бусад сургалтын төвүүдээр дамжуулан 2,520 хүүхдэд амжилттай хүргэсэн.



Хүүхдэд нийгмийн болон санхүүгийн боловсрол олгох Афлатон хөтөлбөрт шинээр нэмэгдсэн Хэнтий аймгийн 4-р сургуулийн хүүхэд багачууд маань Афлатоны баяраа тэмдэглэж "юу мэдэж сурснаа" танилцуулж байна.

“

Хөтөлбөрт шинээр Хэнтий аймгийн 4-р сургууль нэмэгдэж, тус сургуулийн бага ангийн багш нар хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүллээ. 4-р сургуулийн багш нар нь зайны сургалт, зөвлөгөө авч багшийн гарын авлага, сурагчийн сурах бичиг, багц удирдамжийн тусламжтайгаар сургалтаа амжилттай хэрэгжүүлж чадсан юм. Тус сургуульд хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаанд нийт 1,200 орчим эцэг эхчүүд хамрагдаж, зохион байгуулагдсан үйл ажиллагаанд оролцон санхүүгийн боловсролын мэдээллүүдийг авсан байна.

”

Мөн тайлант хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хөтөлбөрийг хүргэх ажил амжилттай хэрэгжиж, Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29 дүгээр сургуулийн дотуур байрны 100 гаруй хүүхэд хөтөлбөрийг 2 үе шаттайгаар хүргэн нийгмийн болон санхүүгийн боловсролыг олголоо.

ХҮНИЙ НӨӨЦ



Нийт ажиллагчдын тоо

1,732



Тухайн сард
ажилласан
ажиллагчдын тоо

1,465



Хөлсөөр ажиллах
гэрээтэй
ажиллагчдын
тоо

50

Жирэмсний болон хүүхэд асрах,
урт хугацааны чөлөөтэй нийт
ажиллагчдын тоо



217



Эмэгтэй ажиллагчдын хувь

66%

Эрэгтэй
жиллагчдын тоо



542

Эмэгтэй
ажиллагчдын тоо



923



Төв алба

363



Арын алба

214



Улаанбаатар
хотын салбар,
тооцооны төв

373



Орон нутгийн
салбар,
тооцооны төв

515

Дээд түвшиний удирдлага



22

Дунд түвшиний удирдлага



93

Удирдах албан тушаал дахь
эмэгтэй ажилтны хувь



47%



Сургалтад хамрагдсан
ажиллагчдын тоо

2,155



Нийт зохион байгуулагдсан
сургалтын цаг

40,656

ХҮНИЙ НӨӨЦ

2013 оны 12 дугаар сарын эцэст ХасБанкны нийт ажиллагчдын тоо 1,533 байсан бол тайлант хугацаанд 1,465 болж буурсан. 2014 оны турш урт хугацааны чөлөө, жирэмсний амралттай, хүүхдээ асарч буй нийт 217 ажилтны ажлын байрыг хадгаллаа.

Өнгөрсөн оны 2 дугаар хагаст банкны үр ашгийг нэмэгдүүлэх, ажилтны бүтээмжийг өсгөх зорилгоор шинээр ажилтан сонгон шалгаруулж авахыг түр хугацаагаар зогсоосон хэдий ч банкны үйлчилгээний чанарыг бууруулахгүй байх зорилтынхоо хүрээнд тодорхой албан тушаалуудад ажилтан сонгон шалгаруулж авсаар байсан билээ.

Сонгон шалгаруулалтын үйл ажиллагааны үр дүн, чанарыг дээшлүүлэхийн тулд бид сонгон шалгаруулалтын хамгийн үр дүнтэй аргуудын нэг Ассессмент центрийн аргачлалыг цогцоор нь ашиглаж эхэллээ.

ХасБанк нь өдөр тутмын үйл ажиллагаандаа үнэт зүйлсээ эрхэмлэж, ажилагсдынхаа ажлын бүтээмжийг өндөр гүйцэтгэлтэй байлгах соёлыг төлөвшүүлж, тэднийг үнэлж хүндэтгэн, санаа бодлыг нь сонсдог байхын төлөө ажиллана.

СУРГАЛТ ХӨГЖИЛ, АЖИЛЛАГЧДЫН СЭТГЭЛ ХАНАМЖ

2014 онд сургалт хөгжлийн хувьд салбар тооцооны төвүүдийн бүтцийн өөрчлөлттэй уялдуулан фронт оффисын ажиллагчдын борлуулалтын техник, харилцагчийн үйлчилгээний үр чадварыг сайжруулах, удирдах ажиллагчдын манлайлах, удирдах үр чадварыг хөгжүүлэхэд чиглэгдсэн.

Тайлант хугацаанд 40,656 хүн/цагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 2,155 ажилтныг хамруулсан нь өмнөх онтой харьцуулахад 11.9 хувиар өссөн үзүүлэлт юм.

НИЙГМИЙН ХАНГАМЖ, ХӨНГӨЛӨЛТ УРАМШУУЛАЛ

ХасБанк ажиллагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгал, тэтгэврийн нэрийн дансны багц хөтөлбөрийг санал болгодог билээ. Эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалын хураамжыг банк бүрэн хариуцдаг бол 2007 оны 2 дугаар сараас хэрэгжүүлж эхэлсэн Тэтгэврийн нэрийн дансны хувьд тухайн ажилтны ажилласан жилээс хамаарч ажилтан сар бүр үндсэн цалингийхаа 1-ээс 3 хувийг дэд дансандаа орлогодох бөгөөд банк мөн ижил хэмжээгээр тус дансанд нь орлого хийдэг.

Нийт ажиллагчид, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн эрүүл саруул, бүтээлчээр ажиллаж, сайн сайхан амьдрах таатай орчин нөхцлийг бүрдүүлэх зорилготой “Сайн сайхан оршихуй” уламжлалт хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн нийт 1,900 орчим ажилтныг хамруулав. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд олон нийт, спортын арга хэмжээнийн зохион байгуулалтанд ажиллагчдын оролцоо жил ирэх тусам нэмэгдсэн нь сайшаалтай.

Банк ажиллагчдаа ажиллахад таатай орчин нөхцөлөөр хангахын тулд Төв албыг шинэ байранд орууллаа.

Хүний нөөцийн бодлогын дагуу ажиллагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд нийт 318 ажилтанд зах зээлийн үнээс харьцангуй хямдаар орон сууцыг худалдан авах нөхцлийг бүрдүүлж, Засгийн газраас хэрэгжүүлж буй ипотекийн зээлийн хөтөлбөр, мөн Банкны өөрийн эх үүсвэрээр олгох хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлсэн байна.





ЭХ ДЭЛХИЙ

ХасБанк нь нийгмийн хариуцлагаа өндөрт ухамсарлаж, Нэгдсэн Үндэсний Байгууллагаас санаачлан эхлүүлсэн Компанийн Нийгмийн Хариуцлагын чиглэлээр дэлхий дахины хамгийн том, сайн дурын хөдөлгөөн болох Даян Дэлхийн Гэрээний 10 зарчмыг үйл ажиллагаандаа хэвшүүлж, мөрдөж ирсэн төдийгүй, Дэлхийн Эдийн Засгийн Форумгаас санаачлан хэрэгжүүлж буй “Авилгын эсрэг түншлэл”-ийг бүрэн дүүрэн дэмжиж ажилладаг билээ.

ХҮНИЙ ЭРХ

Зарчим 1 Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах олон улсын тунхаглалуудыг хүндэтгэх дэмжих;

Зарчим 2 Бизнесийн үйл ажиллагааг хүний эрхийн аливаа зөрчлийн хамтрагч болгохгүй байх.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Зарчим 3 Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, хамтын хэлэлцээр байгуулах эрхийг үр ашигтайгаар хүлээн зөвшөөрөх;

Зарчим 4 Хүчээр болон албадан хөдөлмөрлүүлэх аливаа хэлбэрийг арилгах;

Зарчим 5 Хүүхдийн хөдөлмөрийг арилгах;

Зарчим 6 Ажил эрхлэх, албан тушаал хашихад ялгаварлан гадуурхах байдлыг арилгах.

БАЙГАЛЬ ОРЧИН

Зарчим 7 Бизнесийн үйл ажиллагаанд байгаль орчны аливаа өөрчлөлт доройтлоос урьдчилан сэргийлэх;

Зарчим 8 Бизнесийн үйл ажиллагаанд байгаль орчны хариуцлагыг өндөржүүлэх;

Зарчим 9 Байгаль орчинд ээлтэй технологийг хөгжүүлэх нэвтрүүлэх.

АВИЛГАЛ

Зарчим 10 Авилгал, хээл хахуулийн бүхэл хэлбэрийн эсрэг тууштай үйл ажиллагаа явуулах.

ЭКО БАНКНЫ САНААЧЛАГА

ХасБанк нь 2010 оноос эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүний хэрэглээ, нийлүүлэлтийг дэмжих санхүүгийн тогтолцоо бүрдүүлэхээр Олон Улсын байгууллагуудтай хамтран ажиллаж байна. 2013 онд Хүлэмжийн хийг бууруулах бизнесийн зээлийн хөтөлбөрийг Германы Дойче банктай хамтран эхлүүлсэн бөгөөд 2014 онд 9.7 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийг хүлэмжийн хийг бууруулах бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа эрхлэгч болон эцсийн хэрэглэгч аж ахуйн нэгжид олголоо.

2014 онд Цэвэр Агаарын Сан болон Дэлхийн банкны Улаанбаатар Цэвэр Агаар Төслийн санхүүжилтээр нийт 35,497 ширхэг эрчим хүчний хэмнэлттэй зуух болон 6,218 ширхэг усан халаалттай нам даралтын зуухыг гэр хорооллын өрхүүдэд түгээлээ. Ингэснээр 2010 оноос Монголын Мянганы Сорилтын Сан, Цэвэр Агаарын Сан, Дэлхийн Банкны "Улаанбаатар - Цэвэр Агаар Төсөл"-тэй хамтран хэрэгжүүлсэн Эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн борлуулах хөтөлбөрийн хүрээнд нийт 167,266 эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүнийг Улаанбаатар хотын гэр хорооллын 150,489 өрхөд борлуулаад байна. Ингэснээр бид Улаанбаатар хотын гэр хорооллын нийт айл өрхийн 80 гаруй хувьд хүрч ажиллав.

Судалгаагаар эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүнийг хэрэглэснээр гэр хорооллын нэг өрхийн жилд хэрэглэх түлшний зардлыг дунджаар 46 хувиар буюу 925,000 төгрөгөөр хэмнэж, энэхүү төслийн үр дүнд 2014 онд 330,000 тонн хүлэмжийн хийг бууруулсан тооцоо байна.

“

"Их тэнгэрийн хүч" ХХК нь анх 1996 онд талх, нарийн боовны үйлдвэрлэл чиглэлээр байгуулагдаж, 2007 оноос эхлэн нийтийн хоол, сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр үйл ажиллагаагаа өргөжүүлэн, 2012 оноос барилга угсралт, барилгын материалын үйлдвэрлэл болон сайжруулсан зуухны худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж эхэлсэн байна.

Тус компани нь анх 2007 онд эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлэх зорилгоор ХасБанкнаас бизнесийн зээл авч байсан бол 2009 онд тус банкнаас авсан зээлээр талх, нарийн боовны үйлдвэртээ шинэчлэл хийж, итали улсын тоног төхөөрөмжийг суурилуулжээ. Ингэснээр тус компаний үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдэж өдөрт 1,500-2,000 талх, 1,800 кг нарийн боов үйлдвэрлэх боломжтой болсон байна. Мөн 2014 онд ХасБанкны Хүлэмжийн хий бууруулах бизнесийн зээлийг авч Дэлхийн банкны "Улаанбаатар - Цэвэр Агаар Төсөл"-ийн сайжруулсан зуухны төсөлд оролцох эргэлтийн хөрөнгөтэй болж, нийт 1,250 ширхэг эрчим хүчний хэмнэлттэй зуух борлуулсан нь хүлэмжийн хийн ялгарлыг 6,689 тонноор бууруулсан байна.

"Их тэнгэрийн хүч" ХХК нь ХасБанкаар 12 жил тогтвортой үйлчлүүлж байгаа бөгөөд үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинэ салбарт бизнесээ эхлүүлэхдээ ХасБанкнаас зээлийн санхүүжилт аваад зогсохгүй, өөрийн борлуулж буй эрчим хүчний хэмнэлттэй зуухыг тус банкны санхүүгийн түрээсээр иргэдэд борлуулж байна. Түүнчлэн ХасБанкны 5 дахь жилдээ хэрэгжүүлж буй Эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн борлуулах хөтөлбөрт 2013 оноос эхлэн 2 дахь жилдээ амжилттай оролцож, хөтөлбөрийн хүрээнд эрчим хүчний хэмнэлттэй 2,400 ширхэг сайжруулсан зуухыг Улаанбаатар хотын 6 дүүргийн гэр хорооллын өрхүүдэд нийлүүлээд байна. ХасБанкны Эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн борлуулах хөтөлбөр нь Монголын Мянганы Сорилтын Сан, Цэвэр Агаарын Сан, "Улаанбаатар - Цэвэр Агаар Төсөл"-ийн санхүүжилтээр хэрэгжсэн хэд хэдэн төслөөс бүрдсэн хөтөлбөр юм. Тус компани нь уг хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхүүдэд сайжруулсан зуухыг хөнгөлөлттэй үнээр нийлүүлэхээс гадна 2012 оноос эхлэн Дархан, Эрдэнэт, Баянхонгор, Хөвсгөл, Булган аймгуудад сайжруулсан зуухыг үндсэн үнээр нь борлуулж нийтдээ 12 нэр төрлийн 10,000 орчим эрчим хүчний хэмнэлттэй зуух борлуулсан байна.

"Их тэнгэрийн хүч" ХХК-ийн Ерөнхий захирал Ж.Болормаа ХасБанкны талаар: "Манайх бараг л анх ХасБанк байгуулагдснаас хойш буюу 2003 оноос эхлэн харилцсан. Энэ хугацаанд ХасБанкнаас эргэлтийн хөрөнгө, санхүүгийн түрээс, тоног төхөөрөмжийн санхүүжилтын зээл авч ашиглаж байснаас гадна харилцах, хадгаламжийн данс, интернет банк, ажиллагсдынхаа цалингийн карт зэрэг олон төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг нь идэвхтэй ашиглаж ирсэн. Бизнесийг маань өгсөж уруудахад үргэлж хамт байсан ХасБанкны хамт олондоо талархснаа илэрхийлье. Ялангуяа эко бүтээгдэхүүн борлуулах хөтөлбөрт хамтран ажиллаж буй ХасБанкны Эко банкны хэлтсийн хамт олондоо баярлалаа гэж хэлье" хэмээжээ.

”

2014 ОНЫ НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Хүүхдийн санхүүгийн боловсрол Хүүхдүүдэд АФЛАТОН, ТЭМҮҮЛЭЛ хөтөлбөрөөр санхүүгийн боловсрол олгосон 38.000 	Соёл урлаг МОНГОЛЫН УРЛАГИЙН ЗӨВЛӨЛ Монголын Урлагийн Зөвлөлөөс санаачилан хэрэгжүүлдэг төслүүдийг жил бүр дэмжин ажилладаг.  Чойжин ламын музейн "ХАЙРЦАГ ДАХЬ МУЗЕЙ" төслийг ивээн тэтгэлээ.	Хас төгөл 2009-2014 оны хооронд орон даяар 27 ХАС ТӨГӨЛ байгуулж 32.000 мод бут тарьж ургуулсан Нийт тарьсан модны +80% ургасан 
Хасхүүгийн баяр "ХАСХҮҮГИЙН БАЯР"-ыг Монгол орон даяар зохион байгууллаа. 	Байгаль орчин Байгаль орчин, нийгэмд ээлтэй бизнесийг дэмжих зорилгоор хөнгөлөлттэй нөхцөлтэй төслийн зээлүүдийг олгож байна. Байгаль Орчны Мөнөйлөгч хөтөлбөрийг тууштай дэмжигч  НИЙСЛЭЛИЙН АГААРЫН БОХИРДОЛЫГ БУУРУУЛАХ ЗОРИЛГООР 2009-2014 ОНД 162.676 ЭКО БҮТЭЭГДЭХҮҮН БОРЛУУЛАН, 700.000 ТОНН ХҮЛЭМЖИЙН ХИЙГ БУУРУУЛЖ,	Спортыг хөгжүүлэх чиглэлээр  Сарсан бөмбөгийн баг Хөл бөмбөгийн баг Хоккейн баг  Дуулиан 2020 хөл бөмбөгийн тэмцээнийг 9 дахь жилдээ ивээн тэтгэлээ.
ХАС Холбоо ТББ Банкны ажиллагсдын үүсгэн байгуулсан, өөрсдийн цалингаас санхүүжүүлдэг ХАС Холбоо ТББ нь байгаль орчин, нийгэм болон хүүхдийн сайн сайхны төлөө үйл ажиллагаа явуулдаг. Нийт гишүүн 1,536	Хүүхдийн сайн сайхны төлөө  Сонголын бэрхшээлтэй 29-р сургуулийн дотуур байрыг тохижуулж өглөө.	Сайн сайхан оршихуйн хөтөлбөр  Нийт ажилтнуудын дунд эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг бий болгох зорилгоор цасны баяр, явган аялал, спортын 5 төрөлт урлагын наадам Хас цзм тэмцээнүүдийг уламжлал ёсоор зохион байгууллаа.
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд  Банк хараагүй иргэдийн хөдөлмөрөөр бүтсэн байгаль орчинд ээлтэй давуун тор ашиглаж байна.	39,6 тэрбум төгрөгийн түвшиний хэмнэлтийг хийсэн байна Монголд анх удаа агаарын бохирдол бууруулсны нөхөн төлбөр авахаар боллоо	

ПЛАНЕТ РЕЙТИНГИЙН ҮНЭЛГЭЭ

Франц улсад төвтэй Планет Рейтинг Олон Улсын Үнэлгээний байгууллагаар Нийгмийн хариуцлагын удирдлага, Санхүүгийн хүртээмжтэй байдал, Харилцагчийг хамгаалах буюу ёс зүйтэй бизнес, Хүний нөөцийн бодлого, Нийгэмд оруулж буй хувь нэмэр гэсэн үндсэн 5 үзүүлэлтийг агуулсан Нийгмийн хариуцлагын цогц үнэлгээг хоёр дахь удаагаа хийлгэж, “4” буюу Хангалттай гэсэн үнэлгээг авлаа.



ХасБанк нь 2010 онд Монгол улсад анх удаа энэхүү үнэлгээг хийлгэж байсан бөгөөд энэ удаад өмнөх үнэлгээгээ 1 шатаар ахиулж “4” болгосон нь нийгмийн хариуцлагаар Ази тивд хамгийн өндөр үнэлгээ, олон улсын түвшинд эхний 15-д орох үзүүлэлт болсон юм.

ШАГНАЛУУД



Монгол улсын Шилдэг Банк
Global Finance сэтгүүл



Европын бичил санхүүгийн 5 дахь
удаагийн дээд шагнал – Euro-
pean Microfinance Award



Хөгжиж буй орнууд дахь шилдэг
түнш – “Дэлхийн худалдааны
түншүүд” чуулга /ОУСК/



Ази тивийн шилдэг засаглалтай
компани - Capital Finance
International сэтгүүл



Жижиг Дунд Бизнесийг дэмжигч
Монгол улсын шилдэг банк -
Global Banking and Finance
Review awards



ТОП-150 ААН, ТОП-5 Банк -
Монгол улсын Засгийн Газар,
МҮХАҮТ



Банкны салбарын Оны онцлох
Энтрепренер – МҮХАҮТ





ЭРҮҮЛ АШИГ

Татварын дараах ашгийн хэмжээ 11.6 тэрбум төгрөгт хүрч, 2014 онд 8.2 тэрбум төгрөгийн орлогын албан татвар төлснөөр Монгол Улсын шилдэг 100 татвар төлөгч байгууллагаар дахин шалгарлаа.

МАКРО ЭДИЙН ЗАСАГ

Дэлхийн эдийн засаг 2013 оны өсөлтөө хадгалж 2014 онд 2.6 хувиар өслөө. Хөгжингүй орнууд болох АНУ-н эдийн засагт сэргэлт ажиглагдаж эхэлсэн бол Евро бүсийн өсөлт үргэлжлэн удааширсан жил болов. Түүнчлэн БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн идэвхжил удааширсантай холбоотойгоор эдийн засгийн өсөлт саарсан нь дэлхийн түүхий эдийн зах зээлд нөлөөлж, уул уурхайн голлох түүхий эдийн үнэ буурахад хүргэв.

Монгол улсын эдийн засаг 2013 онд 11.6 хувьтай өссөн бол 2014 онд саарч 7.8 хувиар өслөө. Эдийн засгийн өсөлтийг салбаруудаар авч үзвэл Уул уурхайн салбар 24.2 хувь, Хөдөө аж ахуйн салбар 14.4 хувиар өссөн бол бусад салбаруудын өсөлт дөрвөн улирал тасралтгүй буурч 1.8 хувийн өсөлтийг бий болголоо. 2014 оны эхнээс эдийн засгийн идэвхжил суларч дотоод эрэлт буурсан, төлбөрийн тэнцлийн хямралт нөхцөл байдал үргэлжилсэн нь эдийн засгийн өсөлт саарахад нөлөөлөв.

Тайлант онд Оюутолгойн зэсийн баяжмалын үйлдвэрлэл тогтворжиж нийт зэсийн экспорт 2 дахин өссөн нь нийт экспортыг 5,774 сая ам.долларт хүргэж, өмнөх оноос 35.3 хувиар өсөхөд нөлөөлөв. Харин импортын хувьд 5,237 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 17.6 хувиар буурахад хөрөнгө оруулалт болон нефтийн бүтээгдэхүүний импорт голлон нөлөөлөв. Өмнөх оноос гадаадын шууд хөрөнгө оруулалт 5.2 дахин буурсан, уул уурхайн томоохон төсөл хөтөлбөрүүдийн импортод үзүүлэх нөлөөлөл багассан зэрэг нь хөрөнгө оруулалтын болон нефтийн бүтээгдэхүүний импортын буурах шалтгаан болсон байна. Ийнхүү экспортын өсөлт, импортын бууралтаар гадаад худалдааны тэнцэл 538 сая америк долларын ашигтай гарсан нь урсгал тэнцэлийн алдагдлыг өмнөх онтой харьцуулахад 3.2 дахин бууруулсан байна. Гэсэн хэдий ч эдийн засагт орж ирэх валютын урсгал тодруулбал 2014 онд гадаадын шууд хөрөнгө оруулалт үргэлжлэн буурсан нь төлбөрийн тэнцэл алдагдалтай гарахад хүргэж, улмаар төгрөгийн америк доллартай харьцах ханшийг оны эхнээс 13.8 хувиар буюу 229 төгрөгөөр сулруулж, оны эцэст 1888.4 төгрөгт хүргэв.

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш ийнхүү суларсан нь эргээд валютын төлбөртэй худалдааны өртгийг нэмэгдүүлж улмаар инфляцийг өсгөх гол шалтгаан болов. Тодруулбал 2013 оноос Монголбанк, Засгийн газартай хамтран хэрэгжүүлсэн үнэ тогтворжуулах хөтөлбөр нь нийлүүлэлтийн гаралтай инфляцийн нөлөөллийг бууруулсан боловч, төлбөрийн тэнцлийн хүндрэлээс шалтгаалж төгрөгийн гадаад валюттай харьцах ханш суларсан нь импортын барааны үнийг өсгөж, улмаар эрэлтийн гаралтай инфляцид нөлөөлсөн байна. Иймээс 2014 оны 7 дугаар сард Монголбанкны зүгээс мөнгөний бодлогыг чангатгаж, бодлогын хүүг 1.5 нэгж хувиар нэмэгдүүлж 12 хувьд хүргэсэн нь оны эцэст жилийн инфляцийн түвшинг 11 хувьтай, мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг 12.5 хувьтай гарахад нөлөөлсөн байна.

Тайлант онд улсын төсвийн орлого 3.7 хувиар өсч 6.2 их наяд төгрөг, төсвийн зарлага 13.8 хувиар өсч 7.0 их наяд төгрөгт тус тус хүрснээр төсвийн алдагдал 886 тэрбум төгрөгт хүрсэн нь 2013 онтой харьцуулахад 3.5 дахин өссөн үзүүлэлт болов.

БАНКНЫ СЕКТОР

Тайлант онд банкны секторын активын хэмжээ 22.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 8.2 хувиар өслөө. Зээлийн өрийн үлдэгдэл 12.2 их наяд төгрөгт хүрч өмнөх онтой харьцуулахад 17.2 хувиар өсч, ДНБ-н 55.8 хувьтай тэнцэж байна. Нийт харилцах, хадгаламж 10.1 их наяд төгрөгт хүрч өмнөх онтой харьцуулахад 14.2 хувиар өссөн нь ДНБ-н 46.2 хувьтай тэнцэж байна.

Чанаргүй зээлийн хэмжээ оны эхнээс 126 тэрбум төгрөгөөр өсч 384 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 3.1 хувийг бүрдүүлж байна. Он дамжсан төлбөрийн тэнцлийн хүндрэл үргэлжилсэн, эдийн засгийн идэвхжил саарсан нь Уул уурхай болон Худалдааны салбарын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж уг салбаруудын чанаргүй зээлийн хэмжээг өсгөснөөр нийт чанаргүй зээлийн дөрөвний гурвыг бүрдүүлсэн байна.

Банкны салбарын өөрийн хөрөнгийн хэмжээ тайлант оны эцэст 2.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 35.9 хувь буюу 617 тэрбум төгрөгөөр нэмэгдэв. Түүнчлэн банкны салбарын нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 12.5 хувь, нийт өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 17.7 хувь байгаа нь Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээс 3.5 болон 5.7 нэгж хувиар тус тус дээгүүр байлаа. Мөн Банкны системийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа тайлант оны эцэст 33 хувьд хүрсэн нь Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтээс даруй 8.0 нэгж хувиар дээгүүр байлаа. Банкууд хөрвөх чадвар сайтай, эрсдэлгүй санхүүгийн хэрэгсэлд хийсэн хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа үзүүлэлт 2012 оны эцсээс тогтвортой нэмэгдсэн байна.

2014 оны макро эдийн засгийн гүйцэтгэл

Дотоодын Нийт Бүтээгдэхүүн	2011	2012	2013	2014*
Бодит ДНБ (тэрбум ₮)	11,443.6	12,853.4	14,350.1	15,472.9
Эдийн засгийн өсөлт (%)	17.3%	12.3%	11.6%	7.8%
ХАА	-0.3%	21.1%	19.3%	14.4%
Уул уурхай	7.7%	8.3%	19.4%	24.2%
Аж үйлдвэр	7.9%	8.7%	10.9%	3.0%
Барилга	22.7%	85.3%	8.2%	1.0%
Үйлчилгээ	46.4%	12.0%	6.5%	-6.9%
Тээвэр	15.1%	8.1%	-1.7%	23.5%
бусад	20.5%	8.6%	10.5%	1.8%
Мөнгөний нийлүүлэлт	2011	2012	2013	2014*
M2 мөнгөний нийлүүлэлт (тэрбум ₮)	6,412.3	7,617.3	9,451.0	10,635.8
M2 мөнгөний нийлүүлэлт (%)	37.0%	18.8%	24.1%	12.5%
Инфляци (%)	10.2%	14.0%	12.5%	11.0%
Бодлогын хүү(%)	12.3%	13.3%	10.5%	12.0%
Төсвийн орлого, зарлага	2011	2012	2013	2014*
Төсвийн орлого (тэрбум ₮)	4,400.6	4,957.8	5,986.9	6,145.1
Төсвийн зарлага (тэрбум ₮)	4,792.0	5,993.8	6,164.7	7,031.4
Төсвийн тэнцэл (тэрбум ₮)	-391.4	-1075.7	-250.4	-808.0
Гадаад худалдаа	2011	2012	2013	2014*
Нийт экспорт (\$ сая)	4,817.5	4,384.6	4,272.7	5,774.6
Нийт импорт (\$ сая)	6,598.4	6,738.9	6,354.7	5,236.6
Худалдааны тэнцэл (\$ сая)	-1,746.5	-2,354.3	-2,082.0	537.9
Төлбөрийн тэнцэл	2011	2012	2013	2014*
Ам.долларын төгрөгтэй харьцах ханш	1,396.4	1,392.1	1,659.3	1,883.0
Гадаад валютын албан нөөц (\$ сая)	2,450.6	4,125.8	2,248.0	1,649.9
Гадаадын шууд хөрөнгө оруулалт (\$ сая)	4,620.1	4,407.8	2,098.1	541.8
Банк, санхүүгийн салбар**	2011	2012	2013	2014*
Нийт актив (тэрбум ₮)	9,130.4	11,659.2	20,850.4	22,562.6
Зээлийн өрийн үлдэгдэл (тэрбум ₮)	5,272.6	6,587.4	10,407.8	12,200.0
Чанаргүй зээл (тэрбум ₮)	157.9	143.0	258.0	383.8
Чанаргүй зээлийн харьцаа үзүүлэлт(%)	3.0%	2.2%	2.5%	3.1%
Харилцах, хадгаламж (тэрбум ₮)	5,593.8	6,258.8	8,840.4	10,091.7

Тэмдэглэл:
Урьдчилсан гүйцэтгэл (*)

Татан буугдсан банкуудыг
/Анод, Зоос, Хадгаламж/ хассан дүнгээр(**)

Эх сурвалж:
Монголбанк, Үндэсний Статистикийн Хороо

САНХҮҮГИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Сая төгрөгөөр	2012	2013	2014	Өөрчлөлт	
				2013	2014
Нийт актив	1,077,703	1,811,485	2,072,815	68.1%	14.4%
Зээлийн багц	632,552	1,042,170	1,352,343	64.8%	29.8%
Харилцах, хадгаламж	513,791	635,367	788,367	23.7%	24.1%
Өөрийн хөрөнгө	97,833	122,205	133,841	24.9%	9.5%
Цэвэр ашиг	15,247	24,372	11,636	59.8%	-52.3%
Өөрийн хөрөнгийн өгөөж	1.7%	1.8%	0.6%	0.1%	-1.1%
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	19.5%	16.2%	17.0%	-3.3%	0.8%
Чанаргүй зээлийн харьцаа	1.3%	1.4%	3.7%	0.1%	2.3%
Эрсдэл даах чадварын харьцаа	105.7%	123.5%	95.2%	17.8%	-28.2%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	42.3%	43.8%	37.2%	1.5%	-6.6%

Тайлант жилд Банкны нийт хөрөнгө 14.4 хувиар өсч, 2.1 их наяд төгрөгт хүрэв. Харилцах хадгаламж 24 хувиар өсч, активийн өсөлтийг голлон санхүүжүүлсний зэрэгцээ гадаадын банк санхүүгийн байгууллагуудаас 160 сая ам.долларын эх үүсвэрийг татан төвлөрүүлээ.

Зээлийн багц 30 хувиар өссөнөөс иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 185 тэрбум төгрөг буюу 37 хувиар нэмэгджээ. Түүнчлэн ААН, байгууллагуудад олгосон зээлийн багц 120 тэрбум төгрөгөөр өссөн бөгөөд төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн хэлбэлзэл нь гадаад валютаар илэрхийлэгдэх зээлийн багцын өсөлтийг хязгаарлах хүчин зүйл боллоо. Жилийн эхэнд төгрөг болон ам.доллараар олгосон зээлийн багцын үлдэгдэл 67:33 харьцаатай байсан бол Банк эрсдлийн удирдлагын бодлогын хүрээнд ам.долларын багцын өсөлтийг хязгаарласнаар жилийн эцэст дээрхи харьцаа 81:19-т хүрсэн юм.

Эдийн засгийн зогсонги байдал болон дотоодын мөнгөн тэмдэгтийн ханшийн уналт зэрэг нь зээлийн чанарт дарамт учруулах хүчин зүйлс байлаа. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 2013 онд 1.4 хувь байсан бол 2014 онд 3.7 хувь болж нэмэгдсэн юм. Энэхүү нөхцөл байдалд Банк болзошгүй эрсдэлээс хамгаалахын тулд өмнөх жилтэй харьцуулахад гурав дахин өндөр дүнгээр эрсдэлийн сангаа нэмж байгуулснаар эрсдэл даах чадварын харьцааг 95 хувьд хадгаллаа.

Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар хангалттай өндөр түвшинд буюу 37 хувьд, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээс даруй 12 нэгж хувиар өндөр байлаа. Банк зах зээлийн тогтворгүй нөхцөл байдалд хөрвөх чадвараа хадгалахын тулд шат дараатайгаар зээлийн нөхцөлөө чангаруулж, шинээр олгож буй зээлийн хэмжээгээ эргэн төлөлттэй уялдуулах арга хэмжээнүүдийг авсаар ирсэн юм.

Тайлант хугацаанд Банк зээлийн эрсдэлийн сангаа 30 тэрбум төгрөгөөр нэмж байгуулсан бөгөөд 11.6 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллалаа. Эдийн засгийн орчин болон төгрөгийн ханшийн хэлбэлзэл зэргээс шалтгаалан өндөр дүнгээр эрсдэлийн сангаа нэмэгдүүлэх шийдвэрийн ашигт ажиллагаанд нөлөөлөх нөлөөлөл өндөр байв. Татвар болон эрсдэлийн сангийн зардлын өмнөх ашиг 42.2 тэрбум төгрөг байгаа нь өмнөх онтой харьцуулахад 7 хувиар өссөн үзүүлэлт юм. Тайлант жилийн дүнгээр өөрийн хөрөнгийн өгөөж 9 хувьд хүрсэн бол зардлын үр ашгийн үзүүлэлт сайжирч 61 хувиас 56 хувьд хүрч буурлаа.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Банкны эрсдэлийн удирдлагын үндсэн чиг үүрэг нь санхүүгийн болон санхүүгийн бус эрсдэлийг зохистой түвшинд удирдахын зэрэгцээ, бизнесийн нэгжүүдэд стратеги, төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг тусалцаа үзүүлэхэд оршино. Үүний дагуу зээл, үйл ажиллагаа, хянан нийцүүлэлт, хөрвөх чадвар болон бусад учирч болзошгүй эрсдэлүүдийг удирдахад шаардагдах зохистой бодлогуудыг боловсруулж, тэдгээрт эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан оруулах нэмэлт өөрчлөлтүүдийг цаг тухайд нь хийж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах үүрэгтэй байдаг.

Түүнчлэн Банкны эрсдэлийн удирдлагын бас нэгэн нэн тэргүүний зорилго нь дотоод болон олон улсын хууль, хяналтын байгууллагаас тавьсан шаардлага, мөн банкны эрсдэл даах чадварын талаарх нэгдмэл ойлголтыг банкны нийт ажиллагсдын хүрээнд бий болгоход оршино. Энэхүү зорилгын хүрээнд эрсдэлийн удирдлагын зохистой бодлогуудыг боловсруулахаас гадна, эрсдэлийн удирдлагын талаарх нийт ажиллагсдын ерөнхий мэдлэг болон чадавхыг дээшлүүлэх, зохистой эрсдэлийн удирдлагад ажилтан бүрийн оролцоо, үүрэг хариуцлагыг танин мэдүүлэх танхимын болон зайны сургалтуудыг зохион байгуулж ажиллалаа.

ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Банкны хөрөнгийн томоохон хувийг харилцагчдад олгосон зээлийн багц бүрдүүлдэг тул зээлийн эрсдэл нь бидний удирдах нэн чухал эрсдэл юм. Банк нь зээлийн эрсдэлийг зээлдэгчийн гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаандаа биелүүлээгүйгээс үүсэх алдагдлыг хүлээх эрсдэл гэж тодорхойлдог. Бид зээлийн эрсдэлийг удирдахад шаардагдах зээлийн зохистой бодлогуудыг тодорхойлж, зээл олголт, түүний дараах гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлэх байдлаар зээлийн эрсдэлийг удирдаж байна. Түүнчлэн зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор зээлийн эрсдэлийн удирдлага болон хяналтын арга, арга хэмжээг хэрэгжүүлснээр банкны Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс тогтоосон зээлийн эрсдэлийн хязгаар үзүүлэлтүүд болон Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг биелүүлэн ажиллаж байна.

2014 онд хэрэгжүүлсэн банкны бүтцийн өөрчлөлтийн үр дүнд Иргэд, Бизнес/Байгууллагын банкны бизнесийн чиглэлүүдийг салгаж, тус бүр нь төвлөрсөн зээл олголт, зээлийн эргэн төлүүлэх үйл ажиллагаа болон зээлийн эрсдэлийн удирдлагыг хариуцах нэгжүүдтэй боллоо. Бүтцийн өөрчлөлтийн хүрээнд Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй салбар, тооцооны төвийн иргэдийн зээлийн хүсэлтийг шийдвэрлэх, эрсдэлийг удирдах процессийг Иргэдийн банкинд төвлөрүүлснээр зээлийн ажилтнуудын бүтээмж дээшилж, банкны үйл ажиллагааны зардлын үр ашгийн үзүүлэлт 2013 оны эцэст 60.8 хувь байснаас 2014 оны эцэст 56.2 хувь хүртэл буурч сайжирсан дүр зургийг харууллаа.

Энэхүү бүтцийн өөрчлөлтийн нэг давуу тал нь Зээлийн эрсдэлийн удирдлагын газар нь бизнесийн томоохон зээлийг олгох, олгосон зээлүүдэд хяналт тавихад төвлөрөн ажиллах боломжтой болсон нь нийт зээлийн багцын тал гаруй хувийг бүрдүүлж буй дунд болон байгууллагын зээлийн багцын эрсдэлд анхааран ажиллах шаардлагад нийцсэн юм.

Түүнчлэн Банк нь тайлант онд макро-эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан хөрөнгийн өсөлтийг хангахаас илүүтэйгээр зээлийн багц, багцын чанарыг хадгалж үлдэхэд чиглэсэн төсвийн зорилтоо шинэчлэн батлуулан ажиллав. Зээлийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн гол арга хэмжээнүүдийн нэг нь гадаад валютаар олгосон зээлийн багцын нийт зээлийн багцад эзлэх хувийг 37 хувиас 19 хувь хүртэл бууруулах явдал байлаа. Мөн түүнчлэн, зээл эргэн төлөгдөхөд учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах эрсдэлийн сангийн хэмжээг хангалттай түвшинд буюу нийт чанаргүй зээлийн багцын 100 хувьтай тэнцэх хэмжээнд байгуулах чиглэлтэй ажиллав. 2013 оны эцэст нийт чанаргүй зээлийн багцын 123.5 хувьтай тэнцэх хэмжээний зээлийн эрсдэлийн санг байгуулж байсан бол эдийн засгийн хямралын улмаас 2014 оны эхний хагаст 51.3 хувь хүртэл буурсан үзүүлэлтийг банкны зүгээс эрсдэлийг удирдах зохистой арга хэмжээг цаг тухайд нь авч хэрэгжүүлснээр 2014 оны эцэст энэхүү харьцаа үзүүлэлтийг 95.2 хувь хүргэн өсгөсөн ба цаашид тогтмол 100-аас дээш хувийн зээлийн эрсдэлийн санг байгуулах зорилгыг баримтлан ажиллаж байна.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ХӨРВӨХ ЧАДВАРЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Тайлант онд эдийн засгийн таагүй нөхцөл байдал болон төгрөгийн америк доллартай харьцах ханшийн сулрал үргэлжилсэн, банкны секторын хэмжээнд харилцах, хадгаламжийн тогтворгүй байдал нэмэгдэж, өсөлт удааширсан нь Банкнаас хөрвөх чадварын эрсдэлийг зохистой түвшинд удирдан ажиллахыг шаардсан жил байлаа. Энэ нөхцөл байдалтай уялдуулан бид төгрөг болон гадаад валют дээрх хөрвөх чадвартай активыг хангалттай түвшинд хадгалж, түүнчлэн Монголбанкнаас тогтоосон хөрвөх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтмол давуулан биелүүлж ажиллалаа.

Банкны хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын гол зорилго нь зах зээлийн хэвийн болон хэвийн бус нөхцөлд банк санхүүгийн хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж чадахуйц бэлэн мөнгө болон түүнтэй адилтгах хөрвөх чадвартай хөрөнгийг зохистой түвшинд байлгах, нөгөө талаас банкны ашигт ажиллагааг тогтвортой түвшинд барихад чиглэгддэг. Энэ зорилгын хүрээнд, бид ирээдүйд үүсч болзошгүй нөхцөл байдлын талаарх төсөөлөлд тулгуурласан цэвэр мөнгөн урсгалыг тооцож, эх үүсвэрийн төвлөрөл болон хугацаанаасаа өмнө цуцлагдах байдалд дүн шинжилгээ хийж, хөрвөх чадварын зохистой хязгаар үзүүлэлтүүдийг тогтоон, түүний биелэлтэд тогтмол хяналт тавин ажилладаг. Үүний зэрэгцээ, өнөөгийн тогтворгүй зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан хадгаламжийн багцад үүсэх гэнэтийн гарах урсгалыг даах зорилгоор хөрвөх чадварын хувьд тодорхой хэмжээний нэмэлт нөөцийг хадгалан ажиллав.

ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Тайлант хугацаа нь Банкны зах зээлийн эрсдэлийн удирдлагаас нэг талаас гадаад валютын зээлийн багцыг бууруулах боломжийг бий болгох, нөгөө талаас үүсэх гадаад валютын нээлттэй позици болон хүүний эрсдэлийг оновчтой түвшинд удирдахыг шаардсан жил байлаа. Иймээс бид 2014 онд авсан олон улсын санхүүгийн эх үүсвэрүүдийг Монголбанкны урт хугацаат своп хэлцэлийн тусламжтайгаар төгрөгт хөрвүүлснээр нэг талаас төгрөгийн эх үүсвэрийг дэмжих, нөгөө талаас харилцагчдад олгосон гадаад валютын зээлийг төгрөгт хөрвүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх болон үүсэх гадаад валютын позицгийг удирдах арга хэмжээг авч хэрэгжүүлээ. Түүнчлэн, валют хоорондын своп хэлцэлээр гадаад валютын активыг төгрөгийн орлого олдог активд байршуулах замаар гадаад валютын өгөөжийг нэмэгдүүлэх зарчмыг баримтлан хүүний эрсдэлийг удирдан ажиллаа.

Банкны гадаад валютын ханшийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэгч нэгж нь Хөрөнгө зохицуулалтын газар ба Актив Пассивийн Удирдлагын Хороо нь сарын давтамжтайгаар эрсдэлийн түвшинг хянаж, түүнийг зохистой удирдах арга хэмжээг боловсруулан, хэрэгжилтэнд хяналт тавьж ажилладаг. Үүнээс гадна, банк нь ханшийн тэгшитгэлээс үүсэх алдагдал болон нээлттэй позицгийн эрсдэлээр жигнэсэн активд үзүүлэх нөлөөг Монголбанкны тусгай зөвшөөрөлтэйгөөр “Хамгийн Их Эрсдэл”(ХИЭ) буюу “Value at Risk” (VaR) аргаар тооцдог бөгөөд энэхүү зөвшөөрлийг 2011 оноос тууштай хадгалан ажиллаж байна. ХИЭ-ийн аргачлалын найдвартай байдал болон таамаглах чадварыг үнэлэхийн тулд бид тухайн өдрийн ХИЭ утгыг бодит ашиг/ алдагдалтай харьцуулан, аргачлалаа буцаан шалгаж үр дүнг Монголбанкинд сар бүр тайлагнадаг.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Бизнесийн байгууллагуудын нэгэн адил Банк нь хүний хүчин зүйл, дотоод процесс, мэдээллийн технологи болон гадаад хүчин зүйлсээс үүдэлтэй эрсдэлүүдийн нөлөөн дор өдөр тутмын үйл ажиллагаагаа явуулж байдаг.

Эдгээр эрсдэлийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, цаашлаад үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцоог ахисан төвшинд хүргэх зорилгоор Банк нь Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын бодлого болон холбогдох эрх зүйн актуудыг Монголбанк болон Базелийн банкны хяналт шалгалтын хорооноос тодорхойлсон шаардлага болон стандартад нийцүүлэн шинэчлэн боловсрууллаа.

Шинэчлэн боловсруулсан эрх зүйн актуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх мөн нийт ажиллагсдад үйл ажиллагааны эрсдэлийн талаарх мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор тогтмол байдлаар үргэлжлэх танхимын болон зайны сургалтуудыг эхлүүллээ.

Бизнесийн нэгжүүдэд үүсч болзошгүй үйл ажиллагааны эрсдэлийг илрүүлэх болон удирдахад дэмжлэг үзүүлэх зорилгоор үйл ажиллагааны эрсдэлийн тохиолдлуудыг цуглуулах, нэгтгэх мөн түүнд дүн шинжилгээ хийх ажил хийгдэж байна. Ийнхүү эрсдэлийн мэдээллийн санг бий болгож байгаа нь эрсдэлийг илрүүлэхэд туслалцаа үзүүлэхээс гадна үйл ажиллагааны эрсдэлийн санг тооцох ахисан түвшний аргачлалыг нэвтрүүлэх үндэс суурь болох юм.

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын гол процесс болох өөрчлөлтийн болон үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээг тодорхой бүтээгдэхүүн, үйлчилгээ болон процесст тухайн үйл ажиллагааг хариуцсан бизнесийн болон үйл ажиллагааны нэгжүүдтэй хамтран хийж гүйцэтгэж байна.

ХЯНАН НИЙЦҮҮЛЭЛТ, НИЙГЭМ БАЙГАЛЬ ОРЧНЫ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Тогтвортой хөгжлийн дэлхийн нийтлэг зарчим, хэм хэмжээнүүдийг анх батлуулж, нийгэм, байгаль орчны асуудлуудыг олон улсын дээд жишиг, шаардлагуудад нийцүүлэн өдөр тутмын менежмент үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ирсэн санхүүгийн салбарын тэргүүлэгч байгууллагын хувьд банк нь хүний эрх, хөдөлмөр, нийгэм, байгаль орчин, авилгалын эсрэг зэрэг олон улсын жишиг, хэм хэмжээ, ёс зүйн зарчим, Монгол Улсын хууль тогтоомжийг дээдлэн хэрэгжүүллээ.

Мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг банкны хэмжээнд сайжруулах зорилгоор харилцагчийн эрсдэлийн үнэлгээг хийж, банкны өндөр эрсдэлтэй харилцагчдын цар хүрээг тогтоож, тогтмол хяналт тавих боломжтой болов. Үүний зэрэгцээ банкны өндөр эрсдэлтэй харилцагч болон сэжигтэй гүйлгээг хянаж, цаг хугацаанд нь хяналт шалгалтын байгууллагад тайлагнаж ажиллав. Үйл ажиллагаагаа олон улсын тэргүүн туршлагад нийцүүлэх ажлын хүрээнд харилцагчаа таньж мэдэх чиглэлээр дотоод ажиллагаагаа шинэ түвшинд гаргах, тэр дундаа харилцагчтай холбогдолтой хувийн хэрэг, данс болон бусад мэдээллийг шалгах, шинэчлэх, шинээр заавар боловсруулан баримтлах зэрэг санаачлагуудыг хэрэгжүүллээ.

Ёс зүйн Кодекс ба Сонирхлын зөрчлийн бодлогын шаардлага болон ёс зүйд нийцүүлэн, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах эрмэлзэлийнхээ дагуу банкны Төлөөлөн удирдах зөвлөл болон удирдах багийн гишүүд Кодексийн биелэлтээ зүй ёсоор нотлон баталгаажуулав. Банкны Хууль бус, ёс бус үйлдлийг мэдүүлэх, шийдвэрлэх бодлого нь ёс зүйн хэм хэмжээ, шаардлагуудыг эх дэлхий, харилцагч, хувь нийлүүлэгч, ажиллагсад болон бусад сонирхогч талуудыг оролцуулан банкны үйл ажиллагааны бүх чиглэлээр төлөвшүүлэн хэрэгжүүлэх зорилготой аж.

Санхүүгийн гүйцэтгэлээс гадна банк нь нийгэм, байгаль орчны удирдлагын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлынхаа тайланг сонирхогч талууд болон олон нийтэд зориулан толилуулав. Энэ чиглэлээр банк нь нийгэм, байгаль орчны гүйцэтгэлийн удирдлагын суурь туршлагууд, мөн түүнчлэн харилцагчийг хамгаалах, ядуурлыг бууруулах асуудлын хүрээнд Smart Campaign-ы эрхэм зорилго болон жишигүүдийг хэрэгжүүллээ.

Банк нь давуу, сул талууддаа үнэлгээ хийх, боловсронгуй болгох чиглэлүүдээ тодорхойлж, улмаар нийгэм, байгаль орчны гүйцэтгэлийнхээ ил тод байдлыг дээшлүүлэх зорилгоор 2014 онд үнэлгээний байгууллага Planet Rating-ээр үнэлгээ хийлгэв. Банкны нийгэм, байгаль орчны гүйцэтгэлийн үнэлгээ өмнөх 4(-) аас 4 болж сайжирсан бөгөөд ийнхүү дэлхийн хэмжээний үнэлгээнд хамрагдсан орнуудын топ 15 компанийн нэг, Ази тивд тэргүүлэгч компаниар шалгарлаа. Монгол Улсын тогтвортой өсөлт, хөгжилд хувь нэмрээ оруулах зорилгоор банк нь Монголын Тогтвортой Санхүүжилтийн санаачлагын хүрээнд манлайлагч байгууллагын үүргээ биелүүлж, банкны үндсэн бизнесийн стратегийг нийгэм, байгаль орчинд хөрөнгө оруулалт хийх замаар хэрэгжүүлэх талаар авсан амлалтаа дахин нотоллоо.

ОЛОН УЛСЫН ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ҮНЭЛГЭЭ

Банк нь Олон Улсад тэргүүлэх үнэлгээний байгууллагууд болох Мүүдиз Хөрөнгө Оруулагчдын Үйлчилгээний байгууллага болон Фийч үнэлгээний байгууллагаар үнэлгээг хийлгэсэн анхны банк билээ. Үйл ажиллагааны ил тод байдал болон санхүүгийн хариуцлагыг эрхэмлэн өөрийн санхүүгийн болоод зээлжих чадварын үнэлгээг 2008 оноос эхлэн олон улсын үнэлгээний байгууллагуудаар жил бүр шинэчлэн тогтоолгож байна.

Moody's

	2014	2013
Хандлага	Сөрөг	Сөрөг
Урт болон богино хугацаат төгрөгөөр татан төвлөрүүлсэн хөрөнгө	B2/NP	B1/NP
Урт болон богино хугацаат гадаад валютаар татан төвлөрүүлсэн хөрөнгө	B3/NP	B2/NP
Урт болон богино хугацаат үнэт цаас гаргагчийн үнэлгээ	B3/NP	B1/NP
Зээлжих чадварын үнэлгээ	b3/(b3)	b2/(b2)
Санхүүгийн чадавхийн үнэлгээ	E+	E+

2014 онд Фийч үнэлгээний байгууллага нь банкны санхүүгийн болон зээлжих чадварыг өмнөх оны үнэлгээтэй ижил түвшинд үнэлэн баталгаажуулсан бол Мүүдиз Хөрөнгө Оруулагчдын Үйлчилгээний байгууллагаас банкны үнэлгээг өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан нэг түвшингээр бууруулсан байна. Банкны санхүүгийн болон зээлжих чадвартай холбоотой үнэлгээний мэдээллийг (<http://xacbank.mn/mn/327/about-xacbank/about-khas-bank/ratings>) энэхүү холбоосоор хандан авах боломжтой.

FitchRatings

KNOW YOUR RISK

	2014	2013
Хандлага	Сөрөг	Сөрөг
Урт хугацаат гадаад валютаар хүлээсэн үүргийг биелүүлэх зэрэглэл	B Сөрөг	B Сөрөг
Богино хугацаат гадаад валютаар хүлээсэн үүргийг биелүүлэх зэрэглэл	B	B
Урт хугацаат төгрөгөөр хүлээсэн үүргийг биелүүлэх зэрэглэл	B Сөрөг	B Сөрөг

ДОТООД АУДИТ

Дотоод аудит нь ХасБанкны үйл ажиллагааг сайжруулах, үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор хараат бус, бодитой үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж өгөх үйл ажиллагаа бөгөөд дотоод аудит нь эрсдэлийн удирдлага, хяналтын систем болон засаглалын үр өгөөжийг үнэлэх, сайжруулах талаар системтэй, зарчимч хандлагаар ХасБанкыг зорилго, зорилтоо хэрэгжүүлэн ажиллахад туслах зорилготой юм.

Дотоод аудитын газар нь 2014 онд дотоод аудитын үйл ажиллагааны дунд хугацааны стратеги төлөвлөгөөг батлан гаргасны зэрэгцээ дотоод хяналтын тогтолцоог үнэлэх аргачлалыг шинэчилж, олон улсын нэр хүнд бүхий байгууллагуудын шилдэг туршлага болсон арга аргачлалыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж эхэлсэн. Мөн мэдээллийн технологийн тогтолцооны стандартыг тогтоодог ISACA байгууллагаас гаргасан COBIT5 тогтолцоог үнэлгээний аргадаа ашиглах эхний алхмыг хийж, банкны мэдээллийн технологийн үйл ажиллагааны үнэлгээг анх удаа цогцоор нь хийлээ. Эдгээр арга аргачлалыг бүрэн хэрэгжүүлснээр ХасБанкны эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын системийг сайжруулахад тодорхой хувь нэмэр болох юм.

Дотоод аудитын газар нь энэ онд эрсдэлд суурилсан аудитын төлөвлөгөөний дагуу банкны нийт 55 процессоос 26 процессд болон 28 салбарыг аудитад хамруулаа.





ТУЛХТАЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ТҮНШЛЭЛ

Бидний одоогийн амжилт гадаад, дотоодын хамтрагч байгууллагууд болон түншүүдийн хамтын ажиллагаан дээр оршдог.

ТУЛХТАЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ТҮНШҮҮД



“Бичил Санхүүгийн Хөгжлийн Сан”, Дэлхийн Банк

Бичил санхүүгийн хөгжлийн сан (БСХС)-гаас хэрэгжүүлж буй “Тогтвортой амьжиргаа-2” төслийн хүрээнд уг санг байгуулан, Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн иргэн, жижиг бизнес эрхлэгчдэд бичил зээлийн үйлчилгээ үзүүлдэг бичил санхүүгийн байгууллагуудад бөөний зээл олгодог. ХасБанк Улаанбаатар хот, Өвөрхангай, Завхан, Өмнөговь, Хэнтий, Сэлэнгэ, Ховд, Дорноговь, Говь-Алтай аймгуудын салбаруудаар дамжуулан БСХС-ийн зээлийг олгож байна. ХасБанк уг сантай 2002 оны 11 дүгээр сараас эхлэн хамтран ажиллаж байна



“Бичил Бизнесийг Дэмжье” төсөл, АДРА Олон Улсын байгууллага

“Бичил Бизнесийг Дэмжье” төслийн зорилго нь банк санхүүгийн үйлчилгээ авах боломжоор хязгаарлагдмал, бага орлоготой эмзэг бүлгийн иргэд, нийслэлийн гэр хорооллын бичил бизнес эрхлэгчдэд зориулсан бизнес, санхүүгийн ур чадвар олгох сургалт хийх, зөвлөгөө өгснөөр бизнесээ өргөжүүлэн хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх зорилготой. 2014 онд уг төслийн хүрээнд 78 харилцагчид 416.4 сая төгрөгийн зээл олгосон.

ХасБанк уг төслийг 2007 оны 8 дугаар сараас эхлэн хамтран хэрэгжүүлж байна



Нийслэлийн Засаг Даргын Тамгын газар

Монгол Улсын Засгийн газрын “Жижиг дунд бизнесийг дэмжих Сан”-тай хамтран Нийслэлийн бичил бизнесийг дэмжих төслийн зээлийг 2014 онд амжилттай хэрэгжүүллээ. Төслийн зээлийн зорилго нь өрхийн жижиг, бичил бизнес эрхлэгчдийг Бизнес Инкубатор төвүүдэд бизнес эрхлэлтийн сургалтад хамруулах, сургалтад хамрагдсан бойжигчдод хөнгөлөлттэй нөхцөл бүхий бичил санхүүгийн үйлчилгээг хүргэх явдал юм. Уг төслийн хүрээнд 2014 онд нийт 360 бичил бизнес эрхлэгч иргэдэд 1.2 тэрбум төгрөгийн зээл олгосон. Төсөлд хамрагдсан бичил бизнес эрхлэгч иргэд 100 хувь Улаанбаатар хотын алслагдсан гэр хороололд амьдардаг иргэд, 43 гаруй хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна.

ХасБанк уг төслийг 2011 оноос эхлэн хамтран хэрэгжүүлж байна



Үнэ Цэнэт Банкны Үйлчилгээ Үзүүлэх Дэлхийн Эвсэл (GABV)

GABV нь Ази, Африк, Австрали, Латин Америк, Хойд Америк болон Европын орнуудын дэлхийн тэргүүлэгч тогтвортой банкуудыг нэгтгэсэн өөрийн Дүрэм бүхий эвсэл юм.

Эвслийн гишүүнээр шинээр үүсэж буй зах зээлүүдийн бичил санхүүгийн банк, зээлийн холбоо, орон нутгийн банк болон нийгэм, байгаль орчин, соёлын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, үйлдвэрлэлүүд элсээд байна.



“Хөдөөгийн агробизнесийг дэмжих хөтөлбөр” (RASP), Мерси Кор Монгол

Төв болон говийн бүсийн бизнес эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор банк, санхүүгийн байгууллагаас зээл авахад нь хөрөнгийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийг Өвөрхангай, Өмнөговь, Говьсүмбэр, Говь-Алтай, Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Завхан, Увс, Ховд аймгуудаар хэрэгжүүллээ.

ХасБанк уг Хөтөлбөрийг 2004 оны 3 дугаар сараас хамтран хэрэгжүүлж байна.



“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”, Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яам

ХасБанк НХХЯ-ны Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас ажилгүй иргэд, малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчид, мөн шинээр ажлын байр бий болгож ажилгүй иргэн болон ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэнийг ажлын байраар хангасан аж ахуйн нэгж байгууллагад өөрийн бүх салбаруудаар дамжуулан бага хүүтэй зээл олгож Булган, Дорноговь, Дундговь, Дархан-Уул аймаг, Улаанбаатар хотод уг төслийг хамтран хэрэгжүүлж байна. 2014 онд нийт 103 иргэнд 422.6 сая төгрөгийн зээл олгосон. Уг төсөлтэй 2002 оны 5 дугаар сараас эхлэн хамтран ажиллаж эхэлсэн.



**ХасБанкны нийгмийн хариуцлагынхаа хүрээнд хэрэгжүүлдэг
Органик Монгол хөтөлбөр**

ХасБанк нь нийгмийн хариуцлагынхаа хүрээнд МҮХАУТанхим, Петровис компанитай хамтран 2009 оноос эхлэн “Хойчдоо ногоон ирээдүйг өвлүүлээ” уриан дор ОРГАНИК Монгол хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд өрхийн ногоон аж ахуй эрхлэгч иргэд болон сүү цагаан идээний үйлдвэрлэл, эсгий эдлэл, хүлэмжийн аж ахуй эрхлэгчдэд мэргэжлийн зөвлөгөө сургалт өгч, шаардлагатай хямд өртөг бүхий санхүүжилтээр ханган ажиллаж байна. Органик Монгол хөтөлбөр нь Монгол улсын бүх орон нутагт хэрэгждэг бөгөөд нийт 1,200 гаран иргэнд 2.3 тэрбум төгрөгийн хүүгийн болон барьцаа хөрөнгийн хөнгөлөлттэй зээл олгосон.



“Хөдөөгийн ядуурлыг буулах хөтөлбөр” Монгол Улсын Засгийн газар

ХасБанк нь Монгол улсын засгийн газраас хэрэгжүүлсэн хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөрийн хүрээнд Хэнтий, Архангай, Булган, Хөвсгөл аймагт ядуурлыг бууруулах, иргэдийн өрхийн бичил бизнесийг дэмжиж зорилгоор Хөдөөгийн Ядуурлыг Бууруулах хөтөлбөрийн санхүүгийн үйлчилгээнийхэсгийг 2003 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн. Энэ хөтөлбөрийн хүрээнд дээрх 4 аймгийн давхардсан тоогоор 31,453 иргэнд 26.4 тэрбум төгрөгийн зээл олгосон.



ҮХААЯамны хүүгийн хөнгөлөлттэй төслийн зээл

ХасБанк нь 2010 оноос эхлэн ХХААХҮЯамтай хамтран хүүгийн хөнгөлөлттэй төслийн зээлийг бизнес эрхлэгч нарт олгож байна. Энэхүү төслийн зээл нь бизнес эрхлэгч банкнаас авсан зээлийн нийт хүүгийн төлбөрийн 50 хувийг ХХААХҮЯамнаас хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд төлүүлэх боломжтой юм. Төслийн хүрээнд нийт 12 харилцагч 1.5 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн төлбөрийн 50 хувьд хөнгөлөлт эдэлсэн байна.



Зээлийн батлан даалтын сан

ХасБанк нь 2013 оноос эхлэн Монгол улсын Засгийн газраас үүсгэн байгуулсан “Зээлийн батлан даалтын сан”-тай хамтран ажиллаж байна. Зээлийн батлан даалтын сангийн зорилго нь жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжиж зээлийн үнийн дүнгийн 60 хүртэл хувьд батлан даалт гаргах, улмаар жижиг дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдийг дэмжих, ажлын байр бий болгох юм. Банк нь зээлийн батлан даалтын сантай хамтран ажиллаж нийт 70 харилцагчийн 7.3 тэрбум төгрөгийн зээлд 4.5 тэрбум төгрөгийн батлан даалт гаргуулсан байна.



Хөдөлмөрийн яамны ЖДҮХСангийн ЖДҮ-ийг хөгжүүлэх төслүүд

Монгол Улсын Засгийн Газраас жижиг дунд бизнес эрхлэгчдэд жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлээр дунд хугацааны хөрөнгө оруулалтын эх үүсвэр олгох зорилгоор хөнгөлөлттэй зээлийг олгоход ХасБанк хамтран ажиллаж байна. ХасБанк нь нийт 57.1 тэрбум төгрөгийн төслийн зээлд 1,762 харилцагчийг хамруулаад байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД



84.8 тэрбум төгрөг 8 жил www.ifc.org

Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК) нь хөгжиж буй улс орнуудын хувийн сектор руу чиглэн ажилладаг дэлхийн хамгийн том байгууллага юм. ОУСК нийт 22 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтыг дэлхийн 100 гаруй улсад хийсэн байна. 2009 онд байгуулагдсан Хөрөнгийн Удирдлагын Компани (ХҮК) нь ОУСК-ийн эх үүсвэрийн удирдлагын үйл ажиллагааг хариуцдаг ба өөрийн 6 сангаар дамжуулан гурвадуга эгтээдийн капиталыг удирддаг байна.



47.1 тэрбум төгрөг 3 жил www.cyrano-management.com

Cyranо Management нь хөгжиж буй улс орнуудын бичил санхүүгийн салбар руу чиглэсэн хөрөнгө оруулалтын удирдлагын үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм. Cyranо-ийн эзэлхүүн шинжилгээний аргачлал болон эрдсийг хянах үйл ажиллагаа нь тус байгууллагын гол давуу тал болдог. Одоогийн байдлаар Cyranо MEF-ийн нийт багцын 37 хувийг удирдан ажиллаж байгаа бөгөөд энэ нь 17 улсын 29 компанид хийгдсэн хөрөнгө оруулалт байна.

responsAbility

68.8 тэрбум төгрөг 2-3 жил www.responsability.com

*responsAbility Investments AG нь хөгжиж буй улс орнуудад хөрөнгө оруулалт хийх чиглэлээр мэргэшсэн дэлхийн томоохон байгууллагуудын нэг юм. responsAbility эдийн засгийн өсөлтийг бий болгож, нийгмийн байдлыг сайжруулах зорилгоор бага орлоготой хүн амд үйлчилгээ үзүүлдэг компаниудад зээл болон өөрийн хөрөнгийн санхүүжилт олгодог. Тус байгууллага хөрөнгө оруулалтын мэргэжлийн үйлчилгээг байгууллага болон хувь хүмүүст үзүүлж байна.



28.3 тэрбум төгрөг 5 жил www.proparco.fr

PROPARCO нь эдийн засгийн хамтын ажиллагааг дэмжих зорилготой хөрөнгө оруулалт, тусламжийн байгууллага юм. 1977 онд байгуулагдсан PROPARCO Францын Хөгжлийн Агентлаг болон Өмнөд, Хойд эсгийг бусад хувь нийлүүлэгчдийн эзэмшилд байдаг. Тус байгууллага ядуу буурай улсууд болон хөгжиж буй улс орнуудад хөрөнгө оруулалт хийдэг. PROPARCO нийт 155 ажилтантай ба бүсийн 13 оффис, Францын Хөгжлийн Агентлагийн 50 төлөөлөгчийн газраар дамжуулан үйл ажиллагаагаа явуулж байна.



7.8 тэрбум төгрөг 10 жил www.kfw-entwicklungsbank.de

KfW нь Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ)-ын Засгийн Газрын эзэмшилд байдаг хөгжлийн банк юм. Тус банк 50 гаруй жилийн турш ХБНГУ-ын Засгийн газарт хөгжлийн бодлого болон олон улсын хамтын ажиллагааны зорилтуудад хүрэхэд нь тусламж, дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. ХБНГУ-ын Засгийн газар, Эдийн Засгийн Санхүүжилт Ажиллагаа, Хөгжлийн Яамны нэрийн өмнөөс KfW хөгжиж буй улс орнууд болон шинээр үүсч буй зах зээлд хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдэд санхүүжилт олгодог.



13.8 тэрбум төгрөг 3 жил www.oikocredit.coop

Oikocredit нь бичил санхүүгийн сектор хөрөнгө оруулалт хийдэг дэлхийн томоохон байгууллагуудын нэг юм. Oikocredit хөгжиж буй улс орнуудын бичил санхүүгийн байгууллагуудаар дамжуулан хөгжиж бизнес эрхлэгчдэд зээл, өөрийн хөрөнгийн санхүүжилт олгохоос гадна шууд бизнес эрхлэгчид, худалдааны нийгэмлэгүүдэд санхүүжилт хийдэг. Oikocredit олон жилийн байдлаар 63 улсын 811 компанид зээл, нүүжилт олгосон байгаа бөгөөд 15 улсын 52,000 ай хамтран ажиллаж байна.



3-7 жил www.oikocredit.coop

Incofin Хөрөнгө Оруулалтын Удирдлагын Компани (Incofin IM) нь хөрөнгө оруулалтын сангуудад зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлдэг. Орон нутгийн бичил санхүүжилтын үйл ажиллагааны чиглэлээр мэргэшсэн Incofin IM-ийн гол зорилго нь орон нутгийн хэт тусгаарлагдсан бүст амьдардаг, хөдөө аж ахуйн бизнес эрхлэгчдэд иргэдэд хүрч ажилладаг оршино. Incofin IM одоогийн байдлаар 40 гаруй улсын бичил санхүүгийн байгууллагуудад санхүүжилт, дэмжин ажиллаж байна.



61.9 тэрбум төгрөг 2-4 жил www.ebrd.com

"Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк нь Төв болон Зүүн Европод дайны дараах шинэ эхлэлийг бий болгох зорилгоор байгуулагдаж байсан. Үүнээс хойш тус банк өөрийн бүс нутаг болон бусад улс орнуудад өөрчлөлт шинэчлэлийг дэмжин ажиллаж онцгой туршлага хуримтлуулсан байна. Тус банк санхүүгийн хөрөнгө оруулалт хийх, бизнесийн зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлдэг ба синдикат зээл, худалдааны санхүүжилтыг дэмжин ажилладаг.



37.7 тэрбум төгрөг 2 жил www.ofid.org

Хөгжиж буй улс орнуудад дэмжлэг үзүүлэх зорилгоор OPEC-ийн гишүүн улсууд хамтран OFID-ийг 1976 онд байгуулсан. OFID-ийн үйл ажиллагаа нь дэлхийн буурай улс орнуудын ядуурлыг бууруулж эдийн засгийн өсөлтийг сайжруулахад чиглэсэн бөгөөд энэхүү зорилгынхоо хүрээнд хөгжиж буй улс орнууд болон олон улсын хандивын нийгэмлэгүүдтэй хамтран ажилладаг. OFID-ийг байгуулагдсанаас хойш дэлхийн 134 улс түүний тусламж, дэмжлэгийг хүртсэн байна.



37.4 тэрбум төгрөг 2-3 жил www.symbioticsgroup.com

Symbiotics нь зах зээлийн судалгаа, хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөх үйлчилгээ, хөрөнгийн удирдлагын үйлчилгээ үзүүлдэг байгууллага юм. Тус байгууллагын төв нь Женевт байрладаг ба Лондон, Мексик, Сингапур, Кейп Таунд оффистой. 2004 оноос хойш Symbiotics 28 хөрөнгө оруулалтын сан, бусад хөрөнгө оруулагчидтай хамтран 50 гаруй хөгжиж буй улсын 200 бичил санхүүжилтын байгууллагад 2 тэрбум орчим ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн байна.



28.3 тэрбум төгрөг 5 жил www.oe-eb.at

OeEB 2008 оны 3 дугаар сард Бүгд Найрамдах Австри улсын албан ёсны Хөгжлийн Банк болон байгуулагдсан. OeEB нь Österreichische Kontrollbank (OeKB) буюу Австрийн Экспортын Зээлийн Агентлагийн салбар байгууллага юм. OeEB хөгжиж буй улс орнууд болон шинээр бий болж буй зах зээлд үйл ажиллагаагаа явуулж буй компаниудын санхүүгийн хэрэгцээг тодорхойлж тэдэнд хөрөнгө оруулалт хийдэг. Тус банк барьдаг хөрөнгийн үнэлгээ, зөвлөгөө өгөх хөтөлбөрөөрөө дамжуулан хөгжлийн үр ашгийг нэмэгдүүлж байна.



28.3 тэрбум төгрөг 4 жил www.deginvest.de

DEG нь KfW группын эзэмшилд байдаг, түүний салбар байгууллага юм. 1962 онд байгуулагдсанаасаа хойш DEG хөгжиж буй улс орнуудын хувийн секторыг дэмжин ажиллаж байна. DEG өнгөрсөн хугацаанд 1,700 гаруй байгууллагатай хамтран ажилласан байна. Тус байгууллагын санхүүжилт нь урт хугацаатай, эрсдэл багатай буюу найдвартай, 50 гаруй жилийн туршлага дээр суурилсан байдаг. DEG-ийн хөрөнгө оруулалтын багц 6.8 тэрбум евро бөгөөд үүний 40%-ийг эрсдэлтэй капиталд оруулсан санхүүжилт бүрдүүлж байна.



9.4 тэрбум төгрөг 3 жил www.calvertfoundation.org

Calvert нь нийгмийн дундажаас доогуурх бүлэгт санхүүжилт олгож, үйлчилгээ үзүүлдэг нийгмийн хөгжлийг дэмжих зорилготой санхүүгийн байгууллага юм. Өнгөрсөн 18 жилийн хугацаанд Calvert нийгмийн хөгжлийг дэмжиж, ашгийн төлөө бус дэлхийн 380 гаруй байгууллагад 567 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн байна. 2014 онд тус байгууллага MicroVest Capital-тай хамтын ажиллагаагаа эхлүүлж, бичил санхүүжилтын салбарт олгосон 50 сая ам.долларын багцаа MicroVest Capital-ийн удирдлагад шилжүүлсэн байна.



5.6 тэрбум төгрөг 5 жил www.bibessen.de

Bank Im Bistum (BIB) нь сүм, нийгэмлэг, халамжийн байгууллага болон эрх тэгш, энх тайван дэлхийг бий болгох BIB-ийн зорилгод нийцсэн үйл ажиллагаа явуулж буй хүн бүрт санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг. Өнгөрсөн жилүүдэд хөгжиж буй 60 гаруй улсын олон тооны сүм болон бичил санхүүгийн байгууллагууд BIB-ийн нэр хүндтэй харилцаж болсон байна. BIB бичил санхүүгийн хөрөнгө оруулалтын сан болох KCB Mikrofinanzfonds-ийг дэмжин ажилладаг.



56.6 тэрбум төгрөг 5 жил www.adb.org

Азийн Хөгжлийн Банк 1966 онд байгуулагдсан бөгөөд бүсийн 48 гишүүн, бүсийн бус 19 гишүүнтэй. Тус байгууллага ядуурлыг бууруулж, хүн бүрт хөгжил дэвшлийн үр ашгийг хүргэхийн тулд хөгжиж буй гишүүн улс орнуудад зээл, мөнгөн тусламж, тусгай мэргэшлийн үйлчилгээг үзүүлдэг. 2013 оны эцэст Азийн Хөгжлийн Банкны хөрөнгө оруулалтын хэмжээ хамтын санхүүжилтын 6.7 тэрбум ам.долларыг хамруулаад нийтдээ 21.0 тэрбум ам.долларт хүрчээ.



35.7 тэрбум төгрөг 5-10 жил www.fmo.nl

Нидерландын Хөгжлийн банк болох FMO нь хувиараа бизнес эрхлэгчдийг эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгож иргэдийн амьдралын түвшинг сайжруулахад нөлөөлөх гол хүчин зүйл гэж үздэг. Иймээс FMO хувийн секторын тогтвортой хөгжлийг дэмжих зорилгоор хөгжиж буй улс орнуудын санхүүгийн байгууллагууд, бизнес, тэдгээр улсад хэрэгжиж буй төсөлд санхүүжилт олгодог. FMO тухайн улсад урт хугацааны зэрэг нөлөөллийг үзүүлж чаддаггүй секторууд руу чиглэдэг.



23.8 тэрбум төгрөг 4 жил www.tridos.com

Triodos Хөрөнгийн Удирдлагын компани нь Triodos Банкны эзэмшилд байдаг бөгөөд 2.5 тэрбум еврогоор үнэлэгдэх хөрөнгө оруулалтын 18 саяг удирдан ажиллаж байна. Triodos эдгээр сангуудаараа дамжуулан эрчим хүч, цаг уур, шинээр үүсч буй зах зээл, урлаг, соёл, улс хөдлөх хөрөнгө гэх мэт олон төрлийн секторуудыг дэмжин ажилладаг. Triodos-ийн зарим сангууд хувиараа хөрөнгө оруулалт хийж буй иргэд, буяны байгууллага, гэр бүлийн бизнес эрхлэгчдэд нээлттэй байдаг.



10.1 тэрбум төгрөг 2 жил www.iibbank.com

Олон Улсын Хөрөнгө Оруулалтын Банк нь гишүүн улсуудынхаа эдийн засгийн хамтын ажиллагаа, хүн амын хөгжил, нийгэм болон эдийн засгийн хөгжлийг дэмжин ажилладаг олон талын оролцотой байгууллага юм. Энэхүү байгууллагын үйл ажиллагаа нь жижиг, дунд бизнесийг дэмжих, нийгэмд анх холбогдолтой дэд бүтцийн төслүүдийг санхүүжүүлэхэд чиглэдэг. 2014 оны 11 дүгээр сард тус банкны өөрийн хөрөнгийн хэмжээ 374 сая евро, нэмж төлөгдсөн капиталын хэмжээ 272.6 сая еврод хүрсэн байна.



16.0 тэрбум төгрөг 3 жил www.frankfurt-school.de

FS Financial Services-ийн Хөрөнгө Оруулалтын Удирдлагын Газар нь олон улсын хөрөнгө оруулагчдыг хөгжиж буй улс орнуудын санхүүгийн зах зээлтэй холбож өгдөг. Үүний үр дүнд, хөгжиж буй улс орнууд тогтвортой өсөлтийг бий болгоход шаарддаг санхүүгийн тусламж, дэмжлэгийг хүртэх боломжтой болж байна. Тус байгууллагын Корпорацийн Санхүүжилтын Газар нь жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зөвлөгөө өгөх, санхүүжилт олгох, бизнес эхлүүлэхэд шаарддаг дэмжлэгийг олгох үйлчилгээг үзүүлж байна.



7.1 тэрбум төгрөг 2 жил www.blueorchard.com

BlueOrchard Finance нь бичил санхүүгийн байгууллагуудад өрийн санхүүжилт олгож чиглэлээр туршлагасан дэлхийд тэргүүлэгч хөрөнгийн удирдлагын компаниудын нэг юм. Швейцарын Женевт төвтэй BlueOrchard нь Камбож, Жиоржиа, Перу, Кенд оффистой бөгөөд Люксембург болон Цюрихд төлөөлөгчийн газартай. 2001 онд байгуулагдсанаасаа хойш BlueOrchard бичил санхүүгийн салбарт 2 тэрбум гаруй ам.долларын зээл олгож, хөрөнгө оруулагчдад ашигтай бүтээгдэхүүнийг гянал болгон ажиллаж байна.



17.0 тэрбум төгрөг 3 жил www.limadvisors.com

LIM Advisors нь хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлдэг Азийн групп юм. LIM Advisors 1995 онд Хонг Конгд байгуулагдсан. Тус компани хөрөнгө оруулагч байгууллага болон их хэмжээний хөрөнгөтэй хувь хүмүүст үйлчилгээ үзүүлдэг. LIM Advisors Азийн хөрөнгийн зах зээлд санхүүжилт олгохоос гадна аргитрийн үйл ажиллагаа, өөрийн хөрөнгө болон зээлтэй холбоотой стратегийг, улс хөдлөх хөрөнгө, таварын зах зээлд хөрөнгө оруулалт хийдэг.

КОРРЕСПОНДЕНТ ХАРИЛЦААТАЙ БАНКУУД

	Bank	SWIFT code	Currency	Account number
	中国农业银行 AGRICULTURAL BANK OF CHINA	ABOCCNBJ050	CNY USD	05999901040000095 05999914040000080
	中国工商银行 INDUSTRIAL AND COMMERCIAL BANK OF CHINA	ICBKCNBJNMA	CNY USD	0610040629200108396 0610040629200108795
	Deutsche Bank Trust Co. Americas, NewYork, USA	BKTRUS33	USD	04-434-754
	HypoVereinsbank, Munich, Germany	HYVEDEMM	EUR	69 109 012
	ING Belgium NV/SA, Brussels, Belgium	BBRUBEBB010	EUR	301-0104743-64-EUR
	Kookmin Bank, Seoul, Korea	CZNBKRSE	USD	772-8-USD-01-3
	Sberbank (Savings Bank of the Russian Federation), Moscow, Russia	SABRRUMM	EUR GBP RUB USD	30111978700000000536 30111826700000000536 30111810800000000536 30111840100000000536
	Sumitomo Mitsui Banking Corporation, Tokyo, Japan	SMBCJPJT	JPY USD	4347 3625
	The Bank of Tokyo Mitsubishi UFJ, Ltd., Tokyo, Japan	BOTKJPJT	JPY	653-0468959
	Australian and New Zealand Banking Group Limited, Melbourne Australia	ANZBAU3M	AUD	920983AUD00001
	Korea Exchange Bank, Seoul, Korea	KOEXKRSE	USD KRW	0963-THR-050920016 0963-FRW-001000085
	Bank of China, Erlan Branch, China	BKCHCNBJ89N	CNY	155628273504
	Commerzbank AG, Frankfurt am Main, Germany	COBADEFF	EUR USD CAD	400878578400EUR 400878578400USD 400878578400CAD

2014 оны 10 сар



КОМПАНИЙН
ЗАСАГЛАЛЫН
ТАЙЛАН

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ТАЙЛАН

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ХҮРЭЭ

Үр дүнтэй компанийн засаглал нь ХасБанкны хувьд биднийг тодорхойлох чухал үзүүлэлт байсаар ирсэн. 2014 онд компанийн сайн засаглалын соёлыг хэрэгжүүлж, цаашид хөгжүүлэх асуудал бидний анхаарлын төвд хэвээр байлаа. Банкны компанийн засаглалын жишиг нь засаглалын зарчим болон Дэлхий нийтийн тэргүүн туршлага дээр тулгуурласан байдаг. Системийн банкны хувьд ХасБанк нь банкны салбарын зохицуулагч Монголбанк (Төв Банк)-аас гаргадаг засаглалыг зохицуулах журамд мөн захирагддаг. Тус банкны дотоод үйл ажиллагааг удирдах гол баримт бичиг нь ТэнГэр Санхүүгийн Нэгдэлийн Хувьцаа эзэмшигчидтэй хийсэн гэрээ, ХасБанкны дүрэм ба ТУЗ-ийн гишүүдийн дотоод дүрэм журам болно. ТэнГэр Санхүүгийн нэгдэл нь түүний охин компаниудад хэрэгжих Компанийн засаглалын журам, Ёс зүйн хэм хэмжээ ба сонирхолын зөрчлийн журам, Холбоотой талын үйл ажиллагааны журам, шинэчлэн найруулсан ТУЗ-ийн дотоод дүрэм журмууд, ТУЗ-ийн гишүүдийг сонгох, томилох журам гээд хэд хэдэн гол бодлогын баримт бичиг болон дүрэм, журмуудыг баталсан. Эдгээр дүрэм журмууд нь жижиг болон гадаадын хувьцаа эзэмшигчид бүхий бүх хувьцаа эзэмшигчдэд ижил тэгш хандах, бүх шатандаа тайлагнах зарчим, нээлттэй, ил тод байдал, оролцогч талуудын өмнө хүлээсэн үүрэг хариуцлага зэрэг асуудлыг зохицуулсан компанийн засаглалын хүрээг бүрдүүлж байна.

Ирээдүйд хөрөнгийн биржэд хувьцаа гаргах шаардлага болон хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдын өсөн нэмэгдэж буй хүлээлтийг хангах зорилгоор банк нь цаашид өөрийн компанийн засаглалын жишгийг Олон Улсын тэргүүн туршлагатай нийцүүлж, шинэчлэн сайжруулах ажлыг үргэлжлүүлэн хийх болно.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ

Банкны хамгийн дээд удирдах байгууллага бол хувьцаа эзэмшигчдийн хурал болно. Банкны дотоод үйл ажиллагааны баримт бичигт заасны дагуу Банкны холдинг компани буюу цорын ганц хувьцаа эзэмшигч болох ТэнГэр Санхүүгийн нэгдлийн хувьцаа эзэмшигчид нь Банкны хувьцаа эзэмшигчдийг төлөөлөх юм.

Хувьцаа эзэмшигчдийн сонгосон Төлөөлөн Удирдах зөвлөл (ТУЗ) нь хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр тусгайлан шийдэгдэхээр хүлээгдэж буй асуудлаас бусад асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлуудын хоорондох хугацаанд шийдэх Банкны шийдвэр гаргагч байгууллага болно. ТУЗ нь стратегийн зорилт, бодлогыг томъёолох, тэдгээр зорилтод хүрэхэд шаардлагатай санхүүгийн болон хүний нөөцийн асуудлыг шийдэх замаар Банкинд стратегийн удирдамж болон манлайллаар хангаж ажилладаг. ТУЗ нь Банкны үйл ажиллагааг хууль тогтоомж, удирдан зохицуулах дотоод баримт бичиг, батлагдсан төсөв төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаад, мөн эрхэм зорилгын гурван суурь ухагдахуун болон бүх оролцогч талуудын сонирхолд нийцтэй байгаад хяналт тавьж ажилладаг. ТУЗ эрсдэлийг үнэлж удирдах боломжийг хангасан үр дүнтэй, зохист хяналтын хүрээгээр хангаж ажилладаг.

ТУЗ нь өөрийн чиг үүргийг биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх байнгын хороодыг байгуулж, тодорхой үүрэг хариуцлага, шийдвэрийг тус хороодод даалгаж ажиллаж байна. Түүнчлэн тодорхой, яаралтай асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор ТУЗ нь түр хороодыг ажиллуулдаг.

Банкны өдөр тутмын үйл ажиллагааг ТУЗ-өөс томилогдсон Гүйцэтгэх захирал удирдах бөгөөд тэрээр банкныг төлөөлөх ба ажлын гүйцэтгэлийг хувьцаа эзэмшигчдэд болон ТУЗ-д тогтмол тайлагнана. Банк нь компанийн засаглалын бүтцийн нэг хэсэг болох Ерөнхий аудитор болон Компанийн нарийн бичгийн дарга гэсэн хоёр албан тушаалыг бий болгосон.

Ерөнхий аудитор нь банкны дотоод хяналт, аудитыг хариуцаж ТУЗ-ийн Аудитын хороонд ажлаа тайлагнаж ажилладаг.

Олон улсын засаглалын жишигт нийцүүлэх үүднээс Компанийн нарийн бичгийн дарга нь Компанийн засаглалын захирлын албыг хаших бөгөөд тэрээр банкны засаглалтай холбоотой бүхий л асуудлыг төлөөлөх ба компанийн засаглалын бодлого, тэргүүн туршлагын хэрэгжилтийг хангаж ажиллана.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

2014 оны 4 дүгээр сарын 3-нд Хувьцаа эзэмшигчдийн ерөнхий хурал (ХЭЕХ) болсон. Энэхүү хурлаар 2013 оны үйл ажиллагааны болон санхүүгийн үр дүн, мөн аудитлагдсан санхүүгийн тайланг батлах, ТУЗ-ийг гишүүдийг сонгох, ТУЗ-ийн төсөв батлах зэрэг гол гол асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Мөн ХЭЕХ нь банкны ирээдүйн өсөлтийг санхүүжүүлэх зорилгоор 2013 онд ногдол ашиг хуваарилахгүй байх, бусад зохицуулалтын зөвлөмжийг дагах шийдвэр гаргасан. Банк нь Сайн засаглалын хэрэгжилтийн нэг хэсэг болох жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах нь чухал болохыг хүлээн зөвшөөрч, хэдийгээр банкны удирдан зохицуулах баримт бичигт заагаагүй ч жижиг хувьцаа эзэмшигчдээс ТУЗ-д гишүүнээр сонгогдохыг дэмжин, 2014 онд жижиг хувьцаа эзэмшигчдээс гүйцэтгэх бус захирлыг сонгосон.

Компанийн чухал шийдвэрийн талаар Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, түүнчлэн тэдний эрхийн хэрэгжилтийг хангах, хувьцаа эзэмшигчдийн зүгээс үр дүнтэй түргэн шийдвэр гаргуулах зэргээр хувьцаа эзэмшигчдийн байнгын оролцоог бүтэн жилийн турш хангаж ирсэн.

Банкны дунд ба урт хугацааны хэтийн зорилт, стратеги болон богино хугацааны зорилгыг хэлэлцэх зорилгоор хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлага хоорондын уулзалтыг 2014 оны 6 дугаар сарын 19-нд зохион байгууллаа. Түүнчлэн, 2014 онд хувьцаа эзэмшигчдийн тусгай хурлыг онлайн хэлбэрээр хэрэгжүүлж Банкны дүрэмд тодорхой өөрчлөлтүүдийг баталсан болно.

ТУЗ (ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ)

ТУЗ-ийн бүрэлдэхүүн

2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ТУЗ нь нэг гүйцэтгэх захирал, холдинг компанийн хувьцаа эзэмшигчдийн томилсон 6 гүйцэтгэх бус захирал мөн хоёр хараат бус гүйцэтгэх бус захиралтай буюу нийт 9 гишүүнтэй. Үүнд:

Гүйцэтгэх захирал нь ТэнГэр санхүүгийн нэгдэл болон ХасБанкны Гүйцэтгэх захирал Магваны Болд юм.

Хувьцаа эзэмшигчдээс томилогдсон гүйцэтгэх бус захирлууд:

1. Нямтайширийн Цэлмүүн, МАК-аас;
2. Ричард Ранкен, ОУСК-аас;
3. Шүжи Ирие, ОРИКС-ээс;
4. Сабина Дзиурман, Европын Сэргээн босголтын банкнаас;
5. Майкл Мадден, Ронок Партнерс-аас;
6. Баатарын Батсайхан, Монголия Оппортунитиз Фондаас томилогдсон, жижиг хувьцаа эзэмшигч.

ТУЗ-ийн дарга Чулууны Ганболд болон Жэймс Стент нар хараат бус гүйцэтгэх бус захирлууд болно.

ТУЗ-ийн гишүүд өөр хоорондоо холбоогүй болно.

2014 онд жижиг хувьцаа эзэмшигч болох Нээлтэй Нийгэм форумаас томилогдсон гүйцэтгэх бус захирал Пэрэнлэйн Эрдэнэжаргал, хараат бус гүйцэтгэх бус захирал Биндэръяагийн Саран нарын хугацаа дууссаны улмаас тус тус ажлаа хүлээлгэн өгөв.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ТАЙЛАНТУЗ-ийн Дарга ба Гүйцэтгэх захирал

ТУЗ-ийн Дарга болон банкны Гүйцэтгэх захирлын үүргийг өөр өөр хүн гүйцэтгэх ба үүнийг банкны дүрэмд тодорхой заадаг.

ТУЗ-ийн дарга нь гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавих, ТУЗ-ийн хурлыг удирдах, хурлын хөтөлбөрийг боловсруулах, гишүүн тус бүрээс ирэх асуудал мөн гишүүдийн хувь нэмрийг зохистой түвшинд хэлэлцэхийг дэмжин ТУЗ-ийн үйл ажиллагааг үр дүнтэй байлгахыг хариуцдаг.

Гүйцэтгэх захирал нь өөрт даалгасан ТУЗ-өөр батлагдсан стратеги, зорилго, бодлогын хэрэгжилтэнд анхаарч ажиллахаас гадна банкны өдөр тутмын удирдлага, үйл ажиллагааг хариуцаж ажилладаг. Гүйцэтгэх захирал нь стратегийн болон бизнесийн төлөвлөгөө, бүтэц зохион байгуулалт, хяналтын систем, дотоод дүрэм журмыг боловсруулах ажлыг мөн давхар хариуцан ажилладаг.

Сонгууль ба захирлуудыг дахин сонгох

ТУЗ-ийн гишүүдийг ХЭЕХ-аар 2 жилийн хугацаатайгаар дахин сонгогдох боломжоор хангаж сонгодог ба хугацаа дуусах үед, гишүүн ажлаа өгөх, эсвэл дахин сонгогддог. ТУЗ-д сул чөлөөтэй орон тоо гарсан тохиолдолд дараагийн гишүүнийг ТУЗ нь сонгууль болон хувьцаа эзэмшигчдийн ерөнхий хурлаар батлагдах хүртэл түр томилно.

ТУЗ-ийн гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, сонгох, дахин сонгох, чөлөөлөх журам нь Банкны дүрэмд болон ТУЗ-ийн гишүүдийг нэр дэвшүүлэх журамд тусгагдсан байдаг. ТУЗ-ийн Компанийн засаглал, томилгоо, шагнал урамшууллын хороо (КЗТШУ хороо) нь ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг хянах, гишүүдийг нэр дэвшүүлэх, томилоход зориулсан холбогдох журам боловсруулах, гишүүдийн залгамж байдлыг хангах төлөвлөлтийн хянах, ур чадвар, мэдлэг мэргэжил, туршлага зэргийг үнэлэх үнэлгээг хариуцна.

Гүйцэтгэх бус гишүүн Нямтайширийн Цэлмүүн нь 2013 оны 4 дүгээр сарын 25-нд Хувьцаа эзэмшигчдийн ерөнхий хурлаар 2 жилийн хугацаатайгаар сонгогдсон. Тус хурлаар Гүйцэтгэх захирал Магваны Болд, Гүйцэтгэх бус захирал Майкл Мадден нар нь дахин сонгогдсон. Дүрэмд зааснаар эдгээр гишүүд нь дахин сонгуульд оролцох боломжтой ба КЗТШУ хороо нь эдгээр гишүүдийг 2015 оны ХЭЕХ-аар дахин сонгох саналыг гаргалаа.

2014 оны 4 дүгээр сарын 3-нд болсон ХЭЕХ-аар Гүйцэтгэх бус захирал Чулууны Ганболд, Ричард Ранкен нар дахин сонгогдсон бол Гүйцэтгэх бус захирал Баатарын Батсайхан, хараат бус гүйцэтгэх бус захирал Жэймс Стент нар энэхүү хурлаар 2 жилийн хугацаатайгаар сонгогдсон.

Гүйцэтгэх бус захирал Шужи Ирие ба Сабина Дзиурман нар 2013 оны 12 дугаар сарын 10-нд болсон ХЭЕХ-аар 2 жилийн хугацаатайгаар мөн дахин сонгогдсон юм.

Сургалт ба хөгжил

Банкны сайн засаглалын жишгийн хүрээнд Монгол Улсын Аж ахуйн нэгжийн тухай хуулийн 75.8-р зүйлд заасантай нийцүүлж ТУЗ-ийн бүх гишүүдийг компанийн засаглалын сургалтанд хамруулж гэрчилгээ олголоо. 2014 онд шинээр сонгогдсон ТУЗ-ийн гишүүддээ компанийн засаглалын онлайн сургалтыг Монголын Компанийн засаглалын хөгжлийн төв (МЗХТ) болон ОУСК нартай хамтран зохион байгуулсан.

ТУЗ-ийн хурал

ТУЗ-ийн хурал нь 2014 оны 12 дугаар сарын 10-ны ээлжит хурлаар өөрчлөлт оруулж баталсан ТУЗ-ийн дүрэм, дотоод дүрэм журмын үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулдаг. ТУЗ-ийн үйл ажиллагааны гол хэлбэр нь ТУЗ-ийн хурал ба хурлын шийдвэрээ тушаал хэлбэрээр гаргах.

2014 онд ТУЗ-ийн дөрвөн ээлжит, хоёр ээлжит бус хурал зохион байгуулагдсан ба ТУЗ-ийн хурал дараах өдрүүдэд боллоо:

- 2014 оны 4 дүгээр сарын 2;
- 2014 оны 4 дүгээр сарын 3 (ээлжит бус);
- 2014 оны 6 дугаар сарын 18;
- 2014 оны 7 дугаар сарын 10 (ээлжит бус);
- 2014 оны 9 дүгээр сарын 17;
- 2014 оны 12 дугаар сарын 10.

ТУЗ-ийн дийлэнх ээлжит хурлууд Улаанбаатар хотод болсон ба 2014 оны 7 дугаар сарын ээлжит бус хурал ХонгКонгд зохион байгуулагдсан.

ТУЗ нь банкны урт хугацааны стратеги төлөвлөгөөг хэлэлцэхэд жилд хамгийн багадаа нэг өдөр зориулдаг бөгөөд тайлант онд хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлагын хооронд банкны дунд ба урт хугацааны хэтийн зорилт, стратеги болон богино хугацааны зорилго, зорилтуудыг хэлэлцэх уулзалтыг 2014 оны 6 дугаар сарын 19-нд зохион байгуулав.

2014 онд ТУЗ-ийн хурлын ирц нэг удаагийн хуралд нэг гишүүн урьдчилан мэдэгдэж ирээгүйг үл тооцвол 100 хувьтай байлаа.

2014 онд ТУЗ нь 31 тушаал шийдвэр гаргасан ба үүнээс 5 тушаал, шийдвэрийг ТУЗ-ийн хурлыг хуралдуулалгүйгээр онлайн санал хураалтаар гаргасан болно.

Банкны гүйцэтгэх дээд удирдлагын багийн гишүүд шаардлагатай тохиолдолд ТУЗ-ын бүх ээлжит хурал, ТУЗ-ийн хороодын болон бусад хуралд оролцож банкны бизнес хөгжлийн болон санхүү бүртгэл, хууль зохицуулалтын биелэлт, компанийн засаглал, бусад банкны асуудлуудаар шаардлагатай мэдээлэл зөвлөгөөгөөр хангав.

Энэ мэтчилэн албан хурлаас гадна ТУЗ-ийн гишүүд банкны гүйцэтгэх дээд удирдлагын багийн гишүүдтэй тогтмол албан бус харилцаатай байдаг бөгөөд энэ нь удирдлагын баг болон ТУЗ-ийн хооронд нээлттэй хэлэлцүүлэг, мэдлэг туршлага солилцох үйл ажиллагааг дэмждэг.

ТУЗ-ЫН ХОРООД

ХасБанк нь ТУЗ-өөс даалгасан тодорхой үүрэг хариуцлага бүхий 3 байнгын хороотой ба эдгээр хороод нь ТУЗ-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд туслах зориулалттай. Үйл ажиллагаагаа явуулах нийтлэг үндэслэл нь 2014 оны 12 дугаар сарын 10-ны ээлжит хурлаар өөрчлөн баталсан ТУЗ-ийн дотоод дүрэм, журмаар зохицуулагдах ба хороодтой холбоотой асуудал нь холбогдох хороодын дүрмээр зохицуулагдана. ТУЗ-ийн байнгын хороод нь:

- Компанийн засаглал, томилгоо, шагнал урамшуулалын хороо;
- Эрсдэлийн удирдлагын хороо;
- Аудитын хороо.

ТУЗ-ийн хороод нь тав буюу түүнээс дээш гишүүнтэй байх бөгөөд тэдгээр нь мөн ТУЗ-ийн гишүүн байх юм. ТУЗ-ийн гишүүн нь нэгээс дээш хороонд ажиллаж болох бөгөөд Монгол Улсын Банкны тухай хуульд заасны дагуу ТУЗ-ийн хараат бус нэг гишүүн нь Эрсдэлийн удирдлагын болон аудитын хороодод давхар ажиллах үүрэгтэй.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ТАЙЛАН

Хороодын үйл ажиллагаагаа явуулах гол хэлбэр нь хороодын хурал бөгөөд хурлын шийдвэр нь ТУЗ-д зөвлөмж хэлбэрээр гардаг. Хороодын ээлжит хурлууд нь ТУЗ-ийн хурлын өмнөх өдөр товлөгддог ба 2014 онд байнгын хороод нь дараахь өдрүүдэд 4 ээлжит хурлаа хийсэн:

- 2014 оны 4 дүгээр сарын 1;
- 2014 оны 6 дугаар сарын 17;
- 2014 оны 9 дүгээр сарын 16;
- 2014 оны 12 дугаар сарын 9.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, ТОМИЛГОО, ШАГНАЛ УРАМШУУЛЛЫН ХОРОО

Компанийн засаглал, томилгоо, шагнал урамшууллын хороо нь засаглалын зарчим, бодлого боловсруулах зэрэг компанийн засаглалын асуудлыг хянаж ажиллах ба оролцогч бүх талын сонирхолд нийцсэн ил тод, тогтвортой банкны үйл ажиллагаанд чиглэл өгч, мөн хяналт тавихад шаардагдах бүтэц, процесс бүхий компаний сайн засаглалын системийг хангаж ажиллана.

Энэхүү хорооны бусад үндсэн үүрэг хариуцлага нь: (I) ТУЗ болон Гүйцэтгэх захирлын албан тушаалд тохирох хүмүүсийг нэр дэвшүүлж, үнэлгээ дүгнэлт хийж, ТУЗ-д санал болгох, (II) Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийг хянаж цалин урамшууллыг тогтоох, компанийн өөрийн хөрөнгө дээр тулгуурласан төлөвлөгөөг хянах, ТУЗ-ийн цалин урамшууллын талаар ТУЗ-д санал оруулах. КЗТШУ-ын хорооны дүрмийг 2014 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар өөрчлөн баталсан.

Гишүүд

Сабина Дзиурман, дарга
Нямтайширийн Цэлмүүн
Баатарын Батсайхан
Чулууны Ганболд
Шужуи Ирие

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХОРОО

Эрсдэлийн удирдлагын хороо нь эрсдэлтэй холбоотой бүх асуудлаар болон эрсдэлийн удирдлагаар ТУЗ-д зөвлөх, эрсдэлийг хянах, удирдах, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зэрэг асуудлыг хариуцаж ажилладаг.

Тус хороо нь эрсдэлийн удирдлагын бодлого, бизнесийн шугаманд материалаг эрсдэлийг бууруулах зохистой төлөвлөгөө, эрсдэлийн удирдлагын үр дүнтэй чиг үүрэг, эрсдэлд өртөх хязгаар, зээлийн багцын чанар, ногдол ашгийн бодлого, зээлийг батлах хязгаар, зээлийг данснаас хасалт хийх эрх мэдэл, бодлогын баримт бичигт заасан хязгаараас давсан гүйлгээ болон саналууд, холбоотой болон хамааралтай талуудтай хийх гүйлгээ зэрэг асуудлуудыг хянаж, үнэлгээ дүгнэлт өгдөг. Эрсдэлийн удирдлагын хорооны дүрмийг 2014 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар өөрчлөн баталсан.

Гишүүд

Шужуи Ирие, дарга
Майкл Мадден
Баатарын Батсайхан
Жэймс Стент (Хараат бус ТУЗ-ын гишүүн)

АУДИТЫН ХОРОО

Аудитын хороо нь дотоод хяналтын системийн бүрэн бүтэн, зөв зохистой болон үр дүнтэй байдлыг хянах хариуцлага хүлээдэг.

Хороо нь хөндлөнгийн аудиторыг томилох, дахин томилох эсвэл чөлөөлөх, дотоод аудитын ажлын гүйцэтгэл болон санхүүгийн тайлан гаргах зохицуулалтыг удирдлага дагаж мөрдөж буй байдал зэрэг асуудлыг хянаж, ТУЗ-д тодорхой санал оруулдаг. Мөн нарийн төвөгтэй, ер бусын гүйлгээ болон аудитоор орсон, ороогүй жилийн болон завсарын үеийн санхүүгийн тайлангууд, бүртгэлийн болон тайлангийн чухал асуудлууд, мэргэжлийн болон зохицуулагч байгууллагуудын дүгнэлт, тэдгээрийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөлөл зэрэг асуудлыг хянадаг. Хороо нь Ерөнхий аудиторыг томилдог ба түүний ажлын гүйцэтгэлийг хянадаг.

Аудитын хорооны дүрмийг 2011 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар өөрчлөн баталсан.

Гишүүд

Ричард Ранкен, дарга

Сабина Дзиурман

Нямтайширийн Цэлмүүн

Жэймс Стент (Хараат бус ТУЗ-ын гишүүн)

БИЗНЕСИЙН САХИЛГА БАТ БА ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

Олон нийтийн итгэл найдварыг хүлээж хөгжүүлэх нь чухал асуудал болсон банкны хувьд ёс зүйтэй соёлыг бий болгож хэвшүүлэх нь онцгой ач холбогдолтой юм. Өндөр ёс зүйн хэм хэмжээг сахих нь ХасБанкны хувьд зөвхөн хуулиар хязгаарлагдах төдий бус мэргэжлийн үндсэн шаардлага болсоор ирсэн. Банк нь өдөр тутам үнэнч шударга байх, бүрэн бүтэн цогц байдлыг хангах, ил тод болон хариуцлага хүлээх чадвартай байх зэрэг зарчим дээр тулгуурласан ёс зүйтэй зөв шийдвэр гаргахын төлөө нягт анхаарал тавин ажиллаж байна.

Банк болон ТСН-ийн бусад охин компаниуд нь хувьцаа эзэмшигчид, захирлууд болон удирдлагууд нь үлгэрлэж ажиллагсад дагаж мөрдөх ёс зүйн сахилга батын өндөр хэм хэмжээг хууль ёсны болон ёс зүйтэйгээр үйл ажиллагаандаа мөрдлөг болгосноо дахин баталгаажуулах үүднээс Сахилга бат, сонирхолын зөрчлийн дүрэм (Дүрэм)-ийг холдинг компанийн түвшинд 2011 онд баталсан. Банкны оролцогч талуудтай харьцах бизнесийн харилцаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээг энэхүү дүрэмд мөн заасан болно.

Ажилтан, албан тушаалтан:

- Монгол улсын Хөдөлмөрийн хууль ба бусал хууль тогтоомжийн үндсэн дээр бүх ажиллагсаддаа хүндлэл, итгэл үзүүлсэн урт удаан хугацааны харилцаа хөгжүүлж харьцах;
- Багаар ажиллах болон авъяас ур чадварын ялгаатай байдал, шинэ, бүтээлч бизнесийн боломж, санаачлагыг дэмжиж урамшуулж ажиллах;
- Мөрит болон ялгаварлан гадуурхлаас ангид зарчимд суурилан ажилд шинээр авах, тушаал дэвшүүлэх, цалин урамшуулал олгох зэрэг ижил тэгш нөхцөл бүрдүүлэгч ажил олгогч байх;
- Ажил дээрх сургалт, дагалдан сургалт болон бусад холбогдох сургалтын хөтөлбөрөөр хангах, сургалтанд бүх ажиллагсад хамрагдах

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ТАЙЛАН

боломжоор хангах, дгээр нь хувь хүмүүс ур чадвараа сайжруулах, хувь хүний хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад ач тустай болно;
- Ажиллагсдыг удирдлагадаа ажлаас халагдах эсвэл хариу арга хэмжээн дорх айдасгүйгээр “шүгэл үлээх” мэдэгдэл мэдээлэл хүргэхийг дэмжих;

Харилцагчид болон бизнесийн түншүүд:

- Харилцагчид болон бизнесийн түншүүдтэйгээ хүндлэл, итгэл, үнэнч шудрага байдалд тулгуурласан урт хугацааны харилцааг бий болгох;
- Амлалтаа биелүүлэхийг эрэлхийлэх замаар харилцагчдад хамгийн дээд сэтгэл ханамжийг өгөх;
- Гэрээ, бизнесийн харилцааны цэвэр ариун байдлыг хүндэтгэх, харилцан ашигтай байх үндсэн дээр гэрээний хэлэлцээрийг эрхлэх;
- Өндөр чанартай гүйцэтгэлийн стандартад тулгуурласан бизнесийн харилцааг хангах;
- Арилжааны маргааны үед, найрсаг шийдэлд хүрэхийн тулд сайн сайхан итгэлээр хэлэлцэж, харилцан буулт хийх чармайлт гаргах;
- Монгол Улсын Мөнгө угаахтай тэмцэх тухай хууль болон бусад зохицуулалтыг бүрэн дагаж мөрдөх.

Засгийн газар:

- Татвараа бүрэн бүтэн цаг хугацаанд нь төлөх;
- Засгийн газрын зохицуулалт, дүрэм журмыг дагаж мөрдөх;
- Бизнес эрхлэх лиценз, зөвшөөрөл болон засгийн газраас олгодог бусад зөвшөөрлийг хуулийн дагуу олж авсан байх;
- Засгийн газрын байгууллагуудтай “сунгасан гарын зайтай” зарчимд суурилсан зөв зүйтэй харилцааг бий болгож ажиллах;
- Засгийн газар, захиргаа эсвэл шүүхийн байгууллагуудтай харьцах үед ямар нэг өглөг, төлбөр, эсвэл хээл хахууль хүлээж авахыг хүсэх, хүлээж авахаас татгалзах;

Олон нийт, нийгэм ба орчин:

- Банк нь үйл ажиллагаа эрхэлж буй нийгэмдээ хүндлэл, итгэл, үнэнч шудрага байдалд тулгуурласан эрүүл зөв харилцааг хөгжүүлж ажиллах;
- Ажлын байр бий болгож, орон нутгийн авъяас чадавхийг хөгжүүлэх;
- Оршин буй орчиндоо банкны зээллэгээс үүсч болзошгүй аливаа зөрчил хохирлыг багасгахыг хичээж ажиллах;
- Захирал, ажилтнууд төрөл бүрийн хандивын үйл ажиллагаа болон сан, боловсролын болон ижил төстэй байгууллагуудад туслахад гар бие оролцож өөрсдийн тодорхой цагийг зориулах;
- Эдийн засгийн хувьд тогтвортой хөгжих илүү сайн нийгэм, орчинг байгуулах үйлсэд төрийн бус байгууллагуудтай бүтээлч харилцааг хөгжүүлж, чармайлт гарган ажиллах;
- Банкны үйл ажиллагаа явуулж буй нийгэмд тулгарч буй хөгжлийн тодорхой хэрэгцээ шаардлагыг тогтмол нээлттэй ярилцлагын замаар тодорхойлж ажиллах.

Ёс зүйн хэм, хэмжээ ба Сонирхлын зөрчлийн журмын хэрэгжилтийн ерөнхий хариуцлагыг ТУЗ-ийн түвшинд КЗТШ хороо, гүйцэтгэх түвшинд Ерөнхий аудитор болон хянан нийцүүлэлтийн ажиллагсад хариуцдаг.

СОНИРХОЛЫН ЗӨРЧИЛ БА НЭЭЛТТЭЙ ТАЙЛАГНАХ

Ёс зүйн хэм, хэмжээ ба Сонирхлын зөрчлийн журам нь сонирхолын зөрчлийг тодорхойлдог бөгөөд сонирхолын зөрчлийг нээлттэйгээр тайлагнаж шийдвэрлэх асуудлыг томъёолсон. Жишээ нь:

- Захирал, ажиллагсад нь өөрийн ажил үүргээ гүйцэтгэхдээ аливаа хувийн, санхүүгийн болон бусад сонирхол нөлөөлж болзошгүй тохиолдолд, түүнийгээ нээлттэйгээр тайлагнах;
- Банкнаас хийх гэж буй аливаа гүйлгээтэй захирал ямар нэг сонирхолын зөрчилтэй бол тэрхүү зөрчил болон сонирхолоо ТУЗ-ийн хурал дээр мэдэгдэж, ТУЗ тэрхүү сонирхолын зөрчил илэрсэн гүйлгээ бүхий асуудлыг авч хэлэлцэх;
- Шууд ба шууд бус сонирхол бүхий гүйлгээ, ажил үйлчилгээ, саналыг ТУЗ баталж шийдвэр гаргах үед тухайн захирлыгсанал хураалтад оролцохыг цээрлэнэ.

Нээлттэй тайлагнах журмын дагуу, ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын бүх гишүүд өөрсдийн Нээлттэй тайлагнах жилийн тайлангаа 2014 оны 12 дугаар сарын 31-нд бүрдүүлсэн.

Ил тод, нээлттэй тайлагнах байдал нь зөвхөн сайн засаглалын нэг хэсэг байхаас гадна хууль эрх зүйн зохицуулалтын шаардлага болохыг хүлээн зөвшөөрсөн Банкны ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийг мөн адил өөрсдийн эзэмшил, сонирхолыг нээлттэй тайлагнаж мэдээллэх асуудлыг сайжруулах ажилд анхаарч ажиллаж байна.

ТУЗ-ИЙН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ

Сайн засаглалын жишгийг үргэлжлүүлж, засаглалыг улам сайжруулан ажиллаж буй банкны ТУЗ нь хамтын гүйцэтгэлээ дахин нягтлах, ямар зөрчигдөж буй зүйл байвал түүнийгээ илрүүлэх, сайжруулах тодорхой зорилтуудыг дэвшүүлэх ба цаашид хэрэгжүүлэх арга хэмжээгээ тодорхойлох зэрэг өөрөө өөрийгөө үнэлэх үнэлгээг жил болгон хийж гүйцэтгэдэг. Банкны ТУЗ нь 2014 онд тус үнэлгээгээ хийсэн болно.

ТАЙЛАГНАХ БА АУДИТ

Төлөөлөн удирдах зөвлөл нь үнэн зөв Банкны санхүүгийн тайланг бэлтгэх болон холбогдох зохицуулалтын шаардлага болон хэрэглэгдэж буй нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн эсэхийг хариуцна. Банкны удирдлага нь ТУЗ-өөр батлуулахаар өргөн барьсан санхүүгийн тайланг ТУЗ-д бүрэн мэдээлэлд үндэслэсэн, үнэлгээ дүгнэлт гаргах боломжийг олгох, тайлбар мэдээллээр бүрэн хангах үүрэг хүлээдэг.

ТУЗ нь хөндлөнгийн аудиторыг тодорхой мөчлөгөөр ээлжлэн солигдож, өөрчлөгдөж байх үндэслэлээр сонгож томилохыг мөн хариуцна. 2014 онд Делойт компани нь Банкны сүүлийн 3 жилийн тайланд аудитын шалгалт хийсэн Эрнст Янг компанийн оронд Банкны хөндлөнгийн аудитороор томилогдсон билээ.

ТУЗ нь Банкны 2014 оны аудитаар баталгаажсан санхүүгийн нэгдсэн тайланг хянаж баталсан.

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ХАСBANK LLC

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

ХасБанк ХХК-ийн (цаашид Банк гэх) Гүйцэтгэх захирал Магваны Болд болон Банкны санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтан Ганзоригийн Эрдэнэбаяр бид 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал болон тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.



МАГВАНЫ БОЛД
(Гүйцэтгэх захирал)

A handwritten signature in black ink, consisting of several loops and strokes, written over a horizontal line.

ГАНЗОРИГИЙН ЭРДЭНЭБАЯР
(Санхүү хариуцсан захирал)

Улаанбаатар

Огноо: March 18, 2015

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ХасБанк ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд:

Бид ХасБанк ХХК (цаашид "Банк" гэх) -ийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан уг өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн иж бүрэн орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэн шударгаар илэрхийлэх, эдгээр санхүүгийн тайланг алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг хэмжээний зөрчилгүйгээр бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэж тогтоосон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Аудиторын үүрэг

Аудитор хийсэн аудитдаа үндэслэн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүрэгтэй. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэсэн болно. Санхүүгийн тайлан нь материаллаг үзүүлэлтийнхээ хувьд алдаа зөрчилгүй гэдэг зохих магадлагаа олж авахуйцаар аудитыг төлөвлөж гүйцэтгэх ба ёс зүйн шаардлагуудыг дагаж мөрдөхийг эдгээр стандартуудад шаарддаг.

Аудит нь санхүүгийн тайлан дахь дүн болон тодруулгыг нотлох нотолгооны зүйлсийг олж авахын тулд гүйцэтгэдэг аудитын горимуудаас бүрдэнэ. Санхүүгийн тайлан алдаа болон санаатай зальт үйлдлийн улмаас материаллагаар зөрчилтэй илэрхийлэгдэх эрсдэлд өгсөн аудиторын үнэлгээнээс хамааран аудитын горимуудыг сонгодог. Аудитор эрсдлийн үнэлгээ хийхдээ санхүүгийн тайлан бэлтгэх шударгаар тайлагнахад хэрэглэдэг дотоод хяналтыг судалдаг. Энэ нь зөвхөн тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимуудыг сонгохтой холбоотой бөгөөд аж ахуйн нэгжийн дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт өгөх зорилгогүй болно. Үүнээс гадна аудит нь удирдлагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой эсэх, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол зохистой эсэх, санхүүгийн тайлангийн ерөнхий тайлагналын байдлыг үнэлэх ажлуудаас бүрддэг.

Бидний олж авсан аудитын нотлох зүйлс нь аудиторын дүгнэлт гаргах хангалттай ба зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Дүгнэлт

Бид, Банкны 2014 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн, шударгаар илэрхийлж байна гэж дүгнэж байна.

Бусад

Банкны 2013 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн тайланг өөр аудитын компани аудитласан ба тус аудитор нь 2014 оны 03 дугаар сарын 25-нд зөрчилгүй дүгнэлт гаргасан.

Хэрэглээний хязгаарлалт

Энэхүү тайлан нь Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу зөвхөн Банкны хувьцаа эзэмшигчид зориулагдсан ба аливаа нэгэн өөр зорилго агуулаагүй болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бусад этгээдийн өмнө үүрэг хариуцлага хүлээхгүй болно.



Делоитт Онч Аудит ХХК
Улаанбаатар хот, Монгол Улс
2015 оны 3 дугаар сарын 18

НЭГТГЭСЭН ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН
2014 оны 12 дугаар сарын 31

	ТэнГэр Санхүүгийн Нэгдэл		ХасБанк	
	2014 мян.төг	2013 мян.төг	2014 мян.төг	2013 мян.төг
Хүү болон түүнтэй адилтгах орлого	249,705,126	188,247,032	238,455,847	181,022,347
Хүү болон түүнтэй адилтгах зардал	(143,153,349)	(101,603,895)	(141,046,690)	(100,332,244)
Хүүний цэвэр орлого	106,551,777	86,643,137	97,409,157	80,690,103
Хураамж ба шимтгэлийн орлого	8,149,836	5,888,041	7,690,980	5,799,626
Хураамж ба шимтгэлийн зардал	(1,281,195)	(1,035,694)	(1,019,381)	(782,369)
Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого	6,868,641	4,852,347	6,671,599	5,017,257
Арилжааны цэвэр олз	(947,224)	2,739,208	54,028	2,568,294
Үйл ажиллагааны бусад орлого - цэвэр	(4,898,835)	6,871,267	(7,832,121)	4,142,363
Үйл ажиллагааны нийт орлого	107,574,359	101,105,959	96,302,663	92,418,017
Зээлийн үнэ цэнийн бууралтын алдагдлын зардал	(30,623,431)	(9,965,146)	(29,887,298)	(9,706,640)
Үйл ажиллагааны цэвэр орлого	76,950,928	91,140,813	66,415,365	82,711,377
Үйл ажиллагааны зардал	(60,474,801)	(61,246,655)	(55,111,209)	(54,142,727)
Хойшлогдсон нөхцөлт хандивын хорогдуулга	903,878	1,323,934	903,878	1,323,934
Хараат компаний ашгаас хүртэх хувь		308,009		
Татварын өмнөх ашиг	17,380,005	31,526,101	12,208,034	29,892,584
Орлогын албан татварын зардал	(1,676,018)	(6,025,326)	(572,326)	(5,520,275)
Тайлант жилийн ашиг	15,703,987	25,500,775	11,635,708	24,372,309
Үүнээс:				
Толгой компаний хувьцаа эзэмшигчдэд	14,627,778	25,019,243		
Хяналтын бус багц эзэмшигчдэд	1,076,209	481,532		
	15,703,987	25,500,775	11,635,708	24,372,309
Бусад дэлгэрэнгүй орлого				
Гадаад үйл ажиллагааны ханшийн зөрүү, татварын дараахь байдлаар	2,733,239	4,967,017		
Нийт дэлгэрэнгүй орлого, татварын дараахь байдлаар	18,437,226	30,467,792	11,635,708	24,372,309
Үүнээс:				
Толгой компаний хувьцаа эзэмшигчдэд	16,021,730	27,552,422		
Хяналтын бус багц эзэмшигчдэд	2,415,496	2,915,370		
	18,437,226	30,467,792	11,635,708	24,372,309

НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2014 оны 12 дугаар сарын 31

	ТэнГэр Санхүүгийн Нэгдэл		ХасБанк	
	2014	2013	2014	2013
ХӨРӨНГӨ	МЯН.ТӨГ	МЯН.ТӨГ	МЯН.ТӨГ	МЯН.ТӨГ
Бэлэн мөнгө ба Монголбанкин дахь харилцах	187,784,004	238,621,284	187,780,433	238,614,870
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь				
харилцах, хадгаламж	152,010,067	132,389,522	138,422,940	121,851,611
Урвуу репо хэлцэл	152,799,124	29,991,255	152,799,124	29,991,255
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	1,327,478	636,835	1,469,087	636,835
Санхүүгийн хөрөнгө оруулалт – арилжаалах				
зориулалтаар эзэмшиж байгаа	428	458	-	-
Санхүүгийн хөрөнгө оруулалт – борлуулахад				
бэлэн	7,751,391	15,500,694	7,751,391	15,500,694
Санхүүгийн хөрөнгө оруулалт – дуусах хугацаа				
хүртэл эзэмших	211,901,791	329,582,816	211,594,397	329,582,816
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	1,358,854,987	1,069,901,579	1,313,697,656	1,029,541,294
Бусад хөрөнгө	13,216,142	10,745,612	6,602,101	4,361,822
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	10,727,557	5,105,763	10,727,557	5,105,763
Үндсэн хөрөнгө	33,232,613	31,574,782	31,241,651	29,595,235
Биет бус хөрөнгө	13,482,957	10,756,059	8,407,675	5,666,416
Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	-	-	-	-
Хойшлогдсон татварын хөрөнгө	2,390,968	1,027,166	2,321,415	1,035,981
НИЙТ ХӨРӨНГӨ	2,145,479,507	1,875,833,825	2,072,815,427	1,811,484,592
ӨР ТӨЛБӨР				
Бусад банк, санхүүгийн байгууллагын				
харилцах, хадгаламж	34,317,691	141,706,978	34,317,691	141,706,978
Репо хэлцэл	179,763,676	162,428,300	179,763,676	162,428,300
Харилцагчдын харилцах, хадгаламж	783,471,336	639,662,729	797,749,013	644,483,183
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	2,427,739	626,804	2,427,739	626,804
Худалдах опцион	2,561,913	2,226,068	-	-
Зээлээр авсан санхүүжилт	836,395,853	684,994,007	803,560,458	664,368,204
Хоёрдогч өглөг	97,925,342	58,637,886	97,925,342	58,637,886
Хойшлогдсон нөхцөлт хандив	1,622,531	1,957,277	1,622,531	1,957,277
Санхүүгийн түрээсийн өр	-	-	-	-
Бусад өр төлбөр	29,176,123	22,983,390	21,206,909	13,142,756
Орлогын албан татварын өглөг	975,634	2,205,943	401,316	1,928,160
НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,968,637,838	1,717,429,382	1,938,974,675	1,689,279,548
ГРУПП БОЛОН БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД				
НООГДОХ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ				
Энгийн хувьцаа	16,584,644	16,584,644	20,353,656	20,353,656
Хувьцааны урамшуулал	56,495,362	56,495,362	34,989,097	34,989,097
Хувьцааны урамшуулал	9,645,635	9,579,293	10,531,368	10,531,368
Хуризмтлагдсан ашиг	73,474,370	58,912,934	67,966,631	56,330,923
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	4,175,948	2,781,996	-	-
Толгой компаний хувьцаа эзэмшигчдэд	160,375,959	144,354,229	133,840,752	122,205,044
Хяналтын бус багц эзэмшигчдэд	16,465,710	14,050,214	-	-
НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	176,841,669	158,404,443	133,840,752	122,205,044
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	2,145,479,507	1,875,833,825	2,072,815,427	1,811,484,592



Эх дэлхий | Эрдэнэт хүмүүн | Эрүүл ашиг

Улаанбаатар хот, СБД, Ерөнхий Сайд
Амарын гудамж, ХасБанкны Төв Байр,
Шуудангийн хайрцаг 20А, 72
Утас: +976 (11) 75771888
Факс: +976 (11) 328701
Имэйл: info@xacbank.mn
SWIFT: [caxbmhub](https://www.xacbank.mn)
www.xacbank.mn